



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ТӨСЛИЙН ЦАР ХҮРЭЭ ӨРГӨЖИН
ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭЖ
ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ
ШИНЭ БУУДАЛ АШИГЛАЛТАД ОРОХ
ХУГАЦАА ХОЙШИЛСОН БАЙНА**

2020 оны 4 дүгээр сар

**АУДИТЫН СЭДЭВ: ХӨШИГИЙН ХӨНДИЙН
ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДЛЫН
ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудлын төслийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.


2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Иргэний нисэхийн ерөнхий газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Иргэний нисэхийн ерөнхий газарт тус тус зөвлөсүгэй.

4. Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т даалгасугай.

5. Аудитын тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Хишигтогтох/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



Монгол Улсын Ерөнхий аудиторов
2020 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн
А/35 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудлын
төслийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар
өгсөн албан шаардлагын жагсаалт**

/сая төгрөг/			
№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
1	Төслийн хүрээнд худалдан авсан тоног төхөөрөмж, машин механизмыг хөрөнгийн бүртгэлд бүртгэх тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолыг үндэслэн гал унтраах авран хамгаалах ангийн штаб командын машин, эмнэлгийн машиныг тус тус давхардуулан тусгасан, Хөвсгөл аймгийн Хэнгэрэгтэй ажиглалтын байгууламж, Увс аймгийн Улаангом нисэх буудалд тус тус шилжүүлэн суурилуулсан хэт богино долгионы 2 ширхэг станцыг бүртгэлд тусгаагүй байна. Гал команд аврах ангийн штаб командын зориулалттай автомашиныг 2017 онд ИНЕГ-ын тэргүүн дэд дарга, 2018-2019 онд ИНЕГ-ын Нисэх буудлуудын удирдах газрын дарга нар тус тус албан хэрэгцээнд ашигласан, хэт богино долгионы 2 ширхэг станцыг төслийн зориулалт бус байршилд шилжүүлэн ашигласан байна.	03/189	1,834.6
	Нийт дүн		1,834.6



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товьёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	7
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛСОН БОЛОВЧ ТЭЗҮ-Г ТУСГАЙЛАН БОЛОВСРУУЛААГҮЙ БАЙНА	8
Төслийн анхны зорилго “Чингис хаан” ОУНОБ-ыг өргөжүүлэх бус буудлын хэвийн болон аюулгүй үйл ажиллагааны орчныг сайжруулахад чиглэгдсэн байв	8
Дотоодын ачаа тээврийн урсгалыг зорчигчдын өсөлттэй уялдуулан тооцсон ч таамагласан хэмжээнд хүрч чадаагүй байна	8
ОУНОШБ-ыг иж бүрэн, цогцоор барих чиглэл баримталсан нь САПРОФ судалгааны дүн, Ерөнхий төлөвлөгөөнөөс зөрүүтэй байх үндэслэл болсон байна	9
ОУНОШБ-ын байршлыг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтэд үндэслэн сонгожээ	10
Нэмэлт зээл авснаар ОУНОШБ ашиглалтад орох хугацаа хойшилж төслийн эдийн засгийн үр өгөөж буурсан байна.....	13
БҮЛЭГ 2. ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БОЛОВЧ ГЭРЭЭНД ЯПОН УЛСЫН ГҮЙЦЭТГЭГЧ КОМПАНИ БАЙХААР ЗААСНААС СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД 2 ЖИЛ ГАРУЙ ХУГАЦАА ЗАРЦУУЛАГДЖЭЭ	14
Зээлийн гэрээ олон улсын гэрээний зарчимд нийцэж буй хэдий ч гэрээний бүрдэл, албан орчуулга хангалтгүй, гэрээнд тусгасан дагаж мөрдөх дүрэм, журам, баримт бичгийг бүрэн хавсаргаагүй байна.....	14
Төслийн зээл нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй боловч эргэн төлөлтөд их хэмжээний ханшийн зөрүү үүсэх эрсдэлтэй байна.	18
Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт ЖАЙКА-ийн журмын дагуу явагдсан хэдий ч зээлийн гэрээнд Япон улсын гүйцэтгэгч компани байхаар зааснаас сонгон шалгаруулалтад 2 жил гаруй хугацаа зарцуулжээ	19
Туслан гүйцэтгэгчдийн сонгон шалгаруулалт Самсунг Си Энд Ти”, “Эм Си Эс Проперти” ХХК-ийн дотоод журмын дагуу явагдсан нь өрсөлдөөн олон нийтэд нээлттэй, ил тод явагдах боломжийг хязгаарласан байна	22
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ЦАР ХҮРЭЭ ӨРГӨЖИЖ, ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДСЭН, НЭМЭЛТ БАРИЛГЫН АЖЛУУДААС ТӨСЛИЙН ХУГАЦАА СУНГАГДСАН, ЗАХИАЛАГЧИЙН ҮҮРЭГ, ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙЖЭЭ. .	25
Захиалагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	25
Төсөвт өртөгт үнэлгээ, магадлал хийлгэж бодит өртгийг баталгаажуулаагүй байна.....	30
Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнийн саналын шууд бус зардал нь тооцоолсон төсөвт өртгөөс 2.7 дахин их байжээ	31
Зарим ажлыг нэмэлт зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай гэж үзэх боломжгүй байна.....	32
Төлөвлөгөөнд тусгагдаагүй агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга, барьж эхэлсэн, Монголын талын хөрөнгөөр барьж буй барилгын ажил удааширсан, концессын гэрээ 2019 оны 7 дугаар сард байгуулсан зэргээс ОУНОШБ үйл ажиллагаа явуулах хугацаа хойшилсон байна.....	37
Төслийн хүрээнд нийлүүлсэн авто машины үнэ зах зээлийн үнээс 4.9 дахин өндөр, зарим хөрөнгийг давхардуулан бүртгэсэн байна	39
Төслийн хүрээнд бараа материал, тоног төхөөрөмжийг тусгайлсан эрх зүйн зохицуулалтагүйгээр 15.0 тэрбум төгрөгийн НӨАТ, 15.1 тэрбум төгрөгийн Гаалийн албан татвараас чөлөөлсөн байна.....	41
ОУНОШБ-ын менежментийн концессын гэрээнд татвар, ногдол ашиг, концессын төлбөр төлөхөөр заажээ	43
Төслийн хэрэгжилтэд тавих захиалагчийн болон дотоод хяналт бүрэн хэрэгжээгүй байна	47
ОУНОШБ-ыг түшиглэн хот байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна	50
Холбогдох байгууллагын санал:	51
Саналд өгсөн тайлбар:	59
ДҮГНЭЛТ:	61
ЗӨВЛӨМЖ:	62
ХАВСРАЛТУУД:.....	63



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
АӨЗ	Ашиглалтын өмнөх захиргаа
АӨУХ	Ашиглалтын өмнөх удирдах хороо
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ГТН	Гэрээний тусгай нөхцөл
ГХБГЗЗГ	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЗТБХБС	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗТС	Зам тээврийн сайд
ЗТЯ	Зам, тээврийн яам
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИКАО	International Civil Aviation Organization буюу Олон улсын иргэний нисэхийн байгууллага
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЗД	Нийслэлийн Засаг Дарга
НОБ	Нисэх онгоцны буудал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУНОБ	Олон улсын нисэх онгоцны буудал
ОУНОШБ	Олон улсын нисэх онгоцны шинэ буудал
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны туслалцаа
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ҮХД	Үерийн хамгаалалтын далан
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭЗХС	Эдийн засгийн хөгжлийн сайд
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЯОУХАБ	Японы олон улсын хамтын ажиллагааны банк



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Судалгааны тооцоолол, бодит гүйцэтгэл	9
Хүснэгт 2	Төслийн хүрээнд баригдсан барилга, байгууламжийн тоо	10
Хүснэгт 3	Газар эзэмшүүлэх, тусгай хэрэгцээнд авах шийдвэрүүд	11
Хүснэгт 4	Газрын давхцал бүхий нэгж талбарын тоо	12
Хүснэгт 5	Хүчин чадлын харьцуулалт	12
Хүснэгт 6	Зээлийн нөхцөлийн харьцуулалт	14
Хүснэгт 7	Ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дүн	23
Хүснэгт 8	Ажил, үйлчилгээ худалдан авсан гэрээний тоо	24
Хүснэгт 9	Зөвлөх үйлчилгээний гэрээ дүгнэсэн судалгаа	27
Хүснэгт 10	Зөвлөх үйлчилгээний гэрээний мэдээлэл	30
Хүснэгт 11	Барилгын ажил гүйцэтгэх гэрээний мэдээлэл	
Хүснэгт 12	САПРОФ судалгаа болон Анхан шатны зураг төслийн тооцооны зөрүү	31
Хүснэгт 13	УИХ-ын холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлсэн зээлийн дүн	
Хүснэгт 14	Нэмэлт зээлийн дүнгийн задаргаа	34
Хүснэгт 15	ИНЕГ-ын татварын дараах цэвэр ашиг	34
Хүснэгт 16	Гүйцэтгэл баталгаажуулах үе шатны хоногийн хуваарилалт	36
Хүснэгт 17	Зээлийн хөрөнгийн хуваарилалт	37
Хүснэгт 18	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын хүчин чадал, төсвийн харьцуулалт	38
Хүснэгт 19	Төслийн хүрээнд татвар хураамжийн талаар холбогдох гэрээнд тусгасан байдал	41
Хүснэгт 20	2013-2016 оны импортын мэдээ	42
Хүснэгт 21	Агаарын хөлгийн мөстөлтийн эсрэг шингэн цацах автомашин	42

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1		21

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОУНОШБ-ын бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр	7
Дүрслэл 2	2012-2017 оны нислэгийн саатлын мэдээ	8
Дүрслэл 3	Зөвлөхийн тооцоолсон болон Гүйцэтгэгчээс ирүүлсэн үнийн саналын зөрүү	32
Дүрслэл 4	Санхүүжилтийн үе шат	35
Дүрслэл 5	Татвараас чөлөөлөх үе шат	41

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Байр зүйн зурагт дүрслэгдсэн газар зүйн нэр болон ОУНОБ-ын байршлын зураг	53
Хавсралт 2	Төслийн Удирдах хороо 2009-2018 оны хооронд хуралдсан хуралдааны судалгааны нэгтгэл	54
Хавсралт 3	Улсын комиссын үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлийн нэгтгэл судалгаа	55
Хавсралт 4	Нэмэлт хөрөнгө гарган зайлшгүй хийх шаардлагатай 20 ажлын материалын үнийн урьдчилсан тойм судалгааны нэгтгэл	55
Хавсралт 5	2017 онд ажилласан Улсын комиссын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын актын нэгтгэл	56
Хавсралт 6	Төслийн хүрээнд чөлөөлөгдсөн нийт татварын мэдээ	58



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/45 дугаар тушаалаар батлагдсан “2019 онд Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв. Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааны хүрээнд “Хөшигийн хөндийн Олон Улсын нисэх онгоцны буудал барих төслийн хэрэгжилт”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын гол зорилтыг хангахын тулд дараах дэд зорилт, чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ <i>Төслийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр ашгийг зөв тооцоолж, төлөвлөсөн эсэх;</i> ➤ <i>Зээлийн гэрээ нь олон улсын гэрээний зарчимд нийцэж, зээлийн гэрээний дагуу сонгон шалгаруулалт явагдсан эсэх;</i> ➤ <i>Төслийг ТЭЗҮ болон гэрээний дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны буудал барих төслийн гэрээ хэлэлцээр, САПРОФ судалгаа, холбогдох байр зүйн болон геотехник, инженер геологийн дүгнэлт, төслийн ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, барилгын ажлын төсөв, гүйцэтгэл, холбогдох судалгаа, санхүүгийн баримт материал, захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч талуудын гэрээний үүргийн хэрэгжилттэй холбоотой баримт, материал болон дотоод хяналт шалгалтын тайлан дүгнэлтийг дараах төрийн байгууллага, нэгжийн хүрээнд хамруулан авч үзэв. Үүнд: ▪ Зээлдэгч, Захиалагч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Иргэний нисэхийн ерөнхий газар болон төрийн байгууллагууд Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Улсын бүртгэл, оюуны өмчийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар ▪ Зээлдүүлэгч, санхүүжүүлэгч: ЖАИКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар ▪ Гүйцэтгэгч: Төслийн үйл ажиллагаанд гэрээгээр оролцсон Монгол улсын болон гадаад улсын иргэн, хуулийн этгээд: • Зөвлөх: Япон улсын Azusa Sekkei/Oriental Consultants Global JV хамтарсан Зөвлөх • Ерөнхий гүйцэтгэгч: Mitsubishi Chiyoda Joint Venture, • Ерөнхий туслан гүйцэтгэгч: БНСУ-ын “Самсунг Си энд Ти” компани, “Эм Си Эс Проперти” ХХК болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчид. Аудитад Мон-Пи 8, 12 зээлийн хөрөнгийн зарцуулалтыг хамруулсан болно.
Аудитын хязгаарлалт	Төслийн хүрээнд баригдсан барилга, байгууламжийн төсөвт өртөг, ажлын гүйцэтгэл, чанар байдалд мэргэжлийн зөвлөх, шинжээчийн



**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл үүссэн тул уг асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон зээл олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир удирдаж, аудитын менежер Л.Эрдэнэчулуун, З.Ариунзаяа нар чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Хишигтогтох, аудитор М.Наранжаргал, М.Гүнжмаа, Ж.Мөнхбилгүүн, хөндлөнгийн зөвлөх шинжээчээр олон улсын эрх зүйч Г.Ганзориг нар гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр, нэмэлт горим гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг ОУНОШБ-ын менежментийн концессын гэрээ байгуулагдсантай холбогдуулан 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр тус тус батлуулав.

Аудитын талбарын ажлыг 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийн хооронд, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 12 дугаар сарын 13-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Хүндрэл бэрхшээл

Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор Монгол Улс Япон Улсын Засгийн газар хооронд 2008 оноос байгуулсан зээлийн гэрээ байгуулах үйл явцаас эхлүүлэн Монголын талын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагуудын хариуцсан мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажиллаагүй, зарим баримт материал архивд бүрэн хадгалагдаагүйгээс шаардлагатай баримт материалыг аудитын баг авахад хугацаа зарцуулж байв.

ҮАГ-ын зүгээс ЖАИКА-д төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл авах, уулзалт зохион байгуулах тухай хүсэлтийг удаа дараа хүргүүлсэн боловч шалгадагч байгууллагад хамрахгүй үндэслэлээр мэдээлэл гаргаж өгөх, уулзалт зохион байгуулахаас татгалзсан болно.

ЗТХЯ, СЯ-ны холбогдох мэргэжилтэн аудитад шаардлагатай баримт материалыг цаг хугацаанд нь ирүүлээгүй, төслийн Зөвлөх, ерөнхий болон туслан гүйцэтгэгч компаниудын баримт материал гадаад хэл дээр боловсруулагдсан, монгол хэл дээрх албан ёсны орчуулгагүй байсан нь аудитын хугацаанд сөргөөр нөлөөлж байв.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Чингис Хаан” ОУНОБ нь хуучин ЗХУ-ын цэргийн нисэх буудал байсныг 1956 онд шилжүүлэн Цэрэг ба Нийгмийг Аюулаас хамгаалах Хэргийг эрхлэх Сайдын 1957 оны 107 дугаар тушаалаар Улаанбаатар хотын “Буянт-Ухаа” нисэх онгоцны төв буудлыг байгуулж байжээ. Тус буудал нь Их Монгол Улсын 800 жилийн ойг тохиолдуулан 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс Чингис хаан ОУНОБ нэртэй болжээ. Буудлын хөөрч буух зурвасын өргөтгөлийг 1960-1961 онд мөн хийж, 1986 онд ЗХУ-ын /тухайн үеийн/ тусламжаар Зорчигч үйлчилгээний барилга шинээр барьж ашиглалтад оруулсан байна.

АХБ, ЕСБХБ, ЯОУХАБ-ны санхүүжилтээр Чингис хаан ОУНОБ-д тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар судалгааг 1992-2007 онд хийж байжээ.


МУЗГ нь Улаанбаатар хотын ОУНОШБ барих төслийг хэрэгжүүлэх зорилгоор ЯОУХАБ-тай 2008 онд 28.8 тэрбум иений Мон-Пи8, ЖАИКА-тай 2015 онд 36.8 тэрбум иений Мон-Пи12 нийт 65.6 тэрбум иений нэн хөнгөлөлттэй зээлийн гэрээ байгуулан төслийн зөвлөх үйлчилгээг Япон Улсын “Азуса Секкей-Ориентал Консалтантс” хамтарсан түншлэл үзүүлж, Ерөнхий гүйцэтгэгчээр “Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэл ажиллаж байна.

Төслийн хүрээнд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар зээлийн хөрөнгийн 92.2 хувь буюу 60.5 тэрбум иенийг ашиглаж, төсөл нь 2020 оны 2 дугаар улиралд дуусахаар үргэлжилж байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс төслийн үндсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг 2017 оны 1 дүгээр сард, нэмэлт барилга байгууламжийг 2018 оны 7 дугаар сард хүлээн авахаар ажилласан байна.

ОУНОШБ-д Мон-Пи8, 12 зээлээс 1,148.6 тэрбум, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хурдны замын төсөлд 347.0 тэрбум, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 64.2 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлж, Гааль болон НӨАТ-ын татвараас 98.7 тэрбум төгрөгийг чөлөөлсөн байна. Үүнийг эх үүсвэр тус бүрээр харуулбал,

Дүрслэл 1. ОУНОШБ-ын бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: ЗТХЯ, СЯ, ГЕГ, ТЕГ



БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛСОН БОЛОВЧ ТЭЗҮ-Г ТУСГАЙЛАН БОЛОВСРУУЛААГҮЙ БАЙНА

Төслийн анхны зорилго “Чингис хаан” ОУНОБ-ыг өргөжүүлэх бус буудлын хэвийн болон аюулгүй үйл ажиллагааны орчныг сайжруулахад чиглэгдсэн байв

1.1 АХБ-ны санхүүжилтээр 1992 онд хийгдсэн судалгаагаар “Буянт-Ухаа /тухайн үеийн нэрээр/ ОУНОБ нь 2000 он хүртэл олон улс, дотоодын нислэгийн болон агаарын тээврийн ачааллыг даах боломжтой боловч 2000 оноос хойш нисэх буудлын аюулгүй ажиллагаа, ашиглалт үйлчилгээний нөхцөл байдлын улмаас шинээр ОУНОБ барих хэрэгцээ шаардлага үүсэх магадлалтай” гэж дүгнэсэн байна.


1.2 Мөн Европын сэргээн босголт, хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд 2003 онд хийгдсэн судалгаагаар “Буянт-Ухаа” ОУНОБ-ын зурвасыг ИКАО-ын стандартад нийцүүлэх, нислэгийн зурваст саад үүсгэж буй уул, толгодын оройг авч хаях замаар 2 чиглэлтэй болгон өөрчлөх зэрэгт их хэмжээний хөрөнгө шаардлагатай тул шинээр ОУНОБ барих нь зүйтэй” гэж дүгнэжээ. Тухайлбал,

- Салхины урсгал, утаа манан зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр нислэгүүд цуцлагдах тохиолдол олон гарах;
- Олон улсын нислэг үйлдэж буй агаарын тээврийн байгууллагуудын аюулгүй ажиллагаанд мөрдөгдөх ИКАО-ын зарим стандартыг хангахгүй;
- Нислэгийн зурвасын замын налуу байдал нь 1.5 градусаас хэтрэхгүй байх ёстой боловч 2.1 градус хүрсэн;
- Аэродромын ашиглалтын коэффициент хамгийн багадаа 95% байх шаардлагад нийцэхгүй байгааг дурджээ.

1.3 ЯОУХАБ-ны санхүүжилтээр 2007 онд хийгдсэн Төсөл боловсруулах тусгай туслалцааны тайлан /цаашид САПРОФ гэх/ судалгаагаар өмнөх судалгаануудаар тодорхойлсон хүндрэл бэрхшээлийг хянан үзэж, хөөрч, буух зурвас, газарзүйн байршил зэргээс шалтгаалсан хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаа явуулж болох ОУНОБ-ыг найдвартай, аюулгүй, тохиромжтой байдлаар барьж байгуулах нь зөв шийдэл гэж үзжээ.

1.4 ИНЕГ-аас авсан мэдээллээс үзэхэд 2012-2017 онд 3190 удаагийн нислэгийн саатал бүртгэгдсэний 16 хувь нь техникийн, 84 хувь нь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж үүссэн нь дээр дурдсан судалгаагаар тодорхойлсон хүндрэл бэрхшээл бодитой байсныг харуулж байна.

Дүрслэл 2. 2012-2017 оны нислэгийн саатлын мэдээ



Эх сурвалж: ИНЕГ

Дотоодын ачаа тээврийн урсгалыг зорчигчдын өсөлттэй уялдуулан тооцсон ч таамагласан хэмжээнд хүрч чадаагүй байна

1.5 САПРОФ судалгааны тайланд зорчигч, ачаа тээврийн урсгалыг Монгол Улсын статистик мэдээнд үндэслэн үзүүлэлт хоорондын хамаарлыг регрессийн загварыг ашиглаж 2024 он хүртэлх таамаглалыг гаргасан байна. Таамаглалд 2024 онд жилийн зорчигчийн тоо 2.3 сая хүрэхээр тооцоолсноос 2018 он хүртэлх гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна.



1.6 Судалгааны таамаглал болон бодит гүйцэтгэлийн зөрүү бага байгаагаас үзэхэд зорчигч тээврийн урсгалыг үндэслэлтэй тооцоолсон гэж үзэхээр байна.

1.7 Харин ачаа тээврийн урсгалыг зорчигчдын өсөлттэй уялдуулан тооцоолсноос бодит гүйцэтгэлээр таамагласан үр дүнд хүрээгүй байна.

1.8 Энэ нь нэг талаас авто тээврийн өртөг хямд, агаарын тээвэрлэлтийн тариф өндөр байгаагаас уул уурхайн чиглэлийн тээвэрлэлтээс бусад орон нутгийн нислэгийн эрчим буурснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Судалгааны тооцоолол, бодит гүйцэтгэл

Он	Зорчигчийн урсгал /мян.зорчигч/			Ачаа тээврийн урсгал /мян.тн/		
	Таамаглал	Гүйцэтгэл	Зөрүү	Таамаглал	Гүйцэтгэл	Зөрүү
2005	471.3	479	7	3,666	2,344	(1,322)
2010	753	671	(82)	5,800	3,862	(1,938)
2014	1101	1,019	(82)	8,200	4,955	(3,245)
2015	1203	956	(247)	8,900	4,212	(4,688)
2016	1305	1,023	(282)	9,600	4,409	(5,191)
2017	1414	1,252	(162)	10,300	5,022	(5,278)
2018	1529	1,422	(107)	11,100	5,339	(5,761)
2019	1651			11,900	-	

Эх сурвалж: Төсөл боловсруулах тусгай туслалцааны тайлан, ИНЕГ-ын Агаарын тээврийн бодлого, төлөвлөлтийн газар

ОУНОШБ-ыг иж бүрэн, цогцоор барих чиглэл баримталсан нь САПРОФ судалгааны дүн, Ерөнхий төлөвлөгөөнөөс зөрүүтэй байх үндэслэл болсон байна

1.9 ЯОУХАБ Улаанбаатар хотын ОУНОШБ-ыг барихад шаардлагатай хөрөнгийн хэмжээг тогтоох зорилгоор өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн 2006 оны 11 дүгээр сараас 2007 оны 4 дүгээр сар хүртэл Төсөл боловсруулах тусгай туслалцааны тайлан-САПРОФ судалгаа боловсруулсан байна.

1.10 САПРОФ судалгаа нь АХБ-ны 1993 оны судалгаа болон ЕСБХБ-ны санхүүжилтээр 2003 онд боловсруулагдсан “Иргэний агаарын тээврийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г дахин хянан үзэх, шинэ ОУНОШБ барих төслийн цар хүрээ, хэрэгцээ шаардлага зэргийг тодорхойлох зорилгоор хийгдсэн байна.

1.11 Төслийн саналыг анх боловсруулан зээлийн хэлэлцээр байгуулагдахад ОУНОШБ-ыг одоогийн Чингис хаан ОУНОБ-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчилж өргөжүүлэх зорилт тавиагүй, харин нислэгийн саатал үүсгэх, нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх газарзүйн хязгаарлагдмал байрлал, арын салхи, хотын утаатай холбоотой үзэгдэх орчин муудах зэрэг нөхцөл байдлыг арилгах үндсэн зорилготой байжээ.

1.12 Харин Azusa Sekkei/Oriental Consultants Global хамтарсан түншлэл/цаашид “Зөвлөх” гэх/ зураг төслийг боловсруулахдаа ЗТХЯ, ИНЕГ зэрэг холбогдох талуудын санал хүсэлтийг хүлээн авч төлөвлөлтдөө тусган ажилласан бөгөөд Монголын тал бүрэн цогц нисэх буудлыг төлөвлөх зорилгыг эрхэмлэн ажилласан нь САПРОФ судалгааны төлөвлөлтөөс зөрүүтэй байх шалтгаан болсон байна.

1.13 Зөвлөх нь 2009 оны 8 дугаар сараас анхан шатны зураг төслийн ажлыг эхлүүлэн 12 дугаар сарын 26-ны өдөр Сайдын зөвлөлийн хурлаар оруулж, 12 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газарт танилцуулсан байна. Ерөнхий төлөвлөгөөг ЗТБХС-ын 2010 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 01 дүгээр тушаалаар баталж, эх зургийг зөвшөөрсөн байна.



1.14 Төслийн хүрээнд 2019 оны оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 89 барилга байгууламж баригдсанаас 28 нь САПРОФ судалгаанд төлөвлөгдсөн, 61 нь Ерөнхий төлөвлөгөөнд тусган шинээр нэмж баригдсан байна.

1.15 ТХН-ээс ГХБГЗЗГ-т 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаар албан бичгээр Ерөнхий төлөвлөгөө, үндсэн барилга байгууламжийн эх загвар зурагт магадлал хийхийг хүссэний дагуу ерөнхий дүгнэлтийг 2011 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 2/1498 дугаар бичгээр хүлээн авч, саналыг зураг төсөлд тусган ажилласан байна.

Хүснэгт 2. Төслийн хүрээнд баригдсан барилга, байгууламжийн тоо

Барилга байгууламжийн нэр	Тоо		
	САПРОФ-оор төлөвлөсөн	Төлөвлөөгүй	Нийт
Үндсэн барилга байгууламж	7	32	39
Аэродромын барилга байгууламж	8	2	10
Гадна инженерийн шугам сүлжээ	8	2	10
Нэмэлт гэрээгээр баригдсан барилга байгууламжууд	2	11	13
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга байгууламжууд	3	4	7
Нэмэлт гэрээгээр болон улсын төсвөөр баригдаж байгаа барилгыг холбосон шугам сүлжээ		10	10
НИЙТ	28	61	89

Эх сурвалж: Төсөл хэрэгжүүлэгч нэгж

Техник, эдийн засгийн үндэслэлийг тусгайлан боловсруулаагүй, төслийг судалгааны тайланд үндэслэн хэрэгжүүлж иржээ

1.16 Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль /2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Өрийн удирдлагын тухай хуулиар хүчингүй болсон/-ийн 5 дугаар зүйлийн 5.1¹, 12 дугаар зүйлийн 12.1.1² дэх заалтад салбарын яам салбар, орон нутгийн хэмжээнд гадаадын зээлээр хэрэгжүүлэх төсөл, ТЭЗҮ-г боловсруулж гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заажээ.

1.17 Гэвч ЗТХЯ нь ТЭЗҮ-г хариуцан боловсруулахгүйгээр энэхүү том бүтээн байгуулалтын ажлыг судалгааны тайланд үндэслэн хэрэгжүүлж Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн дээрх заалтуудыг зөрчиж, баримталж ажиллаагүй байна.

1.18 Албан ёсны батлагдсан ТЭЗҮ байхгүйгээс төслийн хэрэгжилтийн явцад анхны төлөвлөлтөөс их хэмжээний өөрчлөлт орж, төлөвлөгдөөгүй барилга байгууламжууд баригдсан нь санхүүжилт нэмэгдэх үндэслэл болсон байна.

ОУНОШБ-ын байршлыг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтэд үндэслэн сонгожээ

1.19 АХБ-ны санхүүжилтээр хийгдсэн судалгаанд ИНЕГ-аас санал болгосноор ОУНОБ барих боломжтой 7 байршилд олон улсад мөрддөг нисэх буудлын байршлын шалгуурт үндэслэн судалжээ. Эдгээр 7 байршлаас шалгуурыг нийцсэн дараах 2 байршлыг сонгон нарийвчилсан судалгаа хийсэн байна. Үүнд:

- Налайх дүүргийн цэргийн нисэх онгоцны буудал;
- Төв аймгийн Зуунмод орчмын байршил.

1.20 Уг нарийвчилсан судалгаа болон ЕСБХБ-ны техник туслалцаатай хийгдсэн судалгаагаар Төв аймгийн Зуунмод орчмын байршил нь дараах үзүүлэлтээр хамгийн боломжит хувилбар гэж үзжээ. Үүнд:

- Нислэг үйлдэхэд саадгүй байршилтай
- Өргөтгөл хийх боломж бүхий харьцангуй тэгш талбайтай
- Хөрсний цэвдэггүй
- Улаанбаатар хотод ойр байршилтай /48 км орчим/

¹ Гадаадын зээлийн талаарх бодлого, дунд хугацааны хөгжлийн стратеги, хэтийн чиглэлд нийцүүлэн тухайн салбар, орон нутгийн хэмжээнд гадаадын зээлээр хэрэгжүүлэх төслийг боловсруулах, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтийг тухайн салбарын яам хариуцан боловсруулж, гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

² гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үндэслэл, тооцоо, судалгаанд техник, эдийн засгийн тооцоо, дүн шинжилгээ хийх.



1.21 САПРОФ судалгаагаар Төв аймгийн Зуунмод орчмын байршлыг харьцангуй тэгш гадаргуутай ОУНОШБ барихад тохиромжтой бөгөөд уг байршилд байгаль орчны мониторингийн хөтөлбөр, геотехник, газар хөдлөлт, гүний болон хөрсний ус зэрэгт нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай гэж үзжээ.

1.22 ИНЕГ-аас 2006-2007 онд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, усны эх үүсвэр гүний усны гидрогеологи, газар хөдлөлтийн аюулгүй байдлын үнэлгээ хийлгэсэн бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш Зөвлөх байр зүйн зураглал, усан хангамжийн эх үүсвэрийн нэмэлт судалгаа болон бүтээн байгуулалтын ажил хийгдэх талбайн барилга байгууламж тус бүрээр геотехникийн судалгааг хийлгэсэн байна.

1.23 “Найчрал Састайнэблэ” ХХК-ийн 2015, 2016 оны Байгаль орчны мониторингийн тайланд төслийн талбайг хашаалсан идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа боловч туулай, үнэг, хярс, бор шувуу, шонхор зэрэг амьтад элбэг тохиолдож байгаа талаар дурдсан бөгөөд энэ нь нислэгийн аюулгүй үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул Иргэний нисэхийн багц дүрэмд заасан мал, амьтан, шувууны аюулаас сэргийлэх үйл ажиллагааны горим, арга зүйн дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.24 ГХБГЗЗГ-аас 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 02/784 дугаар албан бичгээр ирүүлсэн байршлын зургаас үзэхэд ОУНОШБ нь Хөшигийн хөндийн баруун талд, Бөхөгийн хөндийн зүүн хойд талд Тахилт толгой орчимд байршиж байна. /Зургийг хавсралт 1-д үзүүлэв/

ОУНОШБ-ыг ашиглалтад оруулахад газар чөлөөлөлтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна

1.25 МУЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам” дагаж мөрдөөгүйгээс өнөөг хүртэл газрын маргаантай, давхцалтай асуудлууд шийдвэрлэгдээгүй байгаа нь ИНЕГ-ын даргын 2010 оны А/245 тоот тушаалаар батлагдсан “Аэродромд тавигдах шаардлага”-ын 7 дугаар бүлэг Аэродром орчмын газар ашиглалт, аюулгүйн бүс” шаардлага³ зөрчигдөж байна

1.26 Мөн МУЗГ, орон нутгийн захиргааны байгууллагаас 2006-2017 онд ОУНОШБ-ын байршилтай холбоотой дараах газар эзэмшүүлэх, тусгай хэрэгцээнд авах шийдвэрүүд гаргасан байна. Үүнд:

Хүснэгт 3. Газар эзэмшүүлэх, тусгай хэрэгцээнд авах шийдвэрүүд

№	Шийдвэр	Огноо	Дугаар	Хэмжээ	Шийдвэрийн утга
1	Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын захирамж	2006.09.25	108	1200 га	Бөхөгийн хөндийд нисэх онгоцны буудлын зориулалтаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 60 жилийн хугацаатай газар эзэмшүүлэх
2	МУЗГ-ын тогтоол	2010.06.02	140	12084.9 га	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах “Олон улсын нисэх онгоцны буудал”-ын нутаг дэвсгэрт орших газрыг тусгай хэрэгцээнд авч хил заагийг тогтоох
3	МУЗГ-ын тогтоол	2016.03.14	154		Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах “Олон улсын нисэх онгоцны буудал”-н нутаг дэвсгэрт орших газрыг тусгай хэрэгцээнд авч хил заагийг өөрчлөн тогтоох
4	МУЗГ-ын тогтоол	2017.03.29	105	1200 га	МУЗГын 2010 оны 140 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Тусгай хэрэгцээний газар /Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Хөшигийн хөндий Олон улсын нисэх онгоцны шинэ буудал/-аас ИНЕГ-т 1200 га газар эзэмшүүлэх

Эх сурвалж: www.legalinfo.mn

³ 7.3.1.3 Аэродром, нисэх буудлын орчимд байгуулсан барилга байгууламж, газар тариалан, мал аж ахуй, үйлдвэрлэл, мал нядалгааны зориулалтаар ашиглуулахаар олгосон газар, зориулалтын бус ашиглаж байгаа газрууд нь иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх бол дээрх төрлийн зориулалтаар олгогдсон газрын зөвшөөрлийг цуцлах, объектыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, нисэх буудлын орчимд шинээр газар олгох үйл ажиллагаанд тухайн сум, дүүргийн засаг даргатай хамтран ажиллана.



1.27 Засгийн газрын тогтоолоор газрыг тусгай хэрэгцээнд авахдаа Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам”-ын 14⁴ дэх заалтыг хэрэгжүүлээгүй, олгосон тусгай хэрэгцээний 12,084.9 га газарт 2019 оны 10 дугаар сарын байдлаар 24 нэгж талбар давхцалтай хэвээр байгаа тул газрын давхцалыг арилгах шаардлагатай байна.

1.28 Үүнээс Засгийн газрын тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан газраас Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын захирамжаар 2012-2015 онд нийт 909.7 га талбай бүхий 11 нэгж талбарыг иргэн, хуулийн этгээдэд олгосон байна.

Хүснэгт 4. Давхцуулан олгосон газрын мэдээлэл

№	Газар эзэмшигч	Газрын хэмжээ	Газар олгосон огноо	Газар олгох үндэслэл /Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын/
1	Г.Балжинням	6 га	2015.05.25	2015 оны 05 дугаар сарын 25-ны А/199 тоот захирамж /Т.Гансүх/
2	Гоёын толгой ХХК	1 га	2013.01.25	2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 923 тоот захирамж
3	Л.Дашдондог	0.67 га		2013 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 365 дугаарт захирамж /Т.Гансүх/
4	Кичара ХХК	10 га	2012.09.11	2012 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 540 дугаарт захирамж /Ц.Мэндсайхан/
5	Моодунхаан групп ХХК	270 га	2015.01.16	2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 293 тоот захирамж
6		60 га		
7		60 га		
8		50 га	2015.02.13	2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 513 тоот захирамж /Т.Гансүх/
9		50 га		
10	Жуулчин Монгол наадам ХХК	400 га	2013.12.24	2005 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 142 тоот захирамж
11	Тахилт Хан ББ нөхөрлөл	2 га	2013.04.04	2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 923 тоот захирамж /Ц.Мэндсайхан/

Эх сурвалж: Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг Даргын Тамгын Газар

1.29 ИНЕГ 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдөр “Мошеа Эко Энержи” ХХК-тай “Нисэх буудал, түүний навигацйон тоног төхөөрөмжүүдийг сэргээгдэх эрчим хүчээр хангаж ажиллах” хамтын ажиллагааны гэрээ байгуулан ОУНОБ-ын зориулалттай газраас 100 га талбайг тус компанид шилжүүлсэн байна. Уг асуудлыг Авлигатай тэмцэх газар шалгаж байгаа тул аудитад хамруулаагүй хязгаарласан болно.

1.30 ИКАО байгууллагын “Олон улсын иргэний нисэхийн конвенц”-ын 14 дүгээр хавсралт “Аэродром”-д заасны дагуу НОБ-ыг 1-4 хүртэл тоон код, А-Е хүртэл үсэгт кодоор ангилдаг бөгөөд ОУНОШБ нь 4Е ангиллын шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 5. Хүчин чадлын харьцуулалт

Үзүүлэлт	2004 оны Мастер төлөвлөгөөгөөр ОУНОШБ-ын 2020 оны ачаалал, хүчин чадлын тооцоолол	Saprof судалгаагаар төлөвлөсөн	Чингис хаан ОУНОБ /2018 оны байдлаар/	ОУНОШБ
Аэродромын Код Зэрэглэл	4D	4E	4D	4E
Жилийн зорчигч тээвэрлэлт	852,700	1,651,000	1,422,498	3,000,000
Жилийн ачаа тээвэрлэлт /тонн/		11900	5752	11900
Жилийн агаарын хөдөлгөөн	9100	22,200	14,899	22,200
Хөөрч буух зурвас	3,100м x 45 м	3600м x 45м	3,100м x 60м 2,000м x 40м	3600м x 45м
Перрон /агаарын хөлгийн зогсоол/	162,450 м ²	93,000 м ²	120,600м ²	103,950 м ²
Зорчигч үйлчилгээний цогцолбор	24,000 м ²	31,200 м ²	16,050 м ²	53,726 м ²

Эх сурвалж: ИНЕГ, ТХН

⁴ 14. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж байгаа газрыг дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа улсын тусгай хэрэгцээнд авна:

1/ эзэмшиж байгаа газрыг нь өөр газраар сольж байгаа тохиолдолд эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн түүний эзэмшиж байгаа газрынх нь төлөв байдал, чанараас дордохооргүй газрыг түүнд эзэмшүүлэх;

2/ улсын тусгай хэрэгцээнд авч байгаа газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх.



Нэмэлт зээл авснаар ОУНОШБ ашиглалтад орох хугацаа хойшилж төслийн эдийн засгийн үр өгөөж буурсан байна

1.31 Мон-Пи8 зээлийн гэрээ хийгдэх үед төслийг 2015 оны 9 дүгээр сард хэрэгжүүлж дуусган, 2016 оноос эдийн засагт өгөөж өгч эхэлнэ гэж тооцоолсон бөгөөд санхүүгийн болон эдийн засгийн шинжилгээг төсөл хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлээгүй нөхцөлүүдэд тооцсон байна. Ингэхдээ төсөлд хөрөнгө оруулалт хийх үнэ цэнэ байгаа эсэхийг шийдвэрлэх зорилгоор хийгддэг эдийн засгийн дотоод өгөөжийн хувь, санхүүгийн дотоод өгөөжийн хувийг (*Economic Internal Rate of Return*) тооцох аргыг ашигласан байна.

1.32 Төслийн санхүүгийн дотоод өгөөж 0.5 хувь буюу зээлийн хүүгээс өндөр гарсан тул санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой гэж үзсэн байна. Олон улсад эдийн засгийн дотоод өгөөжийн хувийн доод хэмжээг 12 хувь⁵ байхад төслийг хэрэгжүүлэх боломжтой гэж үздэг бол энэхүү төслийн хувьд эдийн засгийн дотоод өгөөж дунджаар 28.4 хувь байна гэж тооцоолжээ.

1.33 Түүнчлэн төсөл хэрэгжүүлснээр дараах өгөөж гарна гэж үзсэн байна. Үүнд:

- Нислэг хойшлогдох болон цуцлагдах нь багассанаар Монголын агаарын тээвэрт гарах өгөөж;
- Нислэг хойшлогдох болон цуцлагдах нь багассанаар Монгол зорчигчдод ирэх өгөөж;
- Гадаадын зорчигчдын тооны өсөлттэйгөөр гарах ашиг;
- Монголд ирэх гадаадын жуулчид нэмэгдсэнээр гарах өгөөж;
- Монголын агаарын тээвэр шаардлагагүй эргэлт/нислэг үйлдэхээс зайлсхийснээр гарч ирэх өгөөж;

1.34 Харин 2015 онд нэмэлт зээл авахад төслийн эдийн засгийн өгөөжөө өгөх хугацаа хойшилж, хувь хэмжээ 13.2 хувь болж 2.1 дахин буурсан байна.

⁵ Азийн хөгжлийн банк



БҮЛЭГ 2. ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БОЛОВЧ ГЭРЭЭНД ЯПОН УЛСЫН ГҮЙЦЭТГЭГЧ КОМПАНИ БАЙХААР ЗААСНААС СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД 2 ЖИЛ ГАРУЙ ХУГАЦАА ЗАРЦУУЛАГДЖЭЭ

Зээлийн гэрээ олон улсын гэрээний зарчимд нийцэж буй хэдий ч гэрээний бүрдэл, албан орчуулга хангалтгүй, гэрээнд тусгасан дагаж мөрдөх дүрэм, журам, баримт бичгийг бүрэн хавсаргаагүй байна

2.1 Монгол Улсын ГХС / С.Оюун Япон Улсын Гадаад хэргийн сайд /хуучин нэрээр/ Масахико Коумура нар 2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Япон Улсын Токио хотод “ОУНОШБ барих төслийн хүрээнд иений хөнгөлөлттэй зээл олгох тухай” ноот бичиг байгуулжээ.

2.2 Уг ноот бичгийг үндэслэн Сангийн сайд Ч.Улаан ЯОУХАБ-тай 2008 оны 05 дугаар сарын 01-ний өдөр 28.8 тэрбум иений Мон-Пи8 зээлийн гэрээг байгуулж, УИХ-аас 2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр соёрхон баталжээ.

2.3 МУЗГ болон Япон Улсын Засгийн газар хооронд 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр солилцсон ноот бичгийг үндэслэн Зам тээврийн сайд /хуучин нэрээр/ Н.Төмөрхүү ЖАИКА-тай 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 36.8 тэрбум иений Мон-Пи12 зээлийн гэрээг байгуулж, УИХ 2015 оны 6 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталжээ.

2.4 Япон Улсын Засгийн газрын олгодог Хөгжлийн албан ёсны туслалцааны /ODA/ зээлийн энгийн хөнгөлөлттэй болон СТЭП /Special Terms for Economic Partnership (STEP)/ нөхцөлийг Мон-Пи8, Мон-Пи12 зээлийн нөхцөлтэй харьцуулан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6. Зээлийн нөхцөлийн харьцуулалт

№	Үзүүлэлт	Энгийн хөнгөлөлттэй зээл	STEP нөхцөлтэй зээл	МОН-Пи8 зээл	МОН-Пи12 зээл
1	Зээлийн хугацаа /жил/	30	40	40	40
2	Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа /жил/	10	10	10	10
3	Жилийн зээлийн хүү /хувь/	1.2	0.2	0.2	0.1
4	Зөвлөх үйлчилгээнд ноогдох зээлийн хүү /хувь/	1.2	0.01	0.01	0.01

Эх сурвалж: Зээлийн гэрээ

2.5 Мон-Пи8, Мон-Пи12 зээлийн гэрээ байгуулахаас өмнө Сангийн яам зээлийн нөхцөлүүдэд харьцуулсан тооцоолол хийсний үндсэн дээр STEP нөхцөлтэй хөнгөлөлттэй зээлийг Монгол Улсад ашигтай гэж үзсэн гэх боловч баримтаар нотлогдохгүй байна.

2.6 Монгол Улсад төдийгүй бусад оронд хөнгөлөлттэй зээл, тусламж олгож буй зээлдүүлэгч улс орон өөрийн дотоодын үйлдвэрлэл, ААН-ийг дэмжих зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь тухайн улсын гүйцэтгэгч байх шаардлага тавьдаг нийтлэг жишигтэй байна. Тухайлбал:

- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Төв цэвэрлэх байгууламжийн төсөл”,
- БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”
- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл “УБ – Хөшигийн хөндийн ОУШНОБ чиглэлийн хурдны авто зам”
- БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Нефть боловсруулах үйлдвэрийн төсөл”

2.7 “Япон улсын хөгжлийн албан ёсны туслалцааны зээлийн хүрээнд худалдан авалт хийхэд баримтлах журам”-ын 2.4-т “зээлээр санхүүжих гэрээ хэлцлийн нийт үнийн 30 хувиас доошгүй бараа болон үйлчилгээг Япон улсаас худалдан авна”, 2 дугаар хэсгийн (1)(а)-д “Ерөнхий гэрээлэгчийн хувьд Япон” гэсэн заалтууд нь зээлдэгч Монгол улсын хувьд хязгаар тогтоож, Япон Улсын талд давуу эрх олгосон байна.



2.8 Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалт хангалтгүйгээс уг зээлийн гэрээнүүдийн монгол хэл дээрх орчуулга иж бүрэн бус, гэрээний жинхэнэ эхийг холбогдох хуульд заасны дагуу хадгалаагүй байна. Тухайлбал:

- Сангийн яам өнөөдрийг хүртэл МОН-Пи8 зээлийн гэрээний жинхэнэ эхийг Гадаад харилцааны яаманд шилжүүлээгүй байгаа нь Олон улсын гэрээний тухай хуулийн /1993 он/ 26 дугаар зүйлийн 2⁶-т заасныг баримтлаагүй,
- МОН-Пи12 Зээлийн гэрээг байгуулахад МУЗГ болон Япон Улсын Засгийн газрын хооронд 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр солилцсон Ноот бичгийг ГХЯ Монгол хэл дээр албан ёсоор орчуулж монгол хэл дээрх гэрээнд хавсаргаагүй, гэрээний бүрдэл дутуу байгаа нь Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, тус зүйлийн 2.8⁷, Иргэний хуулийн 200 дугаар зүйлийн 200.1⁸ дэх заалт Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

2.9 Мөн зээлийн гэрээнд дурдсан дараах журмыг иж бүрэн байдлаар албан ёсоор орчуулж¹⁰ хавсаргаагүй нь дээрх хуулийн заалтуудыг зөрчсөн төдийгүй аудитын баг ГХЯ-ны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын холбогдох албан тушаалтнуудтай хийсэн уулзалт ярилцлагаар “... гаднын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн хувьд санхүүжүүлэгч талын санал болгож буй дүрэм журмуудыг иж бүрэн хавсаргадаггүй ч мөрдөх явдал түгээмэл байдаг” гэж тайлбарлаж байгаа нь Монгол Улсад гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдэд уг дутагдал нийтлэг болохыг харуулж байна. Үүнд:

Мон-Пи8 зээлийн гэрээний хувьд:

- General Terms and Conditions for ODA Loans, dated October 1999,
- Guidelines for Procurement under JBIC ODA Loans dated October 1999
- Commitment Procedure for ODA Loans dated July 2007
- Reimbursement Procedure for ODA Loans dated October 1999

Мон-Пи12 зээлийн гэрээний хувьд:

- Guidelines for Procurement under Japanese ODA Loans dated April 2012
- Guidelines for the Employment of Consultants under Japanese ODA Loans dated April 2012
- Brochure on Commitment Procedure for Japanese ODA Loans dated August 2012
- Brochure on Reimbursement Procedure for Japanese ODA Loans dated August 2012
- Brochure on Transfer Procedure for Japanese ODA Loans dated August 2012
- General Terms and Conditions for Japanese ODA Loans, dated November 2014

2.10 Мон-Пи8 зээлийн гэрээний 4 дүгээр зүйлийн¹¹ 4.1-т “...зээлдэгч нь төслийн нийт зохицуулалт, удирдлагыг хэрэгжүүлэх эрхийг ЗТАЖЯ /гүйцэтгэгч агентлаг/-д олгоно...”, 4.2-т “...зээлдэгч нь төслийн гэрээний хэрэгжүүлэх ажлыг ИНЕГ /хэрэгжүүлэгч агентлаг/-аар гүйцэтгүүлэхээр томилох чиглэлийг гүйцэтгэгч агентлаг өгнө...” гэж заасан байна.

2.11 ИНЕГ-ын дарга С.Буяндалай (холбогдох ажилтнууд) нь барилгын ажлын гэрээг Англи хэл дээр байгуулахдаа гэрээ, гэрээнд нэр зааж дурдсан боловч хавсаргаагүй баримт бичгийн утга агуулгыг бүрэн ойлгон хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан гэж үзэхэд учир дутагдалтай төдийгүй гэрээ байгуулснаас хойш 5 сар орчмын дараа Монгол хэл дээр орчуулга хийлгэсэн нь Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹² дэх заалтыг баримталж ажиллаагүйг харуулж байна. Тухайлбал,

⁶ Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2. Олон улсын гэрээг хариуцан байгуулсан яам, тусгай газар гэрээ байгуулсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн гэрээний баталгаатай хуулбарыг холбогдох газарт нь хүргүүлж, жинхэнэ эх бичвэрийг дараах материалын хамт гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлнэ

⁷ Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2.8/тухайн гэрээнд холбогдолтой бусад баримт бичиг.

⁸ Иргэний хуулийн 200.1.Гэрээний нэг тал нь нөгөөдөө санал болгож байгаа, хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх, урьдчилан тогтоосон нөхцөлийг гэрээний стандарт нөхцөл гэнэ. /539 дүгээр зүйлийн

Иргэний хуулийн 539.1.Монгол Улс олон улсын гэрээ байгуулахдаа Монгол Улсын Иргэний хуулийн нийтлэг үндэслэлийг харгалзана,

Иргэний хуулийн 545.1.Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд төр нэг тал болон оролцож байгаа тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг хэрэглэнэ../

⁹ Төрийн албан ёсны хэлний тухай хууль 5.1.Монгол Улсын төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна.

¹⁰ УДШ-ийн 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 9 дүгээр тогтоолоос “... Гадаад хэргийн яамнаас олон улсын гэрээг албан ёсоор орчуулсан эхийг Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэн нийтэлснийг “олон улсын гэрээний албан ёсны нийтлэл” гэж үзнэ.”

¹¹ Зээлийн удирдлага, зохицуулалт.

¹² Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5.1.Монгол Улсын төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна.



- Гэрээний 3 дугаар зүйлийн 7-д дурдсан “Техникийн нөхцөлүүд” (Technical Specification Terms of Reference (TOR) for Additional Loan Components) 140 хуудас бичиг баримтыг Монгол хэл дээр өнөөдрийг хүртэл орчуулаагүй байгаагаас ЗТХЯ, ИНЕГ, МХЕГ болон барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс техникийн шаардлагуудыг ойлгож ашиглан, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа хязгаарлагдах нөхцөл үүссэн байж болзошгүй байна.

2.12 Зөвлөх үйлчилгээний болон барилгын ажил гүйцэтгэх гэрээнд дурдсан дараах бичиг баримтыг хавсаргаагүй, Монгол хэл дээр албан орчуулга хийлгээгүй тул эдгээр бичиг баримтыг гэрээний стандарт нөхцөл гэж үзэж дүгнэлт гаргах боломжгүй байна.

Зөвлөх үйлчилгээний гэрээ

- Японы ODA Зээлийн дагуу зөвлөхийг сонгон шалгаруулах журам (Guidance for the Employment of Consultants under JBIC ODA Loans /January 2005),
- Зөвшилцөх болон Арбитрын үйл ажиллагааны журам (Rules of Conciliation and Arbitration prepared by the International Chamber of Commerce)

Барилгын ажил гүйцэтгэх гэрээ

- JICA, FIDIC-ийн хооронд 2008 оны 08 дугаар сарын 01-ний өдөр гарын үсэг зурсан Лицензийн Хэлэлцээр (License Agreement) Уг лицензийн хэлэлцээр, ЯОУХАБ-ны хэрэгцээнд нийцүүлэн боловсруулсан, Барилгын ажил гүйцэтгэх гэрээний Ерөнхий нөхцөлүүдийг ИНЕГ Монгол хэл дээр урьдчилан орчуулж, танилцсан гэх нотлох баримтгүй байгаагаас гэрээний тусгай нөхцөлөөр дамжуулан ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах эрхээ чөлөөгөө хэрэгжүүлэх боломжгүй байсан гэж үзэхээр байна,
- Стандартын Олон Улсын Байгууллагаас (International Organization for Standardization) тогтоосон журмыг баримтлахаар Гэрээний Тусгай нөхцөлөөр, Ерөнхий нөхцөлийн 4.9-д өөрчлөлт оруулсан, “ISO 9001:2008 стандарт”
- Монгол, Япон Улсын Засагийн газар хоорондын 2008 оны Ноот бичиг (2008 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн Note Verbale and Record of Discussion)

2.13 Барилгын ажил гүйцэтгэх үндсэн гэрээний 8.7-д заасан барилгын ажил үйлчилгээг хэрэгжүүлэх явцад Гэрээний хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох тухай заалтыг талууд нэмэлт барилгын ажлуудын хувьд хэрэгжүүлэхгүй байх талаар тохиролцож, Ерөнхий гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд ноогдуулах хариуцлагаас чөлөөлсөн нь Гэрээний ерөнхий нөхцөлийн үндсэн агуулгыг алдагдуулсан зөрчил¹³ гэж үзэхээр байна.

2.14 Зөвлөх үйлчилгээний гэрээний Тусгай нөхцөлүүдийн 6.3 (б)(i) – д “Гадаад болон дотоод хүн хүчний цалин хөлс гадаад валютаар (Япон иен) төлөгдөх ёстой” гэсэн нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1¹⁴ дэх заалттай нийцээгүй байна.

2.15 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний Тусгай нөхцөлийн 8.2.5 (а)-д “Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын үйл ажиллагаа Сингапур Улсад явагдана” гэж заасан байна. Арбитрын тухай хуулийн¹⁵ зохицуулалтаар аливаа маргаан үүссэн тохиолдолд Монгол Улсад шийдвэрлүүлэх бүрэн боломжтой байхад өртөг, зардал өндөр Сингапур улсад маргааныг шийдвэрлүүлэхээр заасан нь маргаан үүссэн тохиолдолд Монгол Улсад их хэмжээний арбитрын зардал¹⁶ гарах эрсдэлтэй байна.

2.16 Үүнээс гадна Зөвлөх үйлчилгээний гэрээнд дагаж мөрдөх хууль “Монгол Улсын хууль, тогтоомж” байхаар заасан боловч аливаа маргаан үүссэн тохиолдолд Сингапур улсад

¹³ Барилгын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцөлийн 8.7-д “Гэрээний 8.2-т заасан барилгын ажлыг гүйцэтгэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх”-ээр заасан байна. Гэрээний тусгай нөхцөлийн 8.7, 14.15(b)-д зааснаар нэг өдөрт ноогдуулах торгууль нь төслийн өртгийн 0.05% буюу 435 сая төгрөгтэй тэнцэж байна.

¹⁴ Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монгол банкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.

¹⁵ Арбитрын тухай хуулийн 2.1-д “Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс бол энэ хууль үйлчилнэ”, **9 дүгээр зүйлд** “Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ”, 32.1-д “Арбитрын ажиллагааны харьяаллыг талууд тохиролцон тогтоох эрхтэй” гэж тус тус заасан байх Улаанбаатар, 2017.1.26

¹⁶ Монгол улсын арбитраар эсхүл гадаад улсын иргэн, арбитраар Монгол Улсад маргааныг шийдвэрлүүлэх нь арбитрын зардал бага гарах давуу талтай



Олон улсын худалдааны танхимын журмыг баримтлан ФИДИК-ийн арбитраар шийдвэрлүүлэх зохицуулалттай байна.

2.17 Зөвлөх үйлчилгээний гэрээний 1.3-д “Уг гэрээ түүний утга агуулга болон тайлбар, талуудын хоорондын харилцаа зэрэг нь мөрдөгдөж буй хууль тогтоомжоор зохицуулагдана”, 3.1.2-т Зөвлөх тал “дагаж мөрдвөл зохих хуулиуд”-ын дагуу үйл ажиллагаагаа явуулна гэж заасны дагуу Талууд Монгол Улсын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахаар байна.

2.18 Мөн гэрээний 5.1 (д) Зөвлөх болон туслах компанийг Монгол Улсад бүртгүүлэх, эдгээр компаниуд болон ажилтнууд нь аливаа тусгай зөвшөөрөл авах хуулийн шаардлагаас чөлөөлөгдөхөөр¹⁷ заасан нь Компанийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1¹⁸ дэх заалт, 2 дугаар зүйлийн 2.1¹⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

2.19 Төслийн зөвлөх болон Ерөнхий гүйцэтгэгчийн Монгол Улсад хуулийн этгээдээр бүртгүүлээгүй боловч өдөр тутмын үйл ажиллагаа, туслан зөвлөх, ажил үйлчилгээ авах гэрээ байгуулахад тэмдэг, хэвлэмэл хуудас ашиглаж байгаа нь Засгийн Газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”²⁰-ыг баримтлаагүй байна. Тухайлбал,

- Зөвлөх нь МУЗГ, ЯОУХАБ хооронд байгуулсан зээлийн гэрээний “МОН-Пу8/P12” бүхий NUBIA 1115309105 дугаар бүхий байгууллагын тэмдэг, “Azusa Sekkei/Oriental Consultants Global Joint Venture” гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас;
- Ерөнхий гүйцэтгэгч нь “Mitsubishi-Chiyoda/Joint Venture /New Ulaanbaatar International Airport Construction Project ГСТ 3456” гэсэн байгууллагын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас.

2.20 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний Ерөнхий нөхцөлийн 2.2²¹(b) Тухайн улсын хуулийн дагуу шаардагдах аливаа зөвшөөрөл лиценз, 2.2(b)(i) Гэрээний 1.13²²-т зааснаар Гүйцэтгэгч авбал зохих аливаа зөвшөөрөл лиценз²³ гэж заасныг төсөл хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага нь хэрэгжүүлээгүй төдийгүй гүйцэтгэгчийг энэхүү үүргээс чөлөөлөх санамж бичиг, нэмэлт гэрээг байгуулснаас Ерөнхий гүйцэтгэгч тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, Компанийн тухай хуулийн 8.4²⁴ дэх хэсгийн заалтыг зөрчихөд хүргэжээ. Үүнд:

- ЗТЯ-ны ТНБД Б.Батзаяа, Мицубиши корпорацийн бизнесийн хэсгийн тээврийн хэлтсийн ерөнхий менежер нарын 2013 оны 04 сарын сарын 15-ны өдөр байгуулсан англи хэл дээрх Санамж бичгийн 5 дугаар зүйлийн “Зөвшөөрөл болон Лицензүүд” (Permits and Licences) хэсэгт “Монгол улсын Засгийн газар, 3 дугаар хавсралтад дурдсан ихэнх зөвшөөрөл лицензийг энэ Гэрээний хувьд шаардахгүй. Гүйцэтгэгчид үйл ажиллагаагаа нэн даруй эхлэх боломж олгохын тулд, Гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгч нарт Монголд энэ Төсөлд ажиллах хугацаанд шаардагдах аливаа бусад Зөвшөөрөл Лицензүүдийг олгуулах боломжтой арга хэмжээг Захиалагч авч хэрэгжүүлнэ²⁵” гэж заасан байна.

¹⁷ 5.1.(д) Зөвлөх талыг болон хүн хүч, мөн зөвлөх талын хөлсөлсөн аливаа Туслах зөвлөх талыг бүртгүүлэх, аль эсвэл ажил мэргэжилдээ дадлагажихын тулд албан ёсны зөвшөөрөл авах, мөн түүнчлэн өөрсдийгөө дангаар эсвэл Гэрээний хууль тогтоомжийн дагуу корпорацийн түвшний нэгж компани болгон байгуулах зэрэг аливаа шаардлагуудаас чөлөөлөгдөх”

¹⁸ Компанийн тухай хууль 1.1.Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

¹⁹ Компанийн тухай хууль 2.1 Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг дагаж мөрдөнө

²⁰ Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар. Төрийн бус бусад байгууллага, хуулийн этгээд тэмдэг хэрэглэнэ. 19. Тэмдэг хийлгэхдээ тухайн байгууллагын шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, захиалга болон загварыг аймаг, хотын цагдаагийн байгууллагад өгч хянуулан, хийлгэх хугацааг тохиролцоно.

²¹ “Гүйцэтгэгч дараах зөвшөөрөл лицензийг зохих журмын дагуу авахад Захиалагч нь Гүйцэтгэгчийн шаардсаны дагуу боломжтой тус дэмжлэгийг үзүүлнэ.

²² Захиалагч нь төлөвлөлт болон барилгын зөвшөөрөл, барилгын ажил гүйцэтгэхтэй холбогдуулан техникийн шаардлагад заасан бусад зөвшөөрлийг гаргаж өгөх бөгөөд захиалагч нь хуулийг дагаж мөрдөхтэй холбоотой аливаа алдаа, дутагдал гаргахаас гүйцэтгэгчийг хамгаална

²³ Англи хэлнээс албан бусаар орчуулав. Г.Ганзориг.

²⁴ Компанийн тухай хуулийн 8.4.Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

²⁵ Almost of all Permit and Licences listed in Annex No.3 shall be waived by the Mongolian Government for this Contract. The Employer shall take all reasonable supporting measures to ensure that any remaining Permits and Licenses required for the Contractor and its Subcontractors to work in Mongolia for this project, shall be issued to allow the Contractor to proceed with the Works without delay



- ТУХ-ны 2013 оны хуралд ТХН-ээс Ерөнхий гүйцэтгэгч нь ЗТЯ, БХБЯ, ЭХЯ, БОНХЯ, МХЕГ, Цөмийн энергийн газраас холбогдох тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай талаар танилцуулж байжээ.
- ТХН, Ерөнхий гүйцэтгэгчтэй 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Нэмэлт гэрээ”-нд Захиалагч гүйцэтгэгчид шаардлагатай тусгай зөвшөөрөл болон лицензүүдийг авч өгөхөд хүндрэл бэрхшээлтэй байвал эдгээр зөвшөөрлүүд ажлыг үргэлжлүүлэхэд шаардагдахгүй, саад учруулахгүй байхаар харилцан зөвшилцсөн байна.

2.21 Зөвлөх үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлийн 1.10-д Монгол улсын иргэн болон Монгол Улсад байнгын оршин суудаг иргэнээс бусад нь аливаа татвар хураамжаас чөлөөлөгдөхөөр заасан²⁶ нь МУЗГ, Япон Улсын Засгийн газрын хооронд 2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан “Ноот бичиг”-ийн 7(d) “...Япон компанийн Япон ажилчдыг төсвөөс авах бүх төрлийн хураамж, шимтгэл, татвар ХХОАТ-аас чөлөөлнө”²⁷ гэж заасантай нийцэхгүй байна.

2.22 Зөвлөх болон Ерөнхий гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдтэй Хөдөлмөрийн гэрээ бичгээр байгуулж ажиллуулахдаа Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна. Тухайлбал,

- Зөвлөх нь гэрээ байгуулан ажиллуулж буй 18 ажилтны цалингаас ХХОАТ болон Нийгмийн даатгалыг зохих хувиар суутгал хийж татвар, нийгмийн даатгалын холбогдох байгууллагад шилжүүлэх хуулиар тогтоосон үүргээ биелүүлэлгүй;
- Ерөнхий гүйцэтгэгч нь ажилтны цалингаас зохих хувиар суутгал хийж нийгмийн даатгалын холбогдох байгууллагад шилжүүлэх хуулиар тогтоосон үүргээ биелүүлэлгүй, ХХОАТ-ыг жилд нэг удаа төлж байгаа нь “татварыг сар тутам суутган шилжүүлэх” талаарх заалтыг зөрчжээ.

2.23 Дээрх нөхцөл байдлаас харахад төслийн хүрээнд байгуулагдсан олон улсын жишиг гэрээнүүдийн иж бүрдлийг хангуулах, Монгол улсын онцлогт тохируулан өөрчлөх талаар идэвх санаачилгатай ажилласан гэх хангалттай нотлох баримтгүй байна. Тухайлбал,

- Барилгын ажил гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэгч нэхэмжлэл гаргаснаас хойш нийтээр амрах баяр ёслол, амралтын өдрийг тооцохгүйгээр хуанлийн 56 хоногт гүйцэтгэгчийн дансанд шилжүүлэхээр зааж өгснөөс гүйцэтгэгчээс хугацаа хэтэрсэн хоног тутам алданги тооцож, нэхэмжлэл ирүүлсэн байна.

2.24 Цаашид Засгийн газраас гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хүрээнд гэрээ байгуулахдаа зээлдүүлэгч талын санал болгож буй гэрээний төслийн иж бүрдлийг бүрэн хангуулан, албан ёсны орчуулга хийлгэж нарийвчлан танилцаж, чиг үүргийг тодорхой болгох хэлцлийн үе шатанд гэрээ нь эдийн засгийн үр ашигтай, Монгол улсын онцлогийг тусгасан, эрх тэгш байдлыг хангасан байхад анхаарах шаардлагатай байна.

Төслийн зээл нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй боловч эргэн төлөлтөд их хэмжээний ханшийн зөрүү үүсэх эрсдэлтэй байна.

2.25 Аудитын баг Өрийн удирдлагын тухай хуульд тодорхойлсны дагуу зээлийн хөнгөлөлтийн түвшнийг²⁸ тооцож үзэхэд Мон-Пи8 зээлийн хувьд 42 хувь, Мон-Пи12 зээлийн хувьд 59 хувь байгаа бөгөөд эдгээр зээлүүд нь тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3-д заасан нэн хөнгөлөлттэй зээлийн төрөлд²⁹ хамаарч байна.

2.26 Мон-Пи8 зээлийн гэрээнд заасны дагуу 10 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж 2018 оны 05 дугаар сараас зээлийн эргэн төлөлт хийгдэж эхлээд байгаа бөгөөд 2019 оны 10

²⁶ Ажил олгогч тал Зөвлөх тал, туслан зөвлөх талууд болон Хүн хүчний талаарх Гэрээний хууль тогтоомжийн дагуу, эдгээр Талууд аливаа татвар, хураамж, төлбөр, торгууль зэрэг бусад өр төлбөрөөс чөлөөлөгдөх ёстойг баталж байгаа болно. Үүнд: А. Ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй холбоотой Зөвлөх тал, Туслан зөвлөх талууд болон хүн хүчинд /Ажил олгогч талын улс орны харьяа, аль эсвэл Ажил олгогч талын улс орны байнгын оршин суугчдаас бусад/ төлсөн аливаа төлбөр тооцоо;

²⁷ Төслийн хэрэгжилтэд оролцож буй ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч, зөвлөхөөр ажиллаж байгаа Япон компанийн Япон ажилчдыг Төсвөөс авах бүх төрлийн хураамж, шимтгэл, татвар ХХОАТ-аас чөлөөлнө.

²⁸ Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.18. “хөнгөлөлтийн түвшин” гэж зээлийн нэрлэсэн үнэ болон өнөөгийн үнэ цэний хоорондын зөрүүг тухайн зээлийн нэрлэсэн үнэтэй харьцуулж, хувиар илэрхийлснийг;

²⁹ Өрийн удирдлагын тухай хуулийн 23.1.3. нэн хөнгөлөлттэй буюу 35 болон түүнээс дээш хувийн хөнгөлөлтийн түвшинтэй зээл.



дугаар сарын байдлаар нийт 1,569.3 сая иен буюу 37.2 тэрбум төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөд байна.

2.27 Хэдийгээр Мон-Пи8, Мон-Пи12 зээлийн гэрээ нь нэн хөнгөлөлттэй зээлд хамаарагдаж байгаа ч 2019 оны 10 дугаар сарын байдлаар ханшийн зөрүүнд 488.5 тэрбум буюу хагас их наяд төгрөг төлөгдөхөөр байна. Цаашид төгрөгийн ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан уг дүн нэмэгдэх эрсдэлтэй байна.

2.28 Мөн зээлдүүлэгчээс төслийн гүйцэтгэгчид санхүүжилт олгох үйл ажиллагаа Япон улсад явагдаж, Монгол Улсын валютын урсгалд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлэхгүй байгаа нь зээлдэгч Монгол Улсын хувьд зээлийн хөрөнгөөр дамжуулан валютын нөөц, ханшийн тогтвортой байдлыг хангах боломжийг алдахад хүргэсэн байна.

Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт ЖАИКА-ийн журмын дагуу явагдсан хэдий ч зээлийн гэрээнд Япон улсын гүйцэтгэгч компани байхаар зааснаас сонгон шалгаруулалтад 2 жил гаруй хугацаа зарцуулжээ

2.29 Мон-Пи8 зээлийн гэрээний хавсралт №4-д зээлийн хөрөнгөөр худалдан авалт зохион байгуулахад баримтлах чиглэлийг баталсны дагуу ЗТБХБЯ нь Төслийн зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг 2009 онд, барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2009-2013 онд зохион байгуулжээ. Үүнд:

- Зөвлөх үйлчилгээнээс бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг зээлийн хөрөнгөөр худалдан авахдаа 1999 оны 10 дугаар сард батлагдсан JBIC ODA зээлийн хүрээнд худалдан авалт хийхэд баримтлах чиглэл;
- Зөвлөх үйлчилгээг зээлийн хөрөнгөөр худалдан авахдаа 1999 оны 10 дугаар сард батлагдсан JBIC ODA зээлийн хүрээнд зөвлөх үйлчилгээ авахад баримтлах чиглэлийг баримталсан байна

2.30 ЗТБХБЯ-ны ТНБД-ын 2008 оны 42 дугаар тушаалаар байгуулагдсан зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо ЯОУХАБ ХАЁТ зээлийн хүрээнд зөвлөх үйлчилгээ авахад баримтлах чиглэлийн дагуу ажлын даалгавар, зөвлөхийн хураангуй жагсаалтыг ЖАИКА-д хянуулж, Япон Улсын 7 компанид тендерийн баримт бичгийг хүргүүлснээс 2009 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр 2 түншлэл тус төсөлд оролцох санал, тендерийн баримт бичгээ ирүүлжээ.

2.31 Үнэлгээний хороо оролцогч түншлэлүүдээс ирүүлсэн техникийн саналыг байгууллагын туршлага, хүний нөөцийн үзүүлэлтийг чанарын үнэлгээний аргаар үнэлэхэд “Azusa sekkei Co.Ltd” болон “Oriental Consultants Co.Ltd” хамтарсан түншлэл 95.49 оноо, “Japan airport Consultants, Inc”, “Kisho Kurokawa Architect& Associates”, “Nippon koei Co.Ltd” хамтарсан түншлэл 87.62 оноо тус тус авчээ.

2.32 ЗТБХБЯ-аас техникийн саналын үнэлгээний дүнг Сангийн яаманд хүргүүлснээс хамгийн өндөр үнэлгээ авсан “Azusa sekkei Co.Ltd” болон “Oriental Consultants Co.Ltd” хамтарсан түншлэлийн үнийн саналыг нээж, хэлцэл хийх зөвшөөрөл, ЖАИКА зээлийн гэрээний Хавсралт 4-ийн 4.2³⁰ заалтын дагуу үнэлгээний тайлан болон холбогдох бусад баримт материалыг хянан үзэж, зөвшөөрөл тус тус олгосон байна.

2.33 ЗТБХБС-ын 2009 оны 151 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Azusa sekkei Co.Ltd” болон “Oriental Consultants Co.Ltd” хамтарсан түншлэлийн ирүүлсэн 1,998.8 сая иений санхүүгийн санал болон бусад нөхцөлийг харилцан тохиролцох зорилгоор хэлцэл хийсний үндсэн дээр Монгол Улсын Иргэний нисэх хүчний удирдлага /тухайн үеийн нэрээр/ 1,920.9 сая иений үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний гэрээг 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдөр байгуулжээ.

³⁰ Мон-Пи8 зээлийн гэрээний Хавсралт 4-ийн 4.2 Зээлдэгч нь хамгийн дээд үнэлгээ авсан Зөвлөхийг гэрээний яриа хэлцэлд урихын өмнө ирүүлсэн саналуудын үнэлгээ болон Зөвлөхүүдийн саналын үнэлгээний тайланг хянан үзэх хүсэлтийг зөвшөөрөл авахаар Банканд хүргүүлнэ. Банк нь эдгээр бичиг баримтыг зөвшөөрсөн бол энэ тухайгаа Зөвлөхүүдийн саналын үнэлгээний тайлангийн талаарх мэдэгдлээр Зээлдэгчид хариу өгнө.



2.34 Япон Улсын Зөвлөх нь Төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний 3.7³¹-д заасны дагуу захиалагч /ИНЕГ/-аас зөвшөөрөл авах ёстой боловч ТХН-ээс зөвшөөрөл авсны үндсэн дээр дотоодын 14 компанитай нийт 1.34 сая ам.доллар, 857.6 сая төгрөгийн туслан гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

2.35 Зөвлөх нь “Ач CBC” ХХК³²-тай “Air navigation design” боловсруулах 147.0 мянган ам.долларын гэрээг 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр туслан зөвлөхийн гэрээ байгуулсан байна.

2.36 Мон-Пи8 зээлийн гэрээнд заасан “Sample bidding documents Under JBIC ODA Loans Dater November 1999” жишиг баримт бичгийн дагуу барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулах ёстой хэдий ч энэхүү журам нь 2009 оны 6 дугаар сард шинэчлэн батлагдсан байна.

2.37 ЗТБХБЯ нь Мон-Пи8 зээлийн гэрээнд дурдсан дүрэм, журмын шинэчилсэн хувилбарыг дагаж, мөрдөх тухай зохицуулалт тусгагдаагүй байхад 2010 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 4/3089 дугаар албан бичгээр Зөвлөхөд шинэчлэгдсэн тендерийн баримт бичгийн загварын дагуу³³ боловсруулах, тендерийг дүгнэх зөвшөөрлийг олгосон байна.

2.38 ЗТБХБС-ын 2010 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 336 дугаар тушаалаар төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 11 гишүүнтэй үнэлгээний хороог байгуулж, Зөвлөхийн боловсруулсан “Урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг хянуулж, Сангийн яамаар уламжлуулан ЖАИКА-д хүргүүлсэн байна.

2.39 Сангийн яам урьдчилсан сонгон шалгаруулалтыг ЯОУХАБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу явуулах зөвшөөрлийг ЗТБХБ-нд 2010 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 5/5307 дугаар албан бичгээр, ЖАИКА нь тендерийн баримт бичигт зохих хэмжээний өөрчлөлт оруулсан тохиолдолд татгалзах зүйлгүй гэдгээ 2010 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 12-10001 дугаар албан бичгээр мэдэгджээ.

2.40 Үнэлгээний хороо урьдчилсан сонгон шалгаруулалтын урилгыг дотоодын болон Япон Улсын хэвлэлд нийтэлсний дагуу 7 компани материал худалдаж авсан боловч 2011 оны 2 дугаар сарын 16-ны өдөр зөвхөн Taisei/Nippo/Dai nippon корпорацуудын түншлэл санал ирүүлсэн тул худалдан авах журмын дагуу³⁴ өрсөлдөөн үүсээгүй гэж үзэн сонгон шалгаруулалт хүчингүй болсон байна.

2.41 ЗТБХБЯ-ны зүгээс тендерийн баримт бичигт заасан зарим шалгуур үзүүлэлтийг бууруулан Сангийн яаманд хянуулахаар хүргүүлж, 2011 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 5/1005 дугаар албан бичгээр тендер зарлах зөвшөөрлийг авч тендерийг дахин зарласан байна.

³¹ Ажил олгогч талаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай Зөвлөх талын үйл ажиллагаа.

Зөвлөх тал дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийн өмнө Ажил олгогч талаас бичгээр урьдчилсан зөвшөөрлийг авсан байх шаардлагатай:

- (a) Хавсралт В-д тусгагдсан албан хаагчдын гишүүдийг нэрээр нь биш зөвхөн эзэмшсэн мэргэжлээс нь үүдэн томилох
- (b) Ажил үйлчилгээний аливаа нэг хэсгийг хийж гүйцэтгэхийн тулд туслах гэрээнд нэгдэж орох нь (i) Туслах Зөвлөх талын сонголт болон Тусгах гэрээний нөхцөл Туслах гэрээ батлагдахаас өмнө Ажил олгогч талаас бичгээр урьдчилан хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой, мөн (ii) Гэрээнд холбогдолтой Туслах Зөвлөх тал болон түүний Хүн Хүчний Ажил үйлчилгээний гүйцэтгэлд Зөвлөх талаас бүрэн үүрэг хариуцлагыг хүлээх ёстой болох нь ойлгогдож байгаа болно.

³² “АЧСВС” ХХК нь 2007.12.27-нд “Аялал жуулчлал”, “Гадаад худалдаа”-ны чиглэлээр байгуулагдаж, Үйл ажиллагааны чиглэлдээ “Кафе ажиллуулах”, “Зочид буудал” 2008.01.16-нд нэмсэн. Ажил гүйцэтгэх үед нисэхийн болон нийтийн зориулалтын холбоо, цахилгааны ажил, үйлчилгээ гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй байжээ.

³³ 1 үе шаттай, 2 дугуйтай сонгон шалгаруулалт

³⁴ “Guidelines for Procurement under Japanese ODA Loans 2009-Mar” Section 3.02 Prequalification of Bidders,

3. Paragraph (3): (02) **In case only one applicant is prequalified as a result of the evaluation, the Borrower should reject this prequalification process** because it is of no value to conduct a bid with the only applicant. Accordingly, the Borrower should initiate another prequalification process with certain modifications of conditions or other relevant methods based on the basic principles on guidelines.



2.42 Тендерийн баримт бичгийг 7 компани³⁵ худалдан авсан боловч 2011 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр тендер нээх үед санал ирээгүй тул 2 дахь удаагийн тендер шалгаруулалт амжилтгүй болжээ.

2.43 Иймд үнэлгээний хороо төслийг 2 багц болгон хувааж тендер 3 дахь удаагаа зарлахад 1 дүгээр багцад Япон Улсын Ниппо компанийн ирүүлсэн техникийн саналыг шаардлага хангасан гэж үнэлсэнтэй Сангийн яам танилцан тус оролцогчийн санхүүгийн саналыг нээж, холбогдох журмын дагуу үнэлгээ хийх тухай 2012 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 5/1298 дугаар албан бичгээр мэдэгджээ.

2.44 Гэвч ЖАИКА-ын зүгээс 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 4-17001 дугаар албан бичгээр Үнэлгээний хорооны техникийн саналыг үнэлсэн үнэлгээ нь тендерийн баримт бичиг, худалдан авах ажиллагааны журамтай зөрчилдөж буй³⁶ тул санал нийлэхгүй гэдгээ мэдэгдэж дараагийн шатанд авах арга хэмжээний талаарх саналаа ирүүлэхийг хүссэн байна.

2.45 Сангийн яамнаас Guidelines for Procurement under Japanese ODA худалдан авах журмын 4.05-д заасны дагуу тендерийн 1,2 дугаар багцыг нэгтгэн 2 дугаар багцын сонгон шалгаруулах тухай тендерийн баримт бичигт оруулсан өөрчлөлтийг ЖАИКА зөвшөөрсний үндсэн дээр Үнэлгээний хороо 2012 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр тендер нээж, Shimizu/Dai Nippon JV, Mitsubishi Corp/Chiyoda Corp JV /БНСУ-ын Samsung компани туслан гүйцэтгэгч байх/ нарын тендерийн баримт материалыг хүлээн авчээ.

2.46 Тендерт оролцогчдын техникийн саналыг үнэлэхэд Shimizu/Dai Nippon JV нь барилгын ажлын гүйцэтгэх хугацааг тендерийн нөхцөлд зааснаас 21 сараар хэтрүүлсэн, хүний нөөцийн ур чадвар шалгуурт тэнцээгүй, харин Mitsubishi Corp/Chiyoda Corp JV тэнцсэн тул Үнэлгээний хороо тайлан, дүгнэлтийг Сангийн яаманд хүргүүлж санхүүгийн саналыг нээх зөвшөөрөл хүсжээ.

2.47 Мөн холбогдох журмын дагуу³⁷ техникийн саналын үнэлгээний дүнг танилцуулахад ЖАИКА-ын зүгээс үнэлгээний дүгнэлтэд татгалзах зүйлгүй гэдгээ 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн JICA (MG) 12-21004 дүгээр албан бичгээр мэдэгдсэн тул 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдөр үнийн саналыг нээхэд Mitsubishi Corp/Chiyoda Corp JV -ийн үнийн санал 47.1 тэрбум иен байжээ.

2.48 Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн санал зөвлөхийн боловсруулсан үнээс /тендерийн баримт бичиг/ 17.1 тэрбум иенээр хэтэрсэн тул үнэлгээний дүнг хянуулж, хэлэлцээр хийх тухай зөвшөөрөл авах хүсэлтийг Сангийн яам, ЖАИКА-д тус тус хүргүүлсний дагуу 2013 оны 03 дугаар сарын 4-нөөс 7-ны өдрүүдэд үнийн саналыг судлах ажлын хэсэг Монгол Улсад ирж ажиллан 2013 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн JICA (MG) 3-06001 дугаар албан бичгээр уг нэмэлт хавсралт бүхий 2 дугаар багцын тендерт оролцогчтой гэрээ байгуулах хэлэлцээрт ороход татгалзах зүйлгүй гэдгээ мэдэгджээ.

2.49 ЗТЯ-ны зүгээс үнийн зөрүүг тодруулах зорилгоор Mitsubishi Corp/Chiyoda Corp JV-тэй уулзалт зохион байгуулж, үнэлгээний хороо болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөллийг БНСУ-д томилолтоор ажиллуулж туслан гүйцэтгэгч Samsung компанийн боловсруулсан өртгийн нарийвчилсан задаргаа, тооцоололтой танилцан, хэлэлцээр хийсний үндсэн дээр гэрээний үнийн дүнг 44.9 тэрбум иен байх боломжтой³⁸ гэж үзжээ.

³⁵ 1. Тайсэй- Ниппо ДНС түншлэл, 2. ЖФЕ инженеринг, 3. Матрикс ХХК, 4. YDA /Турк улсын компани/ 5. Ниппо, 6. Сокикаку сэккэй, 7. Фүкүда корпорац

³⁶ Япон Улсын Ниппо компанийн санал болгосон голлох боловсон хүчний мэдлэг болон туршлага шаардлага хангаагүй, тоног төхөөрөмжийн бололцоо хангалтгүй, бетон болон асфальтан хучилтын ажлуудыг өвлийн цагт гүйцэтгэхээр төлөвлөсөн зэрэг үндэслэлүүд

³⁷ Instructions to Bidders Bid Data Sheet ITB 35.2, Evaluation Guide for Prequalification and Bidding under JBIC ODA Loans: JBIC June 2000 (amended 2007) Section III item 2.2

³⁸ ТУХ-ны 2013.04.03-ны хурлын тэмдэглэлд: "Хэлэлцээрийн явцад оролцогч талууд удирдамжид заасан дүн болох 39.8 тэрбум иенд эцсийн байдлаар хүрсэн боловч гэрээний үнийн дүнд НӨАТ 2.4 тэрбум иен, япон иен ам.доллартой харьцах ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэл болох 2.7 тэрбум иенийг тооцон нэмж оруулснаар 44.9 тэрбум иенээр гэрээг байгуулахаар



2.50 ЖАИКА нь ЗТЯ-аас 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 3/85 дугаар албан бичгээр ирүүлсэн төслийн гэрээ, төслийн цар хүрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг хянан үзэж татгалзах зүйлгүй гэдгээ мэдэгдсэн бөгөөд ЗТС-ын 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 109 дүгээр тушаалаар гэрээнд гарын үсэг зурах эрхийг ИНЕГ-ын даргад зөвшөөрсний дагуу 49.5 тэрбум иений гэрээг 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулжээ.

Хүснэгт 7. Ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дүн /сая иен/

№		Барилга байгууламж, арга хэмжээ	Гэрээний дүн
1	Анхны багцад тусгагдсан	Бэлтгэл ажлын зардал	987.1
2		Зам талбайн ажил	5,876.3
3		Барилга угсралтын ажил	8,794.3
4		Нисэх буудлын тусгай тоног төхөөрөмжүүд	1,619.0
5		Нисэх буудлын тоног төхөөрөмжүүд	970.3
6		Нисэх буудлын мэдээллийн технологи болон аюулгүйн систем	4,772.4
7		Навигацийн систем	1,531.1
8		HD камер	289.3
Дүн			4,839.9
8	Анхны багцад	Шатахуун сумалгааны гидрант систем	4,500.0
9	тусгаадаагүй	Тэнхлэгийн гэрэлтүүлэг	160.0
Дүн			4,660.0
НИЙТ ДҮН			49,499.9

Эх сурвалж: ИНЕГ, "Мицубиши- Чиёода" хамтарсан түншлэлтэй байгуулсан гэрээ

2.51 ЖАИКА болон Олон Улсын зөвлөх инженерүүдийн холбоо /ФИДИК/³⁹ хооронд байгуулсан Зөвшөөрлийн хэлэлцээрийн нөхцөл, шаардлагын дагуу ИНЕГ нь Ерөнхий гүйцэтгэгчтэй "Ягаан ном" буюу ажлын тоо хэмжээ /BOQ/-д үндэслэн тохируулга хийх /re-measurement/⁴⁰ нөхцөлтэй жишиг загварын дагуу тус тус гэрээ байгуулсан байна.

Туслан гүйцэтгэгчдийн сонгон шалгаруулалт Самсунг Си Энд Ти", "Эм Си Эс Проперти" ХХК-ийн дотоод журмын дагуу явагдсан нь өрсөлдөөн олон нийтэд нээлттэй, ил тод явагдах боломжийг хязгаарласан байна

2.52 Мон-Пи8, Мон-Пи12 зээлийн гэрээнд зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Бараа болон үйлчилгээ /зөвлөх үйлчилгээнээс бусад/-г худалдан авах ажиллагаатай холбоотой шийдвэрийг ЯОУХАБ/ЖАИКА хянан үзэж зөвшөөрөл өгөх зохицуулалтыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- 2008 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан МОН-Пи8 зээлийн гэрээний "Худалдан авах журам"-д "Энгийн төрлийн болон бусад ажил" ангиллаар гэрээг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх бол Зээлдэгч дараах баримт материалыг банкаар хянуулж, зөвшөөрөл авах:
 - (1) Таван зуун сая иенээс багагүй үнийн дүнтэй гэрээний хувьд:
 - Олон улсын өрсөлдөөнт тендерээс бусад журмыг баримтлах хүсэлтэй бол худалдан авах арга,
 - Урьдчилсан сонгон шалгаруулалтын компаниудын нэрс, сонгон шалгаруулалтын тайлан, сонголт хийсэн үндэслэл, үр дүн,
 - Эрх олгох тухай санал,
 - Гэрээний баталгаажсан хувь болон гэрээг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт,

2 тал тохиролцоонд хүрээд байна. Хэлэлцээрийн явцад НӨАТ болох 2.4 тэрбум иенийг Сангийн яамтай харилцан тохиролцож хасах хувилбараар гаргасан бөгөөд Хэлэлцээрийн явцад Сангийн яамны зүгээс НӨАТ-ыг гэрээний дүнд оруулан тооцох нь зүйтэй гэсэн чиглэл өгснөөр буцаан нэмж байгаа болно. Энэ дүнг бүтээн байгуулалтын жилүүдэд туслан гүйцэтгэгчдийн төлөх татвараар дамжин МУ-ын төсөвт эргэн орох хөрөнгө гэдгийг дурдах нь зүйтэй. Хэлэлцээрийн явцад тохироод байгаа дүнг Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар танилцуулан дэмжсэн." гэжээ.

³⁹ Дэд бүтэц, эрчим хүч, барилгын салбарын бүтээн байгуулалтын томоохон төслүүдэд ФИДИК буюу Олон Улсын зөвлөх инженерүүдийн холбооноос гаргасан гэрээний жишиг баримт бичгүүдийг ашиглах явдал түгээмэл байдаг байна.

⁴⁰ Re-measurement- тохируулгын гэрээнд нэгжийн үнэ өөрчлөгдөхгүй тогтмол бөгөөд гүйцэтгэх явцад Ажлын тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнд өөрчлөлт ордог онцлогтой.

Lump sum- хатуу үнэ тогтоох гэрээнд талууд гэрээний үнийг тохиролцож, гүйцэтгэх явцад ажлын тоо хэмжээний өөрчлөлтөөс үл хамааран анхны үнийн дүнгээр ажлыг гүйцэтгэн хүлээлгэж өгдөг онцлогтой.



- (2) Нэг тэрбум иенээс багагүй үнийн дүнтэй гэрээний хувьд:
- (1)-г мөрдөхийн зэрэгцээ урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг,
- (3) Гурван тэрбум иенээс багагүй үнийн дүнтэй гэрээний хувьд ...,
- (1), (2)-г мөрдөхийн зэрэгцээ тендерийн баримт бичиг,
- (4) Таван тэрбум иенээс багагүй үнийн дүнтэй гэрээний хувьд ...,
- Гэрээний баталгаажсан хувь болон гэрээг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт,
- 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулагдсан МОН-Пи12 зээлийн гэрээний “Худалдан авах журам” 3 дугаар хэсэг “Зам барилгын ажил болон бусад ажил” ангиллаар гэрээг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх бол Зээлдэгч Зээлдэгч дараах баримт материалыг ЖАИКА-аар хянуулж, зөвшөөрөл авах:
- (1) Нэг тэрбум иенээс бага үнийн дүнтэй гэрээний хувьд:
- гэрээний баталгаажсан хувь болон гэрээг ЖАИКА-аар хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт,
 - Гэрээний үнийн дүнд хийсэн тохируулга,
- (2) Нэг тэрбум иенээс багагүй боловч гурван тэрбум иенээс бага үнийн дүнтэй гэрээ, (3) Гурван тэрбум иенээс багагүй үнийн дүнтэй гэрээний хувьд:
- Олон улсын өрсөлдөөнт тендерээс бусад журмыг баримтлах хүсэлтэй бол худалдан авах арга,
 - Урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичиг,
 - Урьдчилсан сонгон шалгаруулалтын компаниудын нэрс, явцын тайлан, сонголтын шалтгаан үндэслэл, холбогдох бүр баримт материал, сонгон шалгаруулалтын үр дүн,
 - Тендерийн баримт бичиг,
 - Нэг үе шат, хоёр дугуй бүхий тендерийн журмыг баримтлах бол үнийн саналыг нээх зөвшөөрөл,
 - Тендерийн саналд хийсэн дүн шинжилгээ, эрх олгох тухай санал,
 - Хэлэлцээр хийх хүсэлт,
 - Гэрээний баталгаажсан хувь болон гэрээг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт,
 - Гэрээний үнийн дүнд хийсэн тохируулга.

2.53 Төслийн Ерөнхий гүйцэтгэгч нь ажил, үйлчилгээ үзүүлэх нийт 46.8 тэрбум иений үнийн дүн бүхий 10 гэрээг туслан гүйцэтгэгч компаниудтай 1.2 тэрбум иений үнийн дүн бүхий бараа, тоног төхөөрөмж нийлүүлэх нийт 5 гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Ерөнхий гүйцэтгэгчийн 2013 онд боловсруулсан тендерийн баримт бичигт “Самсунг Си Энд Ти” ХХК нь туслан гүйцэтгэгч компаниар ажиллахаар тусгагдаж 2012 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр санамж бичиг байгуулсан бөгөөд Ерөнхий гүйцэтгэгч тендерт шалгарсантай холбогдуулан барилгын ажил гүйцэтгэх 44.7 тэрбум иений үнийн дүн бүхий гэрээг 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан,
- Ерөнхий туслан гүйцэтгэгч “Эм Си Эс Проперти” ХХК-тай 1.8 тэрбум иений үнийн дүн бүхий гэрээг 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр тус тус байгуулсан байна.

2.54 Ерөнхий туслан гүйцэтгэгч “Самсунг Си Энд Ти” ХХК нь 23.1 тэрбум иений үнийн дүн бүхий 108 гэрээг туслан гүйцэтгэгч компаниудтай, “Эм Си Эс Проперти” ХХК нь 1.1 тэрбум иений үнийн дүн бүхий 203 гэрээг дэд туслан гүйцэтгэгч компаниудтай байгуулжээ.

Хүснэгт 8. Ажил, үйлчилгээ худалдан авсан гэрээний тоо

№	Компани	Гэрээний үнийн дүн									
		500.0 сая иен хүртэл		500.0 сая иенээс их		1.0 тэрбум иенээс их		3.0 тэрбум иенээс их		Нийт	
		Үнийн дүн	Гэрээний тоо	Үнийн дүн	Гэрээний тоо	Үнийн дүн	Гэрээний тоо	Үнийн дүн	Гэрээний тоо	үнийн дүн	Гэрээний тоо
		“Самсунг Си Энд Ти” ХХК									
1	Ажил, үйлчилгээ	7,497.4	72	5,199.5	7	3,707.1	3	-	-	23,118.6	108
2	Бараа, тоног төхөөрөмж	-	-	3,565.3	23	1,365.8	2	1,783.5	1		
	Нийт	7,497.4	72	8,764.80	30	5,072.90	5	1,783.50	1		
		“Эм Си Эс Проперти” ХХК									
1	Ажил, үйлчилгээ	627.5	142	-	-	-	-	-	-	1,127.5	203
2	Бараа, тоног төхөөрөмж	500.0	61	-	-	-	-	-	-		
	Нийт	1,127.5	203	-	-	-	-	-	-		

Эх сурвалж: “Samsung C&T” ХХК, “Эм Си Эс Проперти” ХХК

2.55 Барилгын ажил гүйцэтгэх гэрээнд дагаж мөрдөх хууль Монгол Улсын хууль байхаар заасан хэдий ч туслан гүйцэтгэгчдийн сонгон шалгаруулалт олон нийтэд нээлттэй, ил тод өрсөлдөөнтэй явагдах эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгаагүйгээс ерөнхий туслан гүйцэтгэгч “Самсунг Си Энд Ти” ХХК, “Эм Си Эс Проперти” ХХК-иуд ТБОНӨХБАҮХАТХ-ийг



мөрдөөгүй, худалдан авалтын дотоод журмын⁴¹ дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

2.56 Төслийн ерөнхий туслан гүйцэтгэгч компаниуд нь дэд туслан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг хязгаарлагдмал тендерийн хэлбэрээр зохион байгуулж, “*барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ*”-ний Ерөнхий нөхцөлийн 4.4 (a),(b)⁴²-д заасны дагуу зөвлөхөд санал болгож буй компанийн жагсаалтыг чадавхын мэдээллийн хамт хянуулахаар хүргүүлж байжээ.

2.57 Төслийн Зөвлөх ирүүлсэн жагсаалт, холбогдох баримт материалыг хянаж шаардлага хангасан эсэхийг компани тус бүрээр тэмдэглэн хариу хүргүүлж, ерөнхий туслан гүйцэтгэгч шаардлага хангасан компаниудын үнийн саналыг үнэлэх замаар дэд туслан гүйцэтгэгчийг сонгон гэрээ байгуулж ирсэн байна.

2.58 Барилгын ажил гүйцэтгэх гэрээнд туслан гүйцэтгэгчийг сонгох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт тусгагдаагүй нь МОН-Пи8, МОН-Пи12 зээлийн гэрээнд заасан худалдан авалт хийхэд баримтлах журам хэрэгжихгүй байх нөхцөл үүсэхэд хүргэжээ.

2.59 Захиалагчийн хувьд Ерөнхий гүйцэтгэгчтэй нийт дүнгээр гэрээ байгуулсан учир туслан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаас тендерийн хэмнэлт үүсэх боломжгүй хэдий ч ТХН-ийн ажилтны хамаарал бүхий компани ажил гүйцэтгэсэн тохиолдол гарсан нь дэд туслан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт нээлттэй, өрсөлдөөнтэй явагдаагүй байх эрсдэлтэй байсныг харуулж байна. Тухайлбал:

- *ТХН-ийн ерөнхий инженерийн хамаарал бүхий Вортекс ХХК нь 2015 оны 8 дугаар сард ерөнхий туслан гүйцэтгэгч Самсунг Си энд Ти ХХК-тай 2,051.7 сая төгрөгийн /үндсэн гэрээ, 2 нэмэлт гэрээний хамт/ үнийн дүн бүхий будгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 1,974.2 сая төгрөгийн санхүүжилт авсан.*

⁴¹ Samsung C&T Overseas subcontracting Work Manual 2016 3.00

“Эм Си Эс Проперти” ХХК “Худалдан авалтын үйл ажиллагааны журам” IMS-P003_ver3.0

⁴² Гэрээний Ерөнхий нөхцөл 4.4 Туслан гүйцэтгэгч. Гүйцэтгэгч ажлыг бүхэлд нь туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх ёсгүй. Туслан гүйцэтгэгчийн аливаа буруутай үйлдэл, алдааны хариуцлагыг ерөнхий гүйцэтгэгч өөрийн гаргасан алдаа, дутагдал мэт хүлээнэ. Гэрээний тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол:

(a) Гүйцэтгэгч нь зөвхөн материал нийлүүлэх эсхүл гэрээнд заасан туслан гүйцэтгэгчийг ажиллуулахад зөвшөөрөл авах шаардлагагүй.

(b) Гэрээнд заагаагүй өөр туслан гүйцэтгэгч ажиллуулахаар бол инженерийн зөвшөөрөл авсан байна.

Гүйцэтгэгч нь гэрээний 1.12 дэд зүйлд [Нууцлал] тавигдсан шаардлагыг мөрдөх баталгаа өгөх ба туслан гүйцэтгэгч бүр энэ шаардлагыг адил тэнцүү дагаж мөрдөнө. Ерөнхий гүйцэтгэгч нь тухайн орны гүйцэтгэгч компаниудад туслан гүйцэтгэгчээр ажиллах боломж олгоно.



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ЦАР ХҮРЭЭ ӨРГӨЖИЖ, ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДСЭН, НЭМЭЛТ БАРИЛГЫН АЖЛУУДААС ТӨСЛИЙН ХУГАЦАА СУНГАГДСАН, ЗАХИАЛАГЧИЙН ҮҮРЭГ, ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙЖЭЭ.

Захиалагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна

3.1 ЗТБХБС-ын 2008 оны 50 дугаар тушаалаар “Төслийн удирдах хороо”⁴³-г 16 хүний бүрэлдэхүүнтэй, 2009 оны 215⁴⁴, 2012 оны 117⁴⁵, ЗТС-ын 2015 оны 92, 2016 оны 05,127 дугаар тушаалаар тус тус ТУХ-г шинэчлэн байгуулж, хороо нь төслийг хуваарийн дагуу хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, улирал, хагас жил тутмын хэрэгжилтийн явцыг ЗТБХБС, ЗТС-ын зөвлөлд танилцуулж байсан эсэх нь тодорхойгүй /аудитын явцад баримт ирүүлээгүй/ байна.

3.2 ТУХ 2009-2018 оны хооронд нийт 19 удаа хуралдсан, 2012 онд хуралдаагүй⁴⁶, 1 жилд дунджаар 2 удаа хуралдсан нь Сангийн Сайдын баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 8.4-т⁴⁷ “...ТУХ нь улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдаж төслийн хэрэгжилтийн явцыг авч хэлэлцэх...”, 7.2.1-т⁴⁸ “...зээл, тусламжийн хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол ТУХ нь улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдах”, 15.9-т⁴⁹ “...энэхүү журмын 11.1.3-11.1.5-д заасан асуудлыг хэлэлцэхээр тогтсон хугацаанд, бусад асуудлаар шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдана” гэж зааснаар жилд дунджаар 4 буюу түүнээс дээш хуралдаж байх үүргээ бүрэн биелүүлээгүй байна. /дэлгэрэнгүйг хавсралт 2/

3.3 ТУХ нь ТХН-ийн 2013 оны 1 дүгээр улирал, эхний хагас жил, жилийн эцсийн тайлан, 2014 оны 1 дүгээр улирал, жилийн эцсийн, 2015 оны 1 улирал, эхний хагас жилийн үйл ажиллагааны ажлын тайланг хэлэлцэж “хангалттай” гэсэн үнэлгээг өгсөн ч тухайн хугацааны үйл ажиллагааны болон нарийвчилсан төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрэх түвшин, тоо хэмжээтэй харьцуулж үнэлсэн үнэлгээгүй, хяналт хэрхэн хэрэгжсэн нь тодорхой бус байна.

3.4 ИНЕГ нь Мон-Пи8, Мон-Пи12 зээлийн гэрээнд “хэрэгжүүлэгч агентлаг”, “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх”⁵⁰ гэрээнд “Ажил олгогч”, “Барилгын ажлыг гүйцэтгэх”⁵¹ гэрээнд “Захиалагч”-ийг тус тус төлөөлсөн байхад ЗТБХБЯ, Сангийн Яам нь дээрх гэрээнүүд дэх ИНЕГ-ын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож удирдлага зохион байгуулалтаар хангаагүй, гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, хяналтыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан байна. Тухайлбал:

- ИНЕГ-аас 2009 онд⁵² Сангийн дэд сайд, ЗТБХБС-д тус тус хүргүүлсэн албан бичигт ...зээлийн хэлэлцээрийн дагуу төслийг хэрэгжүүлэгч байгууллагаар ИНЕГ-ыг тогтоосон..., ...төсөл хэрэгжүүлэх нэгжийг иргэний нисэхийн болон шаардлагатай бусад мэргэжлийн удирдлага, ажилтнуудаар бүрдүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, хяналт, зохион байгуулалт, дэмжлэгээр хангах үүргийг ИНЕГ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх саналтай... гэж ,
- 2011 онд⁵³ ЗТБХБС-д хүргүүлсэн албан бичигт ...ИНЕГ нь Засгийн газар, Сангийн яам болон ЗТБХБЯ-аас тодорхойлсон эрхийн хүрээнд, яамны удирдлага дор төслийг хэрэгжүүлэгч болон мэргэжлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэн ажиллах үүрэгтэй боловч энэ чиг үүргээ хэрэгжүүлэх боломж өнөөдрийн байдлаар бүрдээгүй... гэж дурдсан байхад арга хэмжээ аваагүй байна.

⁴³ Сангийн Сайдын 2007.05.07-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журмын 3.1.9-т Төслийн удирдах хороо /ТУХ/ нь зээлийн гэрээ болон холбогдох бусад баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдамжаар хангах, зээлийн хөрөнгийг зөвхөн тухайн төслийн зорилгоор ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих, Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг дүгнэх, макро түвшинд болон яам, салбар хоорондын үйл ажиллагаатай холбоотой уялдааг зохицуулах үүрэг бүхий орон тооны тус нэгж байна.

⁴⁴ Нарийн бичгийн дарга Н.Энхбат /УБ хотын олон улсын нисэх онгоцны шинэ нисэх буудал барих Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал/

⁴⁵ Удирдах хорооны дарга Б.Батзаяа /ЗТБХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч/

⁴⁶ 2012 оны УИХ-ын сонгуулийн дараа бүтэц зохион байгуулалтын ажлууд хийгдэж Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам ба Зам тээврийн яам болгон салгасан байна.

⁴⁷ Сангийн Сайдын 2007 оны 120 дугаар тушаалаар баталсан журам

⁴⁸ Сангийн Сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар баталсан журам

⁴⁹ Сангийн Сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан журам

⁵⁰ 2009 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан

⁵¹ 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан

⁵² ИНЕГ-ын 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 1/1536 дугаар, 1/1537 дугаар албан бичиг

⁵³ ИНЕГ-ын 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/3488 дугаар албан бичиг



- Сангийн сайдын 2009 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 4/3676 дугаар, 2009 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 4/4154 дугаар ИНЕГ-т хүргүүлсэн албан бичигт ...Төслийн үйл ажиллагаа идэвхжих үед төслийн нэгжийн тогтвортой, бие даасан хариуцлагатай үйл ажиллагааг хангах зорилгоор орон тоог бүрэн хэмжээгээр бие даасан нэгж болгон томилон ажиллуулах, ...төслийн болон нэгжийн удирдлага зохион байгуулалтын асуудлыг СЯ-аас гадна ТУХ-нд тавьж шийдвэрлүүлж байх, ...ИНЕГ нь ЗТБХБЯ-ны хяналт дор төслийг хэрэгжүүлж, тус яамны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ТУХ төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг үнэлэх ёстой..., гэж хариу хүргүүлж байсан.

3.5 ИНЕГ нь ЗТХЯ-аас өгсөн чиглэлийн дагуу⁵⁴ 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Зөвлөх үйлчилгээний үндсэн гэрээний⁵⁵ хэрэгжилтийг 8 жил 7 сарын дараа, Зөвлөх үйлчилгээний нэмэлт гэрээ №1⁵⁶-ийн хэрэгжилтийг 2 жил 3 сарын дараа үнэлж дүгнэхдээ ажил үйлчилгээний биелэлтийг ямар шалгуурт харьцуулсан нь тодорхойгүй, Зөвлөх компани, ТХН-ийн саналтай харьцуулж үнэлгээг хувиар гаргасан байна.

Хүснэгт 9. Зөвлөх үйлчилгээний гэрээ дүгнэсэн судалгаа /хувиар/

№	Ажил үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээний үндсэн гэрээний хэрэгжилт /2009.06.18/			Зөвлөх үйлчилгээний нэмэлт гэрээ №1-ийн хэрэгжилт /2015.09.11/		
		Зөвлөх	ТХН /санал/	ИНЕГ /үнэлгээ/	Зөвлөх	ТХН /санал/	ИНЕГ /үнэлгээ/
1	Барилгын зураг төсөл болон тендерийн бичиг баримтыг боловсруулах	100%	100%	100%	100%	100%	100%
2	Тендерийн хэлэлцээрт тусламж дэмжлэг үзүүлэх	100%	100%	100%	100%	100%	100%
3	Барилга угсралтын ажлын үеийн хяналт хийх 15 ажил үйлчилгээг нэг бүрчлэн үнэлсэн	100%-13 90%-2	100%-11 90-95%-4	80%-5 60%-6 50%-4	100%-9 98-99%-3 80%-2 50%-1	100%-10 98-99%-2 80%-1 75%-1 50%-1	100%-10 98-99%-2 80%-1 75%-1 50%-1
Дундаж үнэлгээ				70.76%			99.37%

Эх сурвалж: ИНЕГ-ын гэрээний дүгнэлт, тайлан

3.6 ИНЕГ нь захиалагчийн хувьд зөвлөх үйлчилгээний, барилгын ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг жил бүр үнэлж дүгнэх ажлыг хийж ирээгүй, ТУХ-нд талуудын гэрээний үр дүнг танилцуулах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, санхүүжилтийг хянах, тооцоо нийлж баталгаажуулах ажлыг хийгээгүй байна.

3.7 МОН-Пи8 зээлийн гэрээнд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах талаар тусгаагүй байхад Сангийн сайд 2009 оны 211 дүгээр тушаалаар ТХН-ийн орон тоо, цалин, үйл ажиллагааны зардлыг баталсан нь Сангийн Сайдын баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журмын” 6 дугаар зүйлийн 6.1⁵⁷, 2 дугаар зүйлийн 2.1-т “...зээлийн хэлэлцээрт энэхүү журамд зааснаас өөрөөр заасан тохиолдолд Олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” заасантай нийцээгүй шийдвэр гаргасан тул цаашид дээрх журмыг зөв хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- ТУХ-ны 2009 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн №1 дугаар хуралдаанаар ТХН-ийн бүтэц, санхүүжилтийг хэлэлцсэн ч эцэслэн шийдвэрлээгүй нээлттэй үлдээсэн, дараа дараагийн хурлаар уг асуудлыг хэлэлцээгүй, эцсийн шийдвэр гаргаагүй байна,
- ЗТБХБЯ-ны 2009 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 4/3160 дугаар Сангийн Яамд хүргүүлсэн албан бичигт ...зээлийн хэлэлцээр /Мон-Пи8/, холбогдох талуудын уулзалтын тэмдэглэл болон Сангийн сайдын 2007 оны 120 дугаар тушаалын дагуу ТХН-ийн бүтэц, орон тоог санхүүжилтийн саналын хамт хүргүүлэв... гэж дурдсан нь Мон-Пи8 зээлийн гэрээнд тусгаадаагүй саналыг гаргасан байна⁵⁸,

⁵⁴ ЗТХЯ-ний 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/337 дугаар ИНЕГ-т хүргүүлсэн албан бичигт ...Улаанбаатар хотын ОУНОШБ барих төслийн Зөвлөх талын үйлчилгээ үзүүлэх гэрээ” болон түүнд оруулсан 1 дүгээр нэмэлт гэрээний хэрэгжилтийг дүгнэж, ажлын гүйцэтгэлийг гаргах, ...шатахууны байгууламжийн туршилт тохируулга, зам гүүр болон нэмэлт барилга байгууламжийн ажлуудын гүйцэтгэл удааширсан шалтгааныг тодорхойлох...

⁵⁵ 2009 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан

⁵⁶ 2015 оны 09 дүгээр сарын 11-ны өдөр байгуулсан

⁵⁷ Гэрээ, хэлэлцээрт төслийн нэгжийг байгуулах тухай тусгасан тохиолдолд түүний бүтэц, орон тоо, цалин, үйл ажиллагааны зардал зэргийг... гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батална

⁵⁸ Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1. “Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг хүлээн авах, ашиглах, тайлагнах үе шатанд тавих ерөнхий хяналтыг гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, өдөр тутмын хяналтыг холбогдох салбарын яам тус тус тавина.



3.8 ТХН-ийн албан тушаалын 4 орон тоог Сангийн сайдын 2009 оны 211 дүгээр тушаалаар баталснаас хойш 2014 оны 136 дугаар тушаалаар албан тушаал, орон тоог 26 болгож шинэчлэн батлахаас өмнө ЗТБХБЯ /хуучнаар/-ны ТНБД-ын 2009-2013 оны тушаалаар ТХН-ийн холбогдох албан тушаалд 2008 онд 2, 2009 онд 8, 2010 онд 8, 2012 онд 1, 2013 онд 5 ажилтныг томилсон нь тухайн орон тоо, албан тушаал батлагдаагүй байхад томилж, ТХН илүү орон тоогоор ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.9 ТХН⁵⁹ нь улсын бүртгэлд бүртгэгдээгүй, Иргэний Нисэхийн Ерөнхий газар гэсэн нэр бүхий хэвлэмэл хуудас, МОН-Пи8 тэмдэг ашиглаж, ЗТЯ-ыг төлөөлж холбогдох гэрээнд гарын үсэг зурсан нь эрх мэдлээ хэтрүүлсэн, захиалагч ИНЕГ-ын өмнөөс өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- ТХН-ийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 845 дугаар ЗТХЯ-нд хүргүүлсэн албан бичигт "...ерөнхий гүйцэтгэгчийн гэрээнд нэмэлт өөрчлөлт №1 оруулах үйл ажиллагааг яаралтай зохион байгуулж бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлнэ үү... гэж дурдсан нь Барилгын ажил гүйцэтгэх гэрээний захиалагч ИНЕГ-ын эрхийг хэрэгжүүлэх хүсэлтийг уламжилсан,
- ЗТЯ, Мицубиши-Чиёода хамтарсан түншлэлийн хооронд 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан "Нэмэлт гэрээ"-нд ЗТЯ-ыг төлөөлж ТХН-ийн захирал Н.Энхбат гарын үсэг зурсан.

3.10 ТХН нь төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулан оролцож, хяналт тавин, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх, барилгын ажил гүйцэтгэх сар бүрийн ажлын дэлгэрэнгүй тайланг талуудаас гаргуулан авч, төслийн хэрэгжилтийн болон ТХН-ийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн ЗТХЯ, СЯ, ИНЕГ, ЖАИКА байгууллагад тухай бүр хүргүүлж, нэгжийн үйл ажиллагааны улирал, жилийн ажлын тайланг ТУХ-нд тайлагнах үүргээ бүрэн хэрэгжүүлж ирсэн байна.

3.11 ЗТС-ын 2014 оны 191 дүгээр тушаалаар "Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх үүрэг бүхий "Шинэ нисэх буудлын Ашиглалтын өмнөх удирдах хороо"-г байгуулсан бөгөөд АӨУХ-ны үйл ажиллагаа ямар журмаар явагдаж ирсэн зохицуулалт тодорхойгүй байна.

Төслийн цар хүрээ өргөжсөнөөс Зөвлөх болон Ерөнхий гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх гэрээний хугацаа хойшилсон байна

3.12 Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2009 оны 06 дугаар сарын 18-ны өдөр ИНЕГ /ажил олгогч/⁶⁰, зөвлөхтэй⁶¹ нийт 1,920.9 сая иений⁶² дүнтэй анхны гэрээг⁶³ төслийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн болон техникийн ажил үйлчилгээ үзүүлэх чиглэлтэй байгуулагдаж, гэрээнд 3 удаа нэмэлт өөрчлөлт / 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр⁶⁴ гэрээний нэмэлт өөрчлөлт №1⁶⁵, 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр гэрээний нэмэлт өөрчлөлт №2, 2018 оны 12 дугаар сарын 11-ны өдөр⁶⁶ гэрээний нэмэлт өөрчлөлт №3 / орсон байна.

⁵⁹ Сангийн сайдын 2007.05.07-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журмын 3.1.7-т Төслийн нэгж гэж төслийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, Зээлийн гэрээ болон холбогдох бусад баримт бичигт заасан ажлыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх ажлыг хангах зорилгоор байгуулагдсан орон тооны нэгжийг хэлнэ... гэж заасан байна.

⁶⁰ Гэрээ байгуулах зөвшөөрлийг ЗТБХБС 2009 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1/232 тоот албан бичгээр ИНЕГ-ын орлогч захирал П. Мөнхжаргалд олгосон

⁶¹ Зөвлөх талын гишүүд бүрийн нэрийн өмнөөс Азуса Секкей үйл ажиллагааны ажилтан Осаму Хорагучи, Ориентал Зөвлөхийн Нисэх онгоцны хэлтсийн төслийн ахлах менежер Кикио Ватанае нар гарын үсэг зурсан.

⁶² Гадаад төлбөрийн хэмжээ 1,834,727.000 японы иен, дотоод төлбөрийн хэмжээ 1,365,281.000 төгрөг буюу төслийн нийт төлбөр +нь гадаад ба дотоод төлбөрийн хэмжээний нийлбэр дүн иений ханш 15,83 ₮ -тэй тэнцэх үнийн дүнтэй 1,920,973.000 япон иен байна. Нийт үнийн дүнд төлөвлөгдөөгүй зардлуудыг оруулаагүй.

⁶³ ИНЕГ-ын удирдлагын нэрийн өмнөөс орлогч захирал П. Мөнхжаргал, ЗТБХБЯ-ы ТНБД Ж.Бат-эрдэнэ нар гарын үсэг зурсан.

⁶⁴ Гэрээнд захиалагч ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбилэг, гэрч ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-эрдэнэ, зөвлөх талыг төлөөлж "Азуса Секкей" ХХК-ийн ерөнхий архитектор Осаму Харагучи, "Ориентал консалтантс глобал" ХХК-ний төслийн менежер Кимихиро Маэта нар гарын үсэг зурсан.

⁶⁵ ИНЕГ, "Азуса Секкей" ХХК "Ориентал консалтантс глобал" ХХК-ний хамтарсан түншлэл хооронд

⁶⁶ ИНЕГ /ЗТХЯ-ны 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 03/5872 дугаар албан бичгээр ИНЕГ-ын даргад нэмэлт гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг олгосон/, Азуса Секкей/Ориентал консалтантс глобал хамтарсан түншлэл хооронд



Хүснэгт 10. Зөвлөх үйлчилгээний гэрээний мэдээлэл

№	үзүүлэлт	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн		Нийт дүн /сая.иен/
			Гадаад төлбөр /сая.иен/	Дотоод төлбөр /сая.төгрөг/	
1	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ	2009.06.18	1,834.7	1,365.3	1,920.9
2	Гэрээний нэмэлт өөрчлөлт №1	2015.09.11	1,399.4	651.5	1,443.0
3	Гэрээний нэмэлт өөрчлөлт №2	2018.04.25	329.6	370.0	346.5
4	Гэрээний нэмэлт өөрчлөлт №3	2018.12.11	582.1	-	582.1
	Гэрээний нийт үнэ		4,145.8	2,386.8	4,292.5

Эх сурвалж: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ

3.13 Зөвлөх үйлчилгээний анхны гэрээ болон нэмэлт гэрээгээр хийгдэх үндсэн ажлуудыг дурдвал,

- **Зөвлөхийн анхны гэрээнд:** Зөвлөх нь барилгын гэрээний загвар болон тендерийн бичиг баримтуудыг бэлтгэх, барилгын гэрээний үнийн хэлцэлд, хүрээлэн буй орчны удирдамжид, холбоо хамааралтай төслүүдэд зохицуулалт хийхэд, ЖАИКА-д тайлан мэдээ явуулахад, нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг саадгүй эхлүүлэх болон үйл ажиллагааг нь сайжруулахад тус тус тусламж дэмжлэг үзүүлэх, барилгын хяналт, шалгалт, алдаа дутагдалд хүлээх үүрэг хариуцлагад хяналт шалгалт хийх чиглэлээр үйлчилгээ үзүүлэх,
- **Гэрээний нэмэлт №1-м⁶⁷:** ...
а1/. Анхны гэрээнд тусгагдсан ажлуудын зураг төсөл боловсруулахад хугацаа сунжирсан, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалт удаа дараа амжилтгүй болсонтой холбоотойгоор тендер шалгаруулалтын явц удааширсан, а2/. Гүйцэтгэгчийн төлөвлөгөөнд нийцүүлэн ажлаа тохируулах, б/. Зорчигч үйлчилгээний барилга холбогдох гүүрэн байгууламж, Нүүрсээр галлах зуух бүхий дулааны систем, Агаарын хөлгийн шатахуун сумалгааны систем, Автомашины дулаан гарааш, Газрын үйлчилгээний машин механизмын барилга зэрэг нэмэлт ажлуудын зураг төсөл боловсруулах болон тэдгээрийн барилгын ажилд хяналт тавих, с/. а/ болон б/ заалтуудтай холбогдон гарах үндсэн зардлыг шинэчлэх, д/. Үнийн өсөлт болон тогтсон ханш... гэж нэмэлтээр тусгасан,
- **Гэрээний нэмэлт гэрээ №2-м** ...а/. Ангaрын барилгын зураг төсөл /дизайн/ боловсруулах болон барилгын ажлын үлдсэн хэсэгт хяналт тавих, б/. Үндсэн болон нэмэлт гэрээний ажлуудын баталгаат засварын хугацааны хяналт, с/. Нэмэлт барилгын ажлын хяналтыг үргэлжлүүлэх... гэж нэмэлтээр тусгасан,
- **Гэрээний нэмэлт №3-м:** ...эцсийн төлбөр нь ЖАИКА-ын шаардлагын дагуу 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор хийгдэх ёстой, Зөвлөх эцсийн төлбөрийн нэхэмжлэхийг 2020 оны 3 сард гаргах бөгөөд үүндээ 2020 оны 4 сараас 12 саруудад төлөвлөсөн хүн/сарыг багтаана.

3.14 Зөвлөхийн гэрээнд “Зөвлөх үйлчилгээ эхэлснээс хойш 14 сарын дотор⁶⁸ худалдан авах ажиллагааны баримт бичиг, урьдчилсан болон нарийвчилсан зураг төслийг дуусгахаар заасан ч зөвлөх нь 21 сарын хугацаанд буюу гэрээнд зааснаас 7 сараар хугацаа хоцроосон нь ЖАИКА-аас ОУНОШБ-ын ерөнхий төлөвлөлтийн өртгийг багасгаж тооцох тухай санал дэвшүүлснийг үндэслэн нарийвчилсан зураг төслийн зарим ажлуудыг түр зогсоосонтой⁶⁹ холбоотой байна.

- ТУХ-ны 2010.09.23-ны өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлд ... ЖАИКА-аас УБ хотын ОУНОШБ-ын ерөнхий төлөвлөлтийн өртгийг багасгаж тооцох тухай санал дэвшүүлснийг үндэслэн нарийвчилсан зураг төслийн зарим ажлуудыг түр зогсоож /2010.04.25-аас 2010.08.05-ыг хүртэл/, шинэ нисэх буудлын ерөнхий төлөвлөлтийг хянах, төслийн өртгийг хэрхэн бууруулах талаар Зөвлөх компанийн хамт санал боловсруулах...,
- ИНЕГ-ын 2011.09.05-ны өдрийн 01/2278 дугаар “ЗТБХБС-д хүргүүлсэн албан бичигт ...Зөвлөх байгууллагын зураг төслийг эцэслэн батлуулах ажил 5 сарын хугацаагаар хойшилсон, ...тендер зарлах, материал хүлээн авах ажил 3 сарын хугацаагаар буюу төлөвлөсөн хугацаанаасаа нийт 8 сараар хойшлогдон удааширч байгаа..., ...дахин хугацааг сунгахгүй байх, улмаар төлөвлөсөн хугацааг барих талаар арга хэмжээ авч,... гэж дурдсан байна.

3.15 Зөвлөх нь “Барилгын ажил гүйцэтгэх гэрээний үнийн хэлцэлд тусламж дэмжлэг үзүүлэх ажил”-ыг 13 сарын хугацаанд⁷⁰ гүйцэтгэх байтал⁷¹ 34 сар буюу 2 жил 10 сарын хугацаанд гүйцэтгэсэн нь Японы гүйцэтгэгч компаниуд уг төсөлд оролцох сонирхолгүй байсан, худалдан авах ажиллагааны баримт бичгийг 3 удаа боловсруулсан зэргээс шалтгаалсан байна.

⁶⁷ MON-P8 зээлийн гэрээ болон MON-P12 зээлийн гэрээнүүдийг нэгтгэсний дагуу⁶⁸ 2009.08.01-2010.10.01-ний хооронд⁶⁹ 2010 оны 4 сарын 25-ны өдрөөс 2010 оны 8 сарын 5-ны өдрийн хооронд⁷⁰ 15.5 сар /2.5 сартай давхацсан хугацаа, эхлэх хугацаа 2010.07.15,⁷¹ ЖАИКА тендерийн эцсийн баримт бичгүүдийг 2011 оны 5-р сарын дундуур баталгаажуулж Худалдан Авах Ажиллагаа 2011 оны 6 дугаар сарын 01-нд эхлээд 13 сарын дараа буюу 2012 оны 7-р сарын 01-нд дуусна.



3.16 Барилгын ажил гүйцэтгэх гэрээг захиалагч ИНЕГ, ерөнхий гүйцэтгэгчтэй 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр анх гэрээг байгуулж, гэрээний нэмэлт №1-ийг 2017 оны 03 дугаар сарын 17-ний өдөр, гэрээний нэмэлт №2-ийг 2018 оны 12 дугаар 11-ний өдөр тус тус байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 11. Барилгын ажил гүйцэтгэх гэрээний мэдээлэл

№	үзүүлэлт	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн		Нийт дүн /сая.иен/
			сая.иен	сая.төгрөг ⁷²	
1	Барилгын ажил гүйцэтгэх гэрээ	2013.05.10	20,262.9	513,695.1	49,499.9
2	Гэрээний нэмэлт №1	2017.03.17	6,026.3	31,165.7	7,680.9
3	Гэрээний нэмэлт №2	2018.12.11	5,145.9	-	5,145.9
	Гэрээний нийт үнэ		31,459.9	544,860.8	62,351.7

Эх сурвалж: Барилгын ажил гүйцэтгэх гэрээ

3.17 Барилгын ажил гүйцэтгэх анхны гэрээгээр ажил гүйцэтгэж дуусгах хугацаа 1290 хоног буюу албан ёсоор 2013 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс тоолж эхэлсэн бөгөөд барилгын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2013 оны 06 дугаар сарын 28-ны өдөр иж бүрэн цогцолбор барилга байгууламжид, 2014 оны 06 дугаар сарын 26-ны өдөр 37 барилга байгууламжид, 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 4 барилга байгууламжид, 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр 8 барилга байгууламжид тус тус олгосон байна.

3.18 Барилгын ажлыг гүйцэтгэх нэмэлт гэрээ №1-т магадалшгүй ажлын зардлыг нэмэлт зээлийн дүнд тооцохдоо дахин санхүүжилт дутах эрсдэлээс сэргийлэх зорилгоор 7 хувиар тооцож 2.63 тэрбум иен /гэнэтийн бодит зардалд 1,629.0 сая иен буюу 5%, Агаарын хөлгийн шатахуун хангамжийн системийн гэнэтийн бодит зардлууд 1,000.0 сая иен/ гэж төслийн өртгийн тооцоог хийсэн үндэслэл тооцоолол нь тодорхой бус⁷³, 2013-2019 оны хооронд нийт 69 “variation order” буюу өөрчлөлтийн захиалга гарч магадалшгүй ажлын зардлаас 1.1 тэрбум иенийг зарцуулсан байна. Тухайлбал:

- “Үерийн хамгаалалтын далангийн ажил”-ыг ЗТБХБЯ, “Боорчи” ХХК-тай 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр улсын төсийн хөрөнгө 2,800.0 сая төгрөгөөр гүйцэтгэх анхны гэрээг байгуулж, гэрээг 2 удаа /2013 он⁷⁴, 2014 он⁷⁵/ сунгаж, уг ажил 5 жил үргэлжилсэн⁷⁶ ч “Боорч” ХХК нь үерийн хамгаалалтын далангийн автозамтай огтлолцож байгаа намагтай хэсгийн 120 метр хэсгийн далангийн 149.3 сая, хөрс солих нэмэлт 72.3 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй⁷⁷, “Самсунг Си энд Си” ХХК нь “Боорчи” ХХК-ийн гүйцэтгэх үерийн хамгаалалтын далангийн зүүн сувгийн ПК1+260-ПК1+500 хооронд намагтай хэсгийн болон хоолойн сувгийн ажлыг Магадалшгүй ажил буюу Variation Orders /2016 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн/-д 14,557.4 иен буюу 264.4 сая төгрөгөөр⁷⁸ гүйцэтгэн зээлийн хөрөнгөнөөс 42.8 сая төгрөгийг нэмж гаргасан байна.

3.19 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн 13.8-д Монгол Улсын эрх бүхий байгууллагаас жил тутам эмхлэн гаргадаг барилгын бараа, материалын үнийн индексийг үндэслэн гэрээний үнийн дүнд тохируулга хийхээр заасан ч үнийн тохируулгыг хийхдээ ЖАИКА-аас баримталсан тоо хэмжээнд тулгуурласнаар иенээр хийгдэх худалдан авалтын үнийн өсөлтийг 2.0 хувиар, төгрөгөөр хийгдэх худалдан авалтын үнийн өсөлтийг 9.2%-аар тус тус тооцсон байна.

3.20 Сангийн Яам нь төслийн хөрөнгийн зарцуулалтын үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх үүргээ огт хэрэгжүүлээгүй явж ирснээс дотоод хяналт, хариуцлагыг сулруулсан, алдаа зөрчил илрэхгүй байх эрсдэлтэй байна.

⁷² Гэрээний тендерийн ханшийг нэг иен 17.57 төгрөгтэй тэнцүү гэж тооцсон.

⁷³ ЖАИКА, МУ-ын СЯ,ЗТЯ хооронд Улаанбаатар хотын ОУНОШБ барих төсөл/II/-ийн талаар 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хийсэн уулзалтын тэмдэглэлийн төслийн өртгийн тооцоо 2-3-1-т 2014 оны 12 дугаар сард шинэчилсэн байдлаар гаргасан тооцооны нийт дүн

⁷⁴ УБ хотын ОУНОШБ-ын үерийн хамгаалалтын далангийн барилгын ажил /ҮХД-2011-01/-ын гэрээний сунгалт 2013.04.01-ний өдөр №49 дугаар

⁷⁵ УБ хотын ОУНОШБ-ын үерийн хамгаалалтын далангийн барилгын ажил /ҮХД-2011-01/-ын гэрээний сунгалт 2014.05.21-ний өдрийн №68 дугаар

⁷⁶ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 07/03/17 дугаар комиссын актаар хүлээн авсан

⁷⁷ Барилгын ажлыг ашиглалтад оруулах комиссын 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдийн хурлын тэмдэглэлд ... зүүн сувгийн ПК1+260-ПК1+500 хооронд намагтай хэсгийн 214 метр сувгийн ажлыг автозам барилгатай уялдуулан “Самсунг” ХХК нь намагтай хэсгийн болон хоолойн сувгийн ажлыг гүйцэтгэсэн... гэж тэмдэглэсэн байна.

⁷⁸ Монгол банкны 2016.03.24-ний өдрийн хаалтын ханш 1 иен х 18.16 төгрөг/

**Төсөвт өртөгт үнэлгээ, магадлал хийлгэж бодит өртгийг баталгаажуулаагүй байна**

3.21 САПРОФ судалгаанд ОУНОШБ-ын төслийн барилга байгууламжийн төсөвт өртгийг 2006 оны зах зээлийн үнээр төлөвлөж 22.6 тэрбум иенээр тооцжээ. Зорчигч үйлчилгээний барилгын 1 м² квадрат талбайн өртгийг тооцохдоо ЯОУХАБ-ны санхүүжилтээр баригдсан Казакстан улсын Астана хотод баригдсан ОУНОБ-ын Зорчигч үйлчилгээний барилгын 1 м²-ын үнэ болох 210.0 мянган иений өртгийг⁷⁹ жишиг болгосон бөгөөд зээлийг СТЭП нөхцөлтэй гэж үзсэний үндсэн дээр жишиг үнээс 10 хувиар илүү буюу 231.0 мянган иенээр тооцсон байна.

3.22 Зөвлөх анх Ерөнхий төлөвлөгөөний⁸⁰ дагуу барилга байгууламжийн төсөвт өртгийг тооцоход 47.1 тэрбум иен болж байсан нь САПРОФ судалгааны төлөвлөлтийн өртгөөс 24.5 тэрбумаар илүү байжээ. Хүснэгт 12-д харуулав.

Хүснэгт 12. САПРОФ судалгаа болон Анхан шатны зураг төслийн⁸¹ тооцооны зөрүү

№	Үзүүлэлт	САПРОФ-2006	Анхан шатны зураг төсөл	Зөрүү
1	Бэлтгэл болон ерөнхий зардал	2,349	8,728	6,379
2	Аэродром, газар шороо, үерийн ус зайлуулах байгууламжийн ажил	4,854	12,713	7,859
3	Барилгын ажил	8,856	15,737	6,881
4	Тусгай тоног төхөөрөмж	1,405	1,705	300
5	Мэдээллийн технологи, аюулгүй хамгаалалтын систем	1,251	1,898	647
6	Инженерийн байгууламжууд	1,870	4,014	2,144
7	Навигацийн систем	1,976	2,313	337
Нийт		22,561	47,108	24,547

Эх сурвалж: Зөвлөх компани, ТХН

3.23 ЖАИКА-аас төслийн хамрах хүрээ, төсөвт өртгийн тооцоолол нэмэгдсэнтэй холбоотойгоор САПРОФ судалгааны төлөвлөлтөд нийцүүлэн, төсөвт өртгийг багасгах тухай санал дэвшүүлж, нарийвчилсан зураг төслийн зарим ажлуудыг түр зогсоосон бөгөөд талуудын⁸² хэд хэдэн удаагийн уулзалтын үр дүнд төслийн нарийвчилсан зураг төсөл болон төсөвт өртгийг багасгах талаар тохиролцож зураг төслийн ажлыг үргэлжлүүлэхээр болжээ.

3.24 Шинэчилсэн зураг төслөөр зарим барилга байгууламжийг хасаж, энгийн хийцтэй зарим барилга, байгууламжийг Монголын талын хөрөнгөөр барихаар тохиролцсон бөгөөд багасгасан хувилбараар Мон-Пи8 зээлийн хүрээнд баригдах барилга байгууламжийн төсөвт өртөг 29.9 тэрбум иен, Монголын талын хөрөнгөөр гүйцэтгэх барилга байгууламжийн төсөвт өртгийг 3.2 тэрбум иен байхаар тооцсон байна.

3.25 Үүнээс гадна Мон-Пи8 зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 4 дүгээр хэсгийн 4.4⁸³-т заасны дагуу дутагдаж байгаа хөрөнгийг Монголын тал гаргах үүрэг хүлээж, зээлийн гэрээнд заасан барилга байгууламжид хуваарилагдсан 25.0 тэрбум иенээс гадна шаардлагатай байгаа 4.9 тэрбум иенийг санхүүжүүлэхээр болжээ.

3.26 ТХН-ээс ГХБГЗЗГ-т 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаар албан бичгээр Ерөнхий төлөвлөгөө, үндсэн барилга байгууламжийн эх загвар зурагт магадлал хийхийг хүссэн боловч 2011 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 1/655 дугаар албан бичгээр "... Япон Улсын өртөг тооцох журмыг үндэслэн хийгдсэн төсөвт магадлал хийх боломжгүй ..." гэдгээ мэдэгдсэн тул төслийн төсөвт өртгийг манай улсын эрх бүхий байгууллага баталгаажуулж магадлал хийгээгүй байна.

⁷⁹ САПРОФ судалгааны тайлангийн А 3-28 дахь тал

⁸⁰ Зөвлөх Ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа ЗТХЯ /одоогийн нэрээр/, ИНЕГ зэрэг холбогдох талуудын санал хүсэлтийг тусган ажилласан бөгөөд Монголын тал бүрэн цогц нисэх буудлыг төлөвлөх зорилгыг баримталж ажилласан тул САПРОФ судалгааны төлөвлөлтөөс зөрүүтэй байх шалтгаан болсон байна.

⁸¹ Ерөнхий төлөвлөгөөнд суурилсан

⁸² Сангийн яам, ЖАИКА, ЗТБХБЯ, ИНЕГ

⁸³ Зээлийн хөрөнгө нь төслийг хүрэлцэхгүй болох тохиолдолд Зээлдэгч нь шаардлагатай хөрөнгөөр хангах шуурхай арга хэмжээ авна"



3.27 Олон улсад томоохон бүтээн байгуулалтын ажлын төсөвт өртөгт хөндлөнгийн үнэлгээ, магадлал хийлгэдэг жишгийн дагуу цаашид гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн төсөвт өртөгт магадлал хийлгэж баталгаажуулж байх эрх зүйн зохицуулалтыг нэг мөр шийдвэрлэх шаардлага гарч байна.


Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнийн саналын шууд бус зардал нь тооцоолсон төсөвт өртгөөс 2.7 дахин их байжээ

3.28 Сонгон шалгаруулалтын үед Ерөнхий гүйцэтгэгчийн ирүүлсэн үнийн санал 47.1 тэрбум иен байсан нь Зөвлөхийн анхны боловсруулсан төсөвт өртөг болох 29.9 тэрбум иенээс 17.1 тэрбум иенээр илүү байжээ.

3.29 Төсөвт өртөг болон Ерөнхий гүйцэтгэгчийн үнийн саналыг зардлын бүлгээр харьцуулж үзэхэд шууд бус зардал 2.7 дахин, барилга угсралт 1.9 дахин их байснаас гадна төсөвт өртөгт дотоодын худалдан авалтын НӨАТ-ыг тусгаагүй байжээ.

3.30 ЖАИКА-аас 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн албан бичгээр “...Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнийн саналыг хүлээн зөвшөөрч болохуйц дүн гэж гэж үзсэн бөгөөд Хөгжлийн албан ёсны туслалцааны зээлийн тендерийн дүн урьдчилсан тооцооноос давж гарах тохиолдол цөөнгүй байдаг, ялангуяа Монгол шиг далайд гарцгүй, хүйтэн ширүүн уур амьсгалтай онцгой нөхцөлтэй оронд ОУНОБ барьсан туршлага Японы компаниудаар зогсохгүй бусад улсуудын хувьд ч байхгүй...” гэдгийг онцлон дурдсан байна.

Дүрслэл 3. Зөвлөхийн тооцоолсон болон Гүйцэтгэгчээс ирүүлсэн үнийн саналын зөрүү /сая иенээр/



Эх сурвалж: Зөвлөх-Азуса секкей Ориентал консалтантс хамтарсан түншлэл

3.31 ИНЕГ “Мицүбиши Чиёода хамтарсан түншлэл”-тэй гэрээ байгуулах хэлэлцээрийн шатанд үнийн саналыг нягталж үзэн гэрээ байгуулах боломжит үнийг 39.8 тэрбум, НӨАТ 2.7 тэрбум, ханшийн зөрүүгээс үүсэх эрсдэлийн сан 2.4 тэрбум иенээр тооцож, анхны багцад тусгаадаагүй шатахуун сумалгааны гидрант систем болон зурвасын гол гэрэлтүүлгийн ажлыг 4.6 тэрбум иенийн нөхцөлт төлбөртэйгөөр хийж гүйцэтгэхээр тохирсон байна.

3.32 Хэдийгээр 2 тал бүтээн байгуулалтын ажлын гэрээг байгуулах тохиролцоонд хүрч чадсан боловч төсөвт өртгөөс хэтэрсэн учир гэрээг байгуулах боломж, нөхцөл бүрдээгүй бөгөөд 2013 оны 3 дугаар сард Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэгийн айлчлалын үеэр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар 2 тал санал солилцсоны үндсэн дээр Мон-Пи8 зээлийн гэрээтэй ижил нөхцөлөөр нэмэлт зээлийг дахин олгож болох талаар зарчмын тохиролцоонд хүрч чадсан байна.

3.33 МУЗГ, ЖАИКА хооронд байгуулах “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэмэлт зээлийн хэлэлцээр”-ийн төслийг Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн УИХ-ын холбогдох байнгын хороодтой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн байна.



3.34 УИХ-ын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан, мөн АБГББХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар нэмэлт зээлийн асуудлыг хэлэлцэх үед зээлийн нийт дүнг тооцож нарийвчилсан судалгаа хийлгүйгээр гэрээ байгуулахад дутагдаж байсан 19.6 тэрбум иенээр танилцуулж дэмжигдсэн байна.

Зарим ажлыг нэмэлт зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай гэж үзэх боломжгүй байна

3.35 ГХЯ /тухайн үеийн нэрээр/ 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Япон Улсын элчин сайдын ямаар Улаанбаатар хотын шинэ ОУНОБ-ын өргөтгөлийн нэмэлт зээл авах тухай албан ёсны хүсэлтийг тавьсан байна.

3.36 Хүсэлтийн дагуу ЖАИКА-аас төслийн хэрэгжих боломжийн талаар нарийвчлан хэлэлцэх, нэмэлт зээлийн хэмжээг нарийвчлан тогтоох зорилготой ажлын хэсэг 2014 оны 6 болон 12 дугаар сард Монголд ирж ажиллан шаардлагатай нэмэлт зээлийн хэмжээг 36.8 тэрбум иен байхаар тооцож, тохиролцжээ⁸⁴. Ажлын хэсгийн холбогдох байгууллагатай ажилласан байдлаас үзэхэд,

- ЖАИКА-аас зээлээр санхүүжих ажлын нэр төрөл, тоо хэмжээний талаар судалгаа хийх баг 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдөр ирж, ЭЗХЯ, Сангийн яам, ЗТЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай 2014 оны 6 дугаар сарын 25-ны өдөр төсөл хэрэгжих боломжийн талаар нарийвчлан хэлэлцэж санал солилцсон байна.
Энэхүү уулзалтаар нэмэлт зээлд хамруулах боломжтой ажлын жагсаалтыг урьдчилсан байдлаар хэлэлцсэн бөгөөд ИНЕГ-аас ажлын горимоор санал авч ажлын жагсаалтыг эрэмбэлэн гаргасан байна.
Нэмэлт зээлээр төслийн гэрээний дутагдаж байгаа зардлыг санхүүжүүлэхээс гадна төсөлд өмнө нь байсан боловч зардал бууруулах зорилгоор хассан ажлуудыг "шаардлагатай" гэж үзэн нэмж оруулан санхүүжилтийг шийдвэрлэх талаар ЖАИКА-тай тохиролцсон байна.
- Нэмэлт зээлийн дүнд анхны төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч Монголын талын хүсэлтээр нэмэгдсэн 4.2 тэрбум иений өртөг бүхий 5 барилга байгууламжийг нэмж оруулсан байна.

3.37 УИХ-ын холбогдох Байнгын хороодоор төслийн нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудлыг 2015 онд дахин хэлэлцүүлэхэд зам барилгын ажлын дүн 2.1 тэрбум иенээр болон үнийн тохируулга, Монголын талын хүсэлт зэрэгт 15.1 тэрбум иен буюу нэмэлт зээлийн дүн нийт 17.2 тэрбум иенээр нэмэгдсэн байна.

Хүснэгт №13. УИХ-ын Байнгын хороодоор хэлэлцүүлсэн нэмэлт зээлийн дүн

Үзүүлэлт	2013 он	2015 он
Зам барилга	19.6	21.7
Үнийн тохируулга		3.4
Ханшийн зөрүү		1.8
Монголын хүсэлтээр шинээр нэмсэн		5.9
Магадалшгүй ажлын зардал		2.6
Нийт	19.6	36.8

Эх сурвалж: УИХ-ын Байнгын хороодын хурлын тэмдэглэл

3.38 Нэмэлт зээлийн хэлэлцээрийн төслийг УИХ-ын ЭЗБХ, ТБХ дэмжсэн санал дүгнэлт гаргасан бөгөөд АБГББХ-ны 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар аудитын дүгнэлт гаргуулсны дараа эцэслэн шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзжээ.

3.39 АБГББХ-ны 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн тогтоолоор Ажлын хэсэг⁸⁵ байгуулагдаж, ҮАГ-ын санал, дүгнэлтийг 2015 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн нэмэлт зээлийг дэмжсэн бөгөөд хэлэлцээрийг эхлүүлж, Зээлийн гэрээг байгуулах эрхийг МУЗГ-т олгосон байна.

3.40 Монгол Улсын Ерөнхий Сайдын 2015 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 93 дугаар захирамжаар төслийн нэмэлт зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүүд эрх олгож, Мон-Пи12 зээлийн гэрээг 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр байгуулж, Монгол Улсын Их Хурал 2015 оны 6 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталснаар төслийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр бүрдсэн байна.

⁸⁴ ЖАИКА болон Монголын талаас Сангийн яам, ИНЕГ-ын холбогдох албан тушаалтнууд нэмэлт зээлийн дүнг 36.8 тэрбум иен байхаар тохирч 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Minutes of discussion-д гарын үсэг зурсан байна.

⁸⁵ УИХ-ын Б.Болороор ахлуулсан УИХ-ын гишүүд, Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн Байнгын хорооны гишүүд, Үндэсний аудитын газрын аудитор, шинжээч, Сангийн яамны мэргэжилтэн нараас бүрдсэн ажлын хэсэг



Хүснэгт 14. Нэмэлт зээлийн дүнгийн задаргаа /тэрбум иен/

№	Үзүүлэлт				Дүн		
1	Бүтээн байгуулалтын ажил	Бүтээн байгуулалтын ажлын гэрээний үлдэгдэл			21.7		
		Монголын талын хүсэлтээр шинээр нэмэгдсэн ажлууд	САПРОФ-т тусгагдсан	Хамгаалалтын хашаа, харуулын байрууд	0.5		
				Ландшафтын ажлууд	0.3		
				Инженерийн шугам сүлжээний ажлууд	0.2		
				Аюулгүй байдлын үзлэгийн болон нэвтрэн өнгөрүүлэх байрнууд	0.1		
				Барилгуудын холбох хүзүүвч	0.1		
				Хориотой хүнс барааг устгал хийх байр, тоног төхөөрөмж	0.1		
				Хэт богино долгионы дахин дамжуулах станц, 2 сувагтай	0.1		
				Тооцоот ажиглалтын систем	0.4		
		Дүн			1.8		
		САПРОФ-т тусгаадаагүй	Автомашин дугаан гарааш	0.8			
			Газрын үйлчилгээний машин механизм төвийн барилга	1			
			Газрын үйлчилгээний машин механизм, тоног төхөөрөмжүүд	0.8			
			Аэродромын үйлчилгээний машин механизм, тоног төхөөрөмжүүд	1.2			
			Шатахууны гидрант системийн машин механизм, тоног төхөөрөмжүүд	0.4			
			Дүн			4.2	
		Ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэл			1.8		
		Үнийн тохируулга			3.4		
		2	Зөвлөх үйлчилгээ				1.5
		3	Магадалшгүй ажил				2.6
4	Зээлийн үүргийн хураамж				0.1		
НИЙТ ДҮН					36.8		

Эх сурвалж: Төсөл хэрэгжүүлэх нэгж

3.41 Монголын талын холбогдох байгууллагууд нэмэлт зээлээр санхүүжих барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон боловч зарим барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг зээлийн хөрөнгөөр барих зайлшгүй шаардлагатай байсан гэх хангалттай үндэслэлгүй байна.

3.42 Дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг Мон-Пи12 зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн нь Өрийн удирдлагын тухай хуулийн /2015 оны 2 дугаар сараас хүчин төгөлдөр болсон/ 6 дугаар зүйлийн 6.4.4⁸⁶ дэх хэсэгт заасан өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зарчмыг баримтлаагүй гэж үзэхээр байна.

- ИНЕГ-ын 2013-2017 оны татварын дараах цэвэр ашиг 68.2 тэрбум төгрөг⁸⁷ байгаагаас харахад ИНЕГ нэмэлт зээлийн хүрээнд нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөмжийг жил бүрийн цэвэр ашгаас худалдан авах боломж, нөөц байсан гэж үзэхээр байна. ИНЕГ-ын татварын дараах цэвэр ашгийг Хүснэгт 15-д харуулав.
- Үүнээс гадна энгийн хийцтэй зарим барилга, байгууламжийг Монгол Улс дотоодын хүч хөрөнгөөр хямд өртгөөр барьж байгуулах боломжтой байсан гэж үзэж байна. Тухайлбал,
 - Хамгаалалтын хашаа, харуулын байрууд
 - Ландшафтын ажлууд
 - Аюулгүй байдлын үзлэгийн болон нэвтрэн өнгөрүүлэх байрнууд

3.43 Мон-Пи12 зээлд нэмэлт ажлууд оруулснаар ОУНОБ ашиглалтад орох хугацаа хойшилж, төслөөс өгөх эдийн засгийн өгөөж буурах нөхцөлийг бий болгосон байна.

Хүснэгт 15. ИНЕГ-ын татварын дараах цэвэр ашиг /сая төгрөг/

Он	Татварын дараах цэвэр ашиг
2013	8,355.4
2014	20,670.1
2015	4,875.3
2016	13,330.0
2017	21,007.3
НИЙТ	68,238.1
Эх сурвалж: ИНЕГ	

⁸⁶ “гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэл баримтлах”

⁸⁷ ИНЕГ-ын санхүүгийн тайлан



Захиалагч тал гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн 1.9 тэрбум төгрөгийн төлбөрийг зээлийн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна


3.44 Төслийн хүрээнд зээлийн санхүүжилтээр нийт 82 барилга байгууламж баригдаж байнгын ашиглалтад хүлээн аваад байгаа бөгөөд агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгыг 2020 оны 4 дүгээр улиралд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

3.45 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний Ерөнхий нөхцөлийн 14.6 “Дунд шатны төлбөрийн гэрчилгээ гаргах” хэсэгт заасны дагуу Зөвлөх Гүйцэтгэгчээс төлбөрийн нэхэмжлэх хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор хянан баталгаажуулж, “Дунд шатны төлбөрийн гэрчилгээ”-г гарган ТХН-д ирүүлж байна.

3.46 ТХН-ээс “Дунд шатны төлбөрийн гэрчилгээ”-г хянан зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх тухай хүсэлтээ ЗТХЯ-ны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэст хүргүүлэн, улмаар ЗТХЯ-аас “Дунд шатны төлбөрийн гэрчилгээ”-г хянан Сангийн яаманд уламжилж, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга “Гүйцэтгэлийн тодорхойлолт” /Statement of Performance/- гаргадаг байна.

3.47 ТХН, Ерөнхий гүйцэтгэгч нь “Гүйцэтгэлийн тодорхойлолт” -ыг авч буухиа шуудангаар Япон Улс дахь Токио Мицүбиши UFJ банк руу хүргүүлж, банкнаас гүйцэтгэгчийн дансанд санхүүжилтийг шилжүүлдэг байна. Санхүүжилтийн үе шатыг Дүрслэл 4-д харуулав.

Дүрслэл 4. Санхүүжилтийн үе шат



Эх сурвалж: Төсөл хэрэгжүүлэгч нэгж

3.48 Зөвлөх, ТХН барилгын ажлын гүйцэтгэлийг, ЗТХЯ, Сангийн яамны зүгээс баримтын бүрдлийн хэмжээнд хянадаг нь холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт ярилцлагаас ажиглагдаж байгаагаас үзэхэд бодит бус гүйцэтгэлд санхүүжилт олгогдох эрсдэл байж болзошгүй байна.

3.49 Аудитын багт барилгын ажлын чанар, гүйцэтгэл болон төсөвт өртөг, санхүүжилтийн дүнг ажлын тоо хэмжээтэй тулган баталгаажуулах зөвлөх, шинжээчийн баг ажиллуулахаар төлөвлөсөн боловч аудитын зардал батлагдаагүйгээс зээлийн хөрөнгөөр санхүүжсэн барилгын ажлаас бусад асуудлуудыг нарийвчлан тодруулав. Үүнд:

▪ **Ашиглалтын зардлын нэхэмжлэлийн талаар**

3.50 Барилгын ажил гүйцэтгэх үндсэн гэрээнд тусгагдсан ажлууд дууссан тул Зөвлөх Барилгын ажлын гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөр тооцож “Ажил хүлээж авах гэрчилгээ”-г гаргасан байна. “Ажил хүлээн авах гэрчилгээ”-г гарснаар төслийн Барилгын ажлын үндсэн гэрээний хүрээнд баригдсан



барилга, байгууламж, тоног төхөөрөмж болон машин механизмын ашиглалт, харуул хамгаалалтын зардлыг ИНЕГ хариуцах үүрэг хүлээсэн байна.

3.51 Гэвч “Ажил хүлээж авах гэрчилгээ” гаргах үед ИНЕГ-ын харьяа ОУНОШБ-ын АӨЗ-ны 2017 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв батлагдаагүй байснаас ИНЕГ-ын хүсэлтээр гүйцэтгэгч 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хүртэл өөрийн хөрөнгөөр нисэх буудлын ашиглалтын зардлыг хариуцан ажилласан байна.

3.52 ИНЕГ-ын ашиглалтын өмнөх захиргааны алба 2017 оны 3 дугаар сарын 6-ны өдрөөс зардлыг хариуцан ажиллаж эхэлсэн бөгөөд Гүйцэтгэгчээс 02 дугаар сарын 1-ний өдрөөс 03 дугаар сарын 06-ны өдөр хүртэл хугацаанд гарсан зардал болох 829.4 сая төгрөгийг /шууд зардал 468.1 сая, шууд бус зардал 361.3 сая төгрөг/ нэхэмжилсэн байна.

3.53 Монголын тал гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс гарсан 829.4 сая төгрөгийг Барилгын ажлын 44 дэх гүйцэтгэлээр буюу Зээлийн хөрөнгөөс төлсөн бөгөөд ИНЕГ-ын АӨЗ-ны санхүүгийн тайланд ОУНОБ-ын 2018 оны 2-3 сарын ашиглалтын зардал 246.8 сая төгрөг бүртгэгдсэн байгаа нь Гүйцэтгэгчид олгосон шууд зардал 468.1 сая төгрөгөөс 1.8 дахин бага байна.

■ **Цахилгаан үүсгүүрийн төлбөрийн нэхэмжлэлийн талаар**

3.54 ЗТЯ, Ерөнхий гүйцэтгэгчтэй 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт⁸⁸ МУЗГ барилга угсралтын ажил эхлэхэд байнгын цахилгаан, эрчим хүчээр тасралтгүй хангах үүрэг хүлээжээ.

3.55 Үүнтэй холбогдуулан тус ажлыг гүйцэтгүүлэхээр ЭХЯ сонгон шалгаруулалт явуулж, “Алтай трест” ХХК ажлыг 2011 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2012 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулахаар ЭХЯ-тай гэрээ байгуулан ажилласан байна.

3.56 Гэвч гэрээний хугацаанд 2 удаа өөрчлөлт оруулан байгууламжийг ашиглалтад оруулах өдрийг 2012 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, 2013 оны 06 дугаар сарын 30-ны өдөр болгон тус тус сунгасан боловч “Алтай трест” ХХК нь Налайх- Хөшигийн хөндийн чиглэлийн чиглэлийн 1 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, Дэд станцаас 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчдэлээр хангаж эхэлсэн байна.

3.57 Монголын тал хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс ерөнхий туслан гүйцэтгэгч “Самсунг Си энд Ти” ХХК 22 дизель цахилгаан үүсгүүрийг өөрийн хөрөнгөөр худалдан авч бүрэн хүчдэлд залгаж цахилгааны байнгын эх үүсвэртэй болох хүртэлх 5 сарын хугацаанд ашигласан байна.

3.58 Үүнээс шалтгаалан Ерөнхий гүйцэтгэгч МУЗГ-ыг шаардлагатай цахилгаан эрчим хүчээр хангах үүргээ хугацаанд нь биелүүлээгүй гэсэн үндэслэлээр 2013 оны 08 дугаар 01-ний өдрөөс 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд гарсан эрчим хүчний зардлыг тооцож нийт 1.1 тэрбум төгрөгийг нэхэмжилснийг гүйцэтгэгчийн 44 дэх гүйцэтгэлийн төлбөрт оруулан зээлийн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.

■ **Төслийн хөрөнгийг төлөвлөөгүй байршилд шилжүүлэн ашигласан талаар**

3.59 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний дагуу Гүйцэтгэгч компани Англи улсын Парк Эйр систем компанид үйлдвэрлэгдсэн 63.2 сая иений үнийн дүн бүхий 2 алсын удирдлагатай хэт богино долгионы радио станцыг нийлүүлсэн байна.

⁸⁸ Төслийн түр ажлуудад байнгын цахилгаан эх үүсвэрийг ашиглаж болох бөгөөд энэ нь 2013 оны 08 дугаар сарын 01-ний өдөр гэхэд ашиглахад бэлэн болсон байна...Гүйцэтгэгч тал төслийн хэрэгжилтийн явцад Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-аас цахилгаан эрчим хүчээр хангаж чадаагүй тохиолдолд эрсдэлийг үүрч цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах үүрэг, хариуцлага хүлээнэ гэж заасан байна.



3.60 ИНЕГ-ын Холбоо, навигаци, ажиглалтын албаны техникийн зөвлөлийн хурлын ТЗ-04 дугаартай шийдвэр гарч, ИНЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/464 дугаар тушаалаар Богд уулын Хэт богино долгионы төвд байрлах 2 алсын удирдлагатай хэт богино долгионы IP радио станцыг Хөвсгөл аймгийн Хэнгэрэгтэй ажиглалтын байгууламжид 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдөр, Морин-Уулын цаг уурын ажиглалтын байранд байрлах IP радио станцыг Увс аймгийн Улаангом нисэх буудалд 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдөр тус тус шилжүүлэн суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хугацаа хоцорсны алданги болон нүүрсний төлбөрийн нэхэмжлэхийн асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна

▪ **Хугацаа хоцорсны алдангийн талаар**

3.61 Зээлийн хөрөнгөөс төслийн Ерөнхий гүйцэтгэгч Мицүбиши-Чиёода хамтарсан түншлэлд 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 51 удаагийн ажлын гүйцэтгэлд 60,452.3 сая иенийг санхүүжилт олгосон байна.

3.62 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний Ерөнхий нөхцөлийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтад Захиалагч тал нь гүйцэтгэгчээс нэхэмжилсэн Зөвлөх үнэн зөв гэж гэрчилсэн дүнг хуанлийн 56 хоногийн дотор санхүүжүүлэхээр, мөн гэрээний Ерөнхий нөхцөлийн 14.8 дахь заалтад Гүйцэтгэгч тал хугацаа хоцорсон төлбөр тутамд Захиалагч талаас алданги тооцон нэхэмжлэх эрхтэй талаар заасан байна.

3.63 Нэмэлт зээлийн хэлэлцээр хийх үед ЖАИКА-гаас Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийн төлбөр хоцорч байгаа асуудалд анхаарч ажиллах хүсэлт тавьсан байна. 2015 оны 07 дугаар сарын 27-ны өдөр төслийн Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн нэхэмжлэлийг санхүүжүүлэх горим боловсруулж Сангийн яам, ЗТЯ, ТХН, Зөвлөх болон Ерөнхий гүйцэтгэгч компанийн холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 16. Гүйцэтгэл баталгаажуулах үе шатны хоногийн хуваарилалт /хуанлийн өдрөөр/

№	Хариуцах тал	Гүйцэтгэлийн нэхэмжлэлийг баталгаажуулах үе шат	Тухайн үе шатанд зарцуулах хугацаа	Нийт зарцуулагдсан хугацаа
1	Ерөнхий гүйцэтгэгч	Ерөнхий гүйцэтгэгч сарын тайланг гаргана.	0	0
2	ТХН/ Зөвлөх	Зөвлөх болон ТХН хянан шалгасны үндсэн дээр Зөвлөх Дунд шатны төлбөрийн гэрчилгээ гаргана.	27	27
3	Ерөнхий гүйцэтгэгч /ТХН	Ерөнхий гүйцэтгэгч ТХН-д нэхэмжлэх ирүүлнэ. Уг нэхэмжлэхийг хянан, санхүүжилт хүссэн албан бичгийг Зам, тээврийн яаманд хүргүүлнэ.	2	29
4	ЗТЯ	ЗТЯ гүйцэтгэлийг хянан, санхүүжилт хүссэн албан бичгийг Сангийн яаманд хүргүүлнэ.	5	34
5	Сангийн яам	Сангийн яам хянан Гүйцэтгэлийн тодорхойлолт гаргана.	5	39
6	Ерөнхий гүйцэтгэгч /ЖАИКА/	Ерөнхий гүйцэтгэгч Гүйцэтгэлийн тодорхойлолтыг нэмэлт баримт бичгийн хамт өөрсдийн Япон дахь банканд хүргүүлнэ. ЖАИКА төлбөрийг шилжүүлнэ.	17	56

Эх сурвалж: ТХН

3.64 Гэвч 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх төслийн үе шатны санхүүжилтийг талуудын хянан баталгаажуулах үйл ажиллагаа удааширнаас шалтгаалан 31 удаагийн санхүүжилт хугацаа хоцорч, 50.1 сая иений төлбөр төлөх шаардлага үүссэн байгаа бөгөөд үүний 10 хувь төслийн зөвлөх, 10 хувь төсөл хэрэгжүүлэгч нэгж, 30 хувь ЗТХЯ, 40 хувь Сангийн яамнаас тус тус хамаарсан байна.

3.65 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний Ерөнхий нөхцөлийн 14 дүгээр зүйлийн 14.8 дахь заалтад алдангийг тооцохдоо Япон Улсын Төв банкны хөнгөлөлтийн хүү (бодлогын хүү)-ээс 3 хувиар илүү байна гэж заасны дагуу 3.3 хувиар тооцохоос гадна төлөөгүй алдангийн дүнгээс дахин хүү тооцдог байна.



3.66 Захиалагч тал алдангийн үлдэгдлийг тооцон баталгаажуулаагүй төдийгүй хугацаа хоцорсны төлбөрийн алдангид өдөр тутам ойролцоогоор 4600 иений хүү бодогдон нэмэгдсээр байгаа тул уг асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

▪ **Нүүрсний төлбөрийн нэхэмжлэлийн талаар**

3.67 ЗТХС-ын 2016 оны 123 дугаарт тушаалаар байгуулагдсан улсын комиссоос ОУНОШБ барих төслийн хүрээнд баригдсан Дулааны станцыг ашиглалтад хүлээн авах шийдвэрийг 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр гаргасан байна.

3.68 ИНЕГ-ын 2017 оны төсөвт Дулааны станцын түлш, халаалтын зардалд 346.0 сая төгрөг батлагдсан ч станцад нүүрс нийлүүлэх ажлын худалдан авах ажиллагаа удааширнаас шалтгаалан ИНЕГ-аас тавьсан хүсэлтийн дагуу Ерөнхий туслан гүйцэтгэгч “Самсунг Си энд Ти” ХХК-аас 2017 оны 4-5 дугаар сар хүртэлх 82.3 сая төгрөгийн үнэ бүхий 1000 тонн нүүрсийг өөрийн хөрөнгөөр худалдан авч нийлүүлсэн байна.

3.69 ТУХ-ны 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01 дугаарт хурлын тэмдэглэлээр 1000 тонн нүүрсийг ИНЕГ-ын 2018 оны төсвийн хэмнэлтээс төлж барагдуулах нь зүйтэй гэж ЗТХЯ болон ИНЕГ-т зөвлөмж болгожээ.

3.70 Гэвч захиалагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс шалтгаалан нүүрсийг худалдан авсан зах зээлийн үнээс 30 хувиар илүү төлбөр төлөх нөхцөл үүссэн байгаа тул яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга, барьж эхэлсэн, Монголын талын хөрөнгөөр барьж буй барилгын ажил удааширсан, концессын гэрээ 2019 оны 7 дугаар сард байгуулсан зэргээс ОУНОШБ үйл ажиллагаа явуулах хугацаа хойшилсон байна

3.71 САПРОФ судалгааны тайлан болон ОУНОШБ-ын ерөнхий төлөвлөгөөнд⁸⁹ агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгыг ашиглагч байгууллага өөрийн хөрөнгөөр барих нөхцөлтэйгөөр тусгасан байна.

3.72 Нисэх буудлын үндсэн хэрэглэгч “МИАТ” ТӨХК нь 5 ширхэг агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын зураг төслийг “М-Эйч-И” ХХК-иар хийлгэж, 2016 онд “Барилгын хөгжлийн төв” төсөвт өртгийг 57.5 тэрбум төгрөг байхаар хянан баталгаажуулсан байна.

3.73 “МИАТ” ТӨХК-ийн агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгыг “барих-шилжүүлэх” концессын төрлөөр барьж байгуулахаар МУЗГ-ын 2016 оны 149 дүгээр тогтоолоор концессын зүйлийн жагсаалтад оруулсан хэдий ч МУЗГ-ын 2016 оны 37 дугаар тогтоолоор улсын төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын гэрээг 2018 оны төсвийн жил хүртэл зогсоосон байна.

3.74 ЗТХЯ-ны 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 03/859 болон 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 03/1451 дугаар албан бичгээр ТХН-д Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тооцоолон гаргаж, зээлийн үлдэх хөрөнгөөс санхүүжүүлэх боломжийг судлахыг даалгасны дагуу барилгын зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулсан байна.

3.75 Түүнчлэн ЗТХС Д.Ганбат МУЗГ-ын 2017 оны 36 дугаар хуралдаанд ОУНОШБ-ын үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын талаар танилцуулснаар Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга, явгалах зам, зогсоол, дэд бүтцийн шугам сүлжээ, газар шорооны ажил болон зураг төслийг зээлийн үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх

⁸⁹ ЗТБХБС-ын 2010 оны 01 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тушаалаар батлагдсан



асуудлыг судлан зохих журмын дагуу шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат нарт даалгажээ.

3.76 Дээрх шийдвэрийн дагуу ЖАИКА-гаас 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн албан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Зөвлөхөд албан ёсоор мэдэгдэж 2017 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн байна.

3.77 Зээлийн гэрээний хавсралт №2-ын 2 дугаар хэсэгт⁹⁰ “... хуваарилагдсан зардал өссөн бөгөөд тэрхүү өсөлтийн дүнтэй тэнцэх хөрөнгийг Зээлийн хөрөнгөөс гаргах шаардлага үүссэн бол Банк нь Зээлдэгчийн тавьсан хүсэлтийн дагуу уг хуваарилалтыг хийнэ” гэж заасны дагуу төсөл хэрэгжих хугацаанд Мон-Пи8 зээлийн хөрөнгөд 1 удаа, Мон-Пи12 зээлийн хөрөнгөд агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга барихтай холбоотойгоор 1 удаа дахин хуваарилалт хийжээ. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 17. Зээлийн хөрөнгийн хуваарилалт /сая иен/

Үзүүлэлт	Зам барилгын болон бусад ажил (1)	Зөвлөхийн үйлчилгээ (2)	Барилгын ажлын үеийн зээлийн хүү (3)	Зээлийн үүргийн хураамж (4)	Магадлашгүй ажил (5)	Дүн (1+2+3+4+5)
Мон-Пи8	25,041	2,011	176	229	1,350	28,807
Дахин хуваарилалт 2015.10.15	26,391	2,011	176	229	-	28,807
Мон-Пи12	32,583	1,525	113		2,629	36,850
Дахин хуваарилалт 2019.01.08	34,455	2,282	113		-	36,850
Монголын талаас санхүүжүүлсэн	1,505					
Дахин хуваарилсан дүн	62,352	4,293	289	229	-	67,162
Үндсэн гэрээ	49,500	1,921				
Нэмэлт №1	7,681	1,443				
Нэмэлт №2	5,171	347				
Нэмэлт №3	-	582				
Дүн	62,352	4,292				
Дахин хуваарилсан болон гэрээний дүнгийн зөрүү	-	0				

Эх сурвалж: Төсөл хэрэгжүүлэх нэгж

3.78 Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгыг барьж, 2019 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар Зөвлөхтэй 928.6 сая иен /нэмэлт №2, 3/, Ерөнхий гүйцэтгэгчтэй 5,170.8 сая иений /90.8 тэрбум төгрөг/ ажил гүйцэтгүүлэх гэрээг тус тус байгуулсан бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 99 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.79 Зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй 2 ширхэг агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга барих гэрээний үнийн дүн нь Барилгын хөгжлийн төвөөс баталгаажуулсан 5 агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын төсөвт өртгөөс 33.3 тэрбум төгрөгөөр буюу 1.6 дахин их байгаа нь ОУНОШБ нь дотоодын зах зээлийн үнээс өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 18. Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын хүчин чадал, төсвийн харьцуулалт

№	Үзүүлэлт	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга	
		МИАТ ТӨХК-ийн 2016 онд боловсруулсан зураг төсөл	Зээлийн хөрөнгөөр баригдаж буй
1	Ерөнхий хэмжээ	176мх105м /18480 м²/	158мх74.7м /11802 м²/
2	Хүчин чадал	2 ширхэг Boeing 787-8 3 ширхэг Boeing 737-800	2 ширхэг Boeing 787-900
3	Төсөвт өртөг / тэрбум төгрөг/	57.5	90.8

Эх сурвалж: МИАТ, ТХН

3.80 Ашиглагч байгууллагаар бариулахаар төлөвлөж байсан Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгыг дахин хуваарилалт хийх замаар зээлийн хөрөнгийн зарцуулаагүй

⁹⁰ Зардлын тооцоо өөрчлөгдсөний дараа дахин хуваарилалт хийх



үлдэгдлээс санхүүжүүлэн барьж байгаагаас ОУНОБ-ыг ашиглалтад орох хугацаанд⁹¹ сөргөөр нөлөөлсөн байна.

3.81 Төслийн хүрээнд баригдсан барилга байгууламж, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг байнгын ашиглалтад хүлээн авах комисс 2017 оны 1 дүгээр сард ажиллан хүлээж авсан боловч өнөөдрийг хүртэл ОУНОШБ үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байгаагаас “Чингис хаан” ОУНОБ-ын өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбоотой асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй⁹², төслийн өгөөжийг 3 жилийн хугацаанд хүртэж чадаагүй байна.

Төслийн хүрээнд нийлүүлсэн авто машины үнэ зах зээлийн үнээс 4.9 дахин өндөр, зарим хөрөнгийг давхардуулан бүртгэсэн байна

3.82 МУЗГ-ын 2018 оны 150 дугаар, ЗТХС-ын 2018 оны 217 дугаар тушаалын дагуу ИНЕГ 2018, 2019 онд 2 удаа “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын хөрөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Мөнх Оргил Трейд” ХХК⁹³ хөрөнгийн үнэлгээг орлуулалтын өртгийн аргаар 1,246.3 тэрбум төгрөгөөр үнэлсэн байна.

3.83 “Мөнх-Оргил трейд” ХХК нь ТӨБЗГ-ын 2017, 2018, 2019 онуудад гарсан тогтоол, албан бичгийн дагуу бусад төрийн байгууллага, ТӨХК-д шилжүүлсэн машин механизмыг хөрөнгөд тооцон үнэлсэн байна. Тухайлбал,

- ТХН-ийн албан хэрэгцээнд ашиглаж байсан нийт 18 автомашины үнэлгээний дүн нь ТХН-д бүртгэсэн балансын анхны өртгөөс 879.6 сая төгрөгөөр өндөр,
- Төслийн хүрээнд 27 дугаар гүйцэтгэлээр гал унтраах аврах ангийн эмнэлгийн автомашины 56,552.2 мянган иен, штаб командын машины 41,206.4 мянган иенийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Хөрөнгийн үнэлгээний тайланд Гал унтраах авран хамгаалах, эмнэлгийн тээврийн хэрэгсэл 56,552.2 мянган төгрөг, Гал унтраах авран хамгаалах, штаб командын тээврийн хэрэгсэл 41,206.4 мянган төгрөг гэж валютыг өөрчлөн тусгасан,
- Дээр дурдагдсан штаб командын автомашиныг 252,200.0 мянган төгрөг гэж давхцуулан үнэлсэн байна.

3.84 ИНЕГ нь Сангийн яаманд 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 01/2639 дугаар албан бичгээр “Мөнх-Оргил трейд” ХХК-аар хийлгэсэн хөндлөнгийн үнэлгээний дүн нь төслийн нийт санхүүжилтийн дүнгээс 178.5 тэрбум төгрөгөөр зөрүүтэй, нийт хөрөнгийн өртөгт гадаадын болон Монголын зөвлөх үйлчилгээний зардал, баригдаж байгаа агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын өртгийг тусгаагүй тул дээрх зөрүүг бүртгэлд хэрхэн бүртгэх талаар тодруулга авахаар хандсан байна.

3.85 Сангийн яам 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 2/0367 дугаарт албан бичгээр НББОУС-16 “Үндсэн хөрөнгө гэсэн стандартын 15-т “хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг анхны удаа өртгөөр нь хэмжинэ” гэж заасны дагуу төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг анх удаа бүртгэхдээ өртгөөр нь бүртгэх нь зүйтэй гэсэн зөвлөмж хүргүүлсний дагуу ИНЕГ хөрөнгийн үнэлгээнээс газар эзэмших эрх, зөвлөх үйлчилгээ, Ангартын барилгын дуусаагүй үйлдвэрлэл зэргийг хасаж, ТХН болон ИНЕГ-аас гарсан бусад зардлыг нэмж, хөрөнгийн анхны өртгөөр бүртгэх дараах өөрчлөлтийг оруулжээ.

Хүснэгт 19. ИНЕГ-аас “Мөнх-Оргил трейд” ХХК-ний хийсэн хөрөнгийн үнэлгээнд хийсэн өөрчлөлтийн мэдээлэл /сая төгрөг/

№	Хөрөнгийн төрөл	Үнэлгээний дүн	ИНЕГ-аас үнэлгээнд өөрчлөлт оруулсан дүн
1	Барилга байгууламж, машин механизм	969,552.1	990,290.3
2	Тоног төхөөрөмж, тавилга, биет бус хөрөнгө	149,200.0	125,430.4
3	Эргэлтийн хөрөнгө	17,959.1	17,959.1
4	Бусад зардал	114,630.0	-
Нийт дүн		1,246,341.3	1,133,679.8

Эх сурвалж: “Мөнх-Оргил трейд” ХХК-ний хийсэн үнэлгээний тайлан

⁹¹ 2018 оны 05 дугаар сар

⁹² МУЗГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр “...Чингис хаан ОУНОБ-ыг шинэ нисэх буудал руу шилжүүлсэн тохиолдолд Буянт-Ухаа дах одоогийн барилга байгууламжийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулан Засгийн газарт оруулахыг ЗТХС-д даалгасан.

⁹³ ИНЕГ/УЗ/ТББ/ЗУ-11/19.2 дугаартай 39.9 сая төгрөгийн “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын хөрөнгийн үнэлгээ хийх гүйцэтгэх гэрээ”-г 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулж, ажлын тайланг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүлээлгэн өгч, гэрээг 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдөр дүгнэсэн байна.



3.86 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 382 дугаар тогтоолоор Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон Монгол Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлсэн Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын нийт 1,264.6 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг ИНЕГ-ын баланст төрийн өмчөөр бүртгэхийг зөвшөөрсөн байна.

Хүснэгт 20. ТӨБЗГ-ын тогтоолын хавсралтын нэгтгэл /сая төгрөг/

№	Хөрөнгийн төрөл	Балансын үнэ
1	Барилга	367,787.4
2	Байгууламж	561,167.1
3	Тоног төхөөрөмж	124,462.4
4	Тавилга эд хогшил	962.9
5	Тээврийн хэрэгсэл	61,375.7
6	Биет бус хөрөнгө	5.0
7	Эргэлтийн хөрөнгө	17,919.2
8	Нийт	1,133,679.8
9	Дуусаагүй барилга /Ангар/	130,950.9
	Нийт дүн	1,264,630.6

Тайлбар: Дуусаагүй барилга гэдэгт 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх Ангарын барилгын санхүүжилтийн дүн, зээлийн үлдэгдэл санхүүжилт, банкны хураамж болон хүүгийн зардлыг тус өдрийн иений 24.69 ханшаар тооцсон байна.

3.87 Дээрх тогтоолд ТӨБЗГ-ын 2017 оны 244, 2018 оны 294, 2019 оны 431 дүгээр тогтоол, 2019 оны А-22/3305 дугаарт бичгээр тус тус хөрөнгийн бүртгэлийг өөр газруудад шилжүүлэн ашиглаж буй нийт 11 автомашины уг тогтоолоор давхцуулан шилжүүлсэн, мөн дараах 2 авто машиныг давхардуулан тусгасан байна. /ТӨБЗГ-ын хөрөнгө шилжүүлэх тогтоол, албан бичгийн мэдээллийг хавсралт 5-с үзнэ үү/ Тухайлбал:

Хүснэгт 21. ТӨБЗГ-ын тогтоолд давхардуулан тусгасан хөрөнгийн жагсаалт /төгрөг/

№	Тээврийн хэрэгслийн нэр	Балансын үнэ
1	Гал унтраах авран хамгаалах, эмнэлгийн тээврийн хэрэгсэл	56,552,200.00
	Эмнэлгийн түргэн тусламжийн машин	1,377,612,000.00
2	Гал унтраах авран хамгаалах, штаб командын тээврийн хэрэгсэл	41,206,400.00
	Штаб командын машин	1,003,787,000.00

Тайлбар: Монголбанкны 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн албан ханш 24.36 төгрөгөөр тооцсон.

3.88 Мөн зээлийн санхүүжилтээр 63.2 сая иенээр худалдан авсан алсын удирдлагатай хэт богино долгионы 2 ширхэг радио станцыг ИНЕГ-ын даргын 2018 оны А/464 дүгээр тушаалаар Хөвсгөл, Увс аймгуудад шилжүүлсэн байхад хөрөнгийн үнэлгээний жагсаалт оруулаагүй, хөрөнгө бүртгэх тухай тогтоолд тусгаагүй байх тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өглөө.

3.89 Төслийн ерөнхий гүйцэтгэгч “Мицүбиши-Чиёода”-ийн нийлүүлсэн автомашины гэрээнд заасан үнэ тухайн автомашины анхны өртгөөс (импортлогч Таванбогд ХХК-ийн 147.0 сая төгрөг⁹⁴, суурилуулсан богино долгионы станцын ижил төрлийн зах зээлийн үнэ 1.9 сая төгрөг) 4.9 дахин их байгаа нь өнөөгийн нөхцөлд нийцэхгүй, хэт өндөр үнээр нийлүүлснийг ИНЕГ, ЗТХЯ, Сангийн яам хяналт тавихгүйгээр ажилласан байна. Иймд тус асуудлыг хууль хяналтын байгууллагаар нарийвчлан шалгуулах шаардлагатай байна. Тухайлбал:

⁹⁴ гаалийн бүрдүүлэлтийн суурь үнэ 127,125,110.25 төгрөг, онцгой татвар 6,525,000.0 төгрөг, НӨАТ 13,365,011.0 төгрөг нийт 147,015,121.3 төгрөг



Хүснэгт 22. ОУНОШБ-ын гал унтраах авран хамгаалах штаб командын автомашины үнийн харьцуулалт

№	Тээврийн хэрэгслийн нэр	“Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэл, Rosenbauer International AG хооронд байгуулсан “УБ хотын ОУ-ын шинэ нисэх онгоцны буудлын тээврийн хэрэгслийг худалдан авах захиалгын гэрээ”-ний дүн		ИНЕГ, “Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэлтэй байгуулсан “Барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний ажлын тооцооны тоо хэмжээний дүн		Ерөнхий гүйцэтгэгчийн шууд бус зардал /төслөөс санхүүжсэн дүн, туслан гүйцэтгэгчийн нийлүүлсэн дүнгийн зөрүү/	ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолд тусгасан дүн,
		Евро	Төгрөг	Иен	Төгрөг	Төгрөг	Төгрөг
1	Штаб командын машин	85,778.00	223,519,454.62	41,206,390.00	723,996,272.3	500,476,817.68	1,003,787,000.00

Тайлбар: Монгол банкны 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн хаалтын бодсон тооцсон болно.

3.90 ИНЕГ, төсөл хэрэгжүүлэгч нэгж, төслийн зөвлөх болон ерөнхий туслан гүйцэтгэгч нар 2016 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд гал унтраах авран хамгаалах штабын автомашинд холбогдох туршилтыг хийж хүлээн авсан бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдөр ИНЕГ-ын нэр дээр тус машиныг улсын бүртгэлд бүртгэж 2017 онд ИНЕГ-ын тэргүүн дэд дарга, 2018-2019 онд ИНЕГ-ын НБУГ-ын дарга нар албан хэрэгцээнд ашиглаж байгаа нь зээлийн хөрөнгөөр худалдан авсан зориулалттай нийцэхгүй байна. Мөн тус автомашины 0450 УБҮ улсын дугаарыг 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 2735 УНП болгож өөрчилжээ.

■ **Зээлийн хөрөнгөөр зарим шууд бус зардлыг санхүүжүүлсэн байна**

3.91 Мон-Пи8, Мон-Пи12 зээлийн гэрээнд дор дурдсан зардлыг зээлийн санхүүжилтэд хамааруулахгүй гэж заасан байхад гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний техникийн шаардлагын 1 дүгээр хэсэгт “...Гүйцэтгэгч нь Захиалагч болон Зөвлөхийн ашиглалт, хангамж, ажлын байрны тавилга, тоног төхөөрөмжийн зардал болон Зөвлөхийн ажилчдын амьдрах байрны зардлыг хариуцах...”-аар тусгажээ. Үүнд:

- Захиргааны ерөнхий зардал
- Татвар хураамж
- Газар болон бусад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах
- Нөхөн олговор
- Шууд бус бусад зардал

3.92 Ерөнхий туслан гүйцэтгэгч “Самсунг Си энд Ти” компанийн 2013-2017 оны шууд бус зардлыг түүвэрлэн авч үзэхэд ТХН болон зөвлөхийн харилцаа холбоонд 26.3 сая төгрөг, оффис бичиг хэрэгт 324.4 сая төгрөг, тээврийн хэрэгслийн зардалд 1,151.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн нь зээлийн гэрээтэй нийцэхгүй байна.

Төслийн хүрээнд бараа материал, тоног төхөөрөмжийг тусгайлсан эрх зүйн зохицуулалтгүйгээр 15.0 тэрбум төгрөгийн НӨАТ, 15.1 тэрбум төгрөгийн Гаалийн албан татвараас чөлөөлсөн байна.

3.93 Төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар, ИНЕГ-ын Япон Улсын талуудтай байгуулсан гэрээнд татвар хураамжийн асуудлын талаар дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 23. Төслийн хүрээнд татвар хураамжийн талаар холбогдох гэрээнд тусгасан байдал

Баримт бичиг	Татварын зохицуулалт
МУЗГ, Япон Улсын Засгийн газрын хооронд 2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан Ноот бичиг	7 дугаар зүйл. Зээлийн хүрээнд Япон Улсын ханган нийлүүлэгч аж ахуйн нэгж, гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлж буй байгууллагын бүтээгдэхүүн буюу үйлчилгээг татварын хураамж болон Монгол Улсын бүх татвар ногдуулалтаас чөлөөлнө. Төсвийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй Япон Улсын ханган нийлүүлэгч аж ахуйн нэгж, гүйцэтгэгч, зөвлөх байгууллага нь төслийн хэрэгжилтэд шаардлагатай бараа бүтээгдэхүүн болон тоног төхөөрөмжийг импортлох/ буцаан экспортлох тохиолдолд Монгол Улсын татвар ногдуулалт, бүх хариуцлагаас чөлөөлнө. Төслийн хэрэгжилтэд оролцож буй ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч, зөвлөхөөр ажиллаж байгаа Япон компанийн Япон ажилчдыг Төсвөөс авах бүх төрлийн хураамж, шимтгэл, татвар ХХОАТ-аас чөлөөлнө.
МОН-Пи8 зээлийн гэрээ	Хавсралт №2 Зээлийн хөрөнгийн хуваарилалтад Зээлийн санхүүжилтэд Татвар, хураамж хамаарахгүй.
МОН-Пи12 зээлийн гэрээ	Хавсралт №2 Зээлийн хөрөнгийн хуваарилалтад Зээлийн санхүүжилтэд Татвар, хураамж хамаарахгүй.




Барилгын ажил гүйцэтгэх гэрээ	ГЕН 14 дүгээр зүйл: Зөвхөн гэрээт ажлыг гүйцэтгэх зорилгоор гүйцэтгэгчийн оруулж ирсэн тоног төхөөрөмж, гол сэлбэг хэрэгслийг импортын татвар, хураамжаас чөлөөлнө.
	ГТН 14 дүгээр зүйл: Монгол улсын Засгийн газар ба Япон улсын Засгийн газар хооронд солилцсон Ноот бичгийн дагуу Японы компаниуд болон Япон ажилчдыг төслийн зээлийн гэрээний дагуу нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олох орлогод ноогдуулах. Монгол улсын бүх албан татвар, хураамжаас, түүнчлэн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өөрсдийн бараа түүхий эдийн импорт ре-экспортын татвар хураамжаас чөлөөлнө. Харин гэрээнд өөрөөр заагаагүй бол Японоос бусад улсын бүх гүйцэтгэгч, туслах гүйцэтгэгч, тэдгээрийн ажилтнуудад оногдуулах холбогдох бүх татвар, шимтгэл, хураамж үйлчилнэ.
Зөвлөх үйлчилгээний гэрээ	ГТН 1.10 дугаар зүйл: Ажил олгогч тал Зөвлөх тал, туслан зөвлөх талууд болон Хүн хүчний талаарх Гэрээний хууль тогтоомжийн дагуу, эдгээр Талууд аливаа татвар, хураамж, төлбөр, торгууль зэрэг бусад өр төлбөрөөс /эсвэл Ажил олгогч тал нь эдгээр Талуудын нэрийн өмнөөс төлбөр төлөх ёстой, аль эсвэл нөхөн төлбөр олгох ёстой зэрэг/ чөлөөлөгдөх ёстойг баталж байгаа болно. Үүнд: А. Ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй холбоотой Зөвлөх тал, Туслан зөвлөх талууд болон хүн хүчинд /Ажил олгогч талын улс орны харьяа, аль эсвэл Ажил олгогч талын улс орны байнгын оршин суугчдаас бусад/ төлсөн аливаа төлбөр тооцоо;

Эх сурвалж: ноот бичиг, зээлийн гэрээ, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, зөвлөх үйлчилгээний гэрээ

3.94 Импортын татвараас чөлөөлөх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд:

Дүрслэл 5. Татвараас чөлөөлөх үе шат



Эх сурвалж: Сангийн яам, ЗТХЯ, ТХН

3.95 Төсөл хэрэгжих хугацаанд нийт 98.7 тэрбум төгрөгийн Гаалийн албан татвар, импортын болон дотоодын зах зээлээс худалдан авсан бараа ажил үйлчилгээний НӨАТ-аас чөлөөлснөөс тусгайлсан тогтоол, хууль эрх зүйн зохицуулалтгүйгээр 2013-2015 онд туслан гүйцэтгэгч компани, ИНЕГ гаалийн бүрдүүлэлт хийж нийт 15.0 тэрбум төгрөгийн импортын НӨАТ, төслийн хэрэгжих хугацаанд нийт 15.1 тэрбум төгрөгийн Гаалийн албан татвараас чөлөөлсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-д үзүүлэв/

- НӨАТ-н тухай хуульд /2006 он/ Зээлийн хөрөнгөөр авсан барааг татвараас чөлөөлөх талаар заалт тусгаадаагүй бөгөөд уг хуулийн шинэчилсэн найруулгын /2015 он/ 13.1.3. "Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа"⁹⁵ гэж тусгаагдсан,
- Гаалийн тариф, татварын тухай хуулийн 38 дугаар Татвараас чөлөөлөгдөх бараа зүйлийн 38.1.13-т "хууль, олон улсын гэрээнд заасан бусад бараа"⁹⁶ гэж заасан байна.
- Ерөнхий гүйцэтгэгч нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.2 дахь⁹⁷ заалт, Компанийн тухай хуулийн 7.5 дахь⁹⁸ заалтыг дагаж мөрдөөгүйгээс Мон-Пи8 зээлийн гэрээний салшгүй хэсэг болох Ноот бичгийг⁹⁹ зөрчин татвар хураамжаас чөлөөлөгджээ.

Хүснэгт 24. 2013-2016 оны импортын мэдээ /сая төгрөг/

№	Аж ахуйн нэгжийн нэр	Импортын барааны статистик дүн	Чөлөөлөгдсөн татварын дүн		
			Гаалийн албан татвар	НӨАТ	Нийт дүн
1	АЧСВС ХХК	442.4	22.1	46.5	68.6

⁹⁵ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 13.1. Дараах барааг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:

⁹⁶ 38.1. Гаалийн нутаг дэвсгэрт оруулах дараах барааг гаалийн татвараас чөлөөлнө:

38.3. Гаалийн татвараас чөлөөлөх харилцааг гагцхүү энэ хуулиар зохицуулна.

⁹⁷ 7.2. Улсын бүртгэлийн байгууллага гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

⁹⁸ 7.5. Гадаад улсын хуулийн этгээдийн Монгол Улсад оршин байгаа салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

⁹⁹ Төсвийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй Япон Улсын ханган нийлүүлэгч аж ахуйн нэгж, гүйцэтгэгч, зөвлөх байгууллага нь төслийн хэрэгжилтэд шаардлагатай бараа бүтээгдэхүүн болон тоног төхөөрөмжийг импортлох/ буцаан экспортлох тохиолдолд Монгол Улсын татвар ногдуулалт, бүх хариуцлагаас чөлөөлнө



2	Ач холдинг ХХК	701.2	35.1	73.6	108.7
3	Үлэмж ХХК	212.3	10.6	22.3	32.9
4	Эс Өү Си Эм ГХОХХК	181.2	9.0	19.0	28.0
5	Эс Си Ти Си И Эм ГХОХХК	138,753.9	6,899.6	14,565.3	21,464.9
6	Явуу-Импекс ХХК	185.2	9.3	19.4	28.7
7	ИНЕГ	2,819.4	141.0	296.0	437.0
	Нийт дүн	143,295.6	7,126.7	15,042.1	22,168.8

Эх сурвалж: ГЕГ

Бүрдүүлэлтийн дараах шалгалтыг төслийн хүрээнд гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөгдсөн нийт бараа материал, импортлогч аж ахуйн нэгжээр нэгдсэн журмаар хийх шаардлагатай нь ГЕГ-аас 2018 онд хийсэн шалгалтаас харагдаж байна.

- ГЕГ-ын даргын 2018 оны 13/18 дугаар удирдамжийн дагуу 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд туслан гүйцэтгэгч “Эс Си Ти Си Эм” ХХК-аар Гаалийн хөнгөлөлт чөлөөлөлтийн горимоор импортолсон бараа материалын бүрдүүлэлтэд шалгалт хийж “зөвшөөрлөөс хэтрүүлэн бүрдүүлэлт хийсэн”, “хөнгөлөлт чөлөөлөлтийн горимоор бүрдүүлэлт хийн импортолсон бараа бүтээгдэхүүний хаягдлыг худалдан борлуулсан” гэх зэрэг нийт 179.5 сая төгрөгийн зөрчил дутагдлыг илрүүлж татварыг бүрэн нөхөн төлүүлсэн байна.

3.96 Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, машин механизм нь чанарын шаардлага хангахгүйн улмаас засаж сайжруулах, сэлбэг хэрэгслийг болон иж бүрнээр нь дахин сольж импортолсон ба эдгээр нь хөнгөлөлт чөлөөлөлтийг давхардуулан олгох эрсдэлтэй байх тул давхардуулан импортолсон бараа материал, тоног төхөөрөмжийг буцаан экспортлох, татварыг нөхөн төлүүлэх шаардлагатай байна. Тухайлбал,

Хүснэгт 25. Агаарын хөлгийн мөстөлтийн эсрэг шингэн цацах автомашин /сая төгрөг/

№	Автомашинны үйлдвэрлэсэн улс, он	Импортолсон огноо	Барааны үнэ /статистик дүн/	Чөлөөлөгдсөн татварын дүн		
				НӨАТ	Гаалийн татвар	Нийт дүн
1	БНХАУ, 2016	2016.12.12	1,756.6	184.4	87.8	272.2
2	Швед, 2019	2019.05.16	1,933.0	203.0	96.7	299.7

Эх сурвалж: ГЕГ

3.97 ЗТХЯ болон Ерөнхий гүйцэтгэгч хооронд 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Санамж бичгийн 1.4-д “... НӨАТ-ын үнэ нь орон нутгийн туслан гүйцэтгэгчид болон нийлүүлэгчдэд төлөх дүн бөгөөд гэрээний үнийн дүнгийн нэг хэсэг байх агаад гэрээнд 2.3 тэрбум иен байхаар тооцоолж тусгасан”¹⁰⁰ заалт нь Мон-Пи8 зээлийн гэрээний хавсралт Зээлийн хөрөнгийн хуваарилалт “Дор дурдсан зардал Зээлийн санхүүжилтэд хамаарахгүй болно. Үүнд: (б) Татвар, хураамж” гэж заасантай нийцээгүй байна.

ОУНОШБ-ын менежментийн концессын гэрээнд татвар, ногдол ашиг, концессын төлбөр төлөхөөр заажээ

3.98 ЗТЯ /хуучнаар/ ЖАИКА хооронд 2014 онд техникийн туслалцааны хүрээнд санамж бичиг байгуулснаар Япон Улсын “Номура” болон Монгол Улсын “Стратежик партнерс” компанийн түншлэл шинэ нисэх буудлын менежментийн зохион байгуулалтын бүтцийг боловсруулах судалгааны ажлыг эхлүүлсэн байна.

- Нисэх буудлын менежментийг хэрэгжүүлэх бүтцийг “Төрийн өөрөө удирдах”, “Менежментийн багийг гэрээгээр томилон ажиллуулах”, “Төр, хувийн хэвшил хамтран концессын гэрээгээр хэрэгжүүлэх”, “Урт хугацааны түрээсийн гэрээгээр хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх” гэсэн харьцуулсан судалгааг үндэслэн боловсруулсан байна.

3.99 Мөн дээрх судалгааны багаас гадна менежментийн бүтцийг боловсруулах Зөвлөхийн тендерийг зарлаж Франц Монголын хамтарсан “Интерконсалтинг Групп”, “Эжис Тийн Монголиа” ХХК-ийн түншлэл шалгарч судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна.

¹⁰⁰ Гүйцэтгэгч талын Үндсэн-Туслан-Гүйцэтгэгчид татварын албанд НӨАТ төлөхгүй боловч орон нутгийн туслан гүйцэтгэгчид болон тэдгээрийн нийлүүлэгч нарт НӨАТ-г төлөх хэрэгтэй. Энэ төрлийн НӨАТ-ийн үнэ нь орон нутгийн туслан-гүйцэтгэгчид болон нийлүүлэгчдэд төлөх дүн бөгөөд Гэрээний үнийн дүнгийн нэг хэсэг байх бөгөөд Гэрээнд 2,327,000,000 япон иен байхаар тооцоолж тусгасан.



- Зөвлөх багууд олон улсын нисэх буудлын менежментийг “төр-хувийн хэвшлийн түншлэл”-ийн хүрээнд концессын гэрээгээр хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлснийг төслийн ашиглалтын өмнөх удирдах хороо, ЗТС-ын зөвлөлийн хуралдаанд танилцуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн,

3.100 Засгийн газрын 2015 оны 398 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг концессын “Хөрөнгө оруулах-Ашиглах-Шилжүүлэх” төрлөөр шууд гэрээ байгуулж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

3.101 Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд энэхүү төсөлд оролцох санал тавьсан Японы компаниудын төлөөлөлтэй¹⁰¹ хэлэлцээ хийх зорилгоор 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын 209 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Зөвлөх багуудын боловсруулсан баримт бичигт тулгуурлан “Төслийн санал авах баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулж 2016 оны 01 дүгээр сарын 25-нд Японы консорциумд хүргүүлжээ.

3.102 Японы талаас 2016 оны 04 сарын 29- ний өдөр холбогдох саналаа ирүүлснээр 2016 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ажлын хэсгээс техникийн саналыг үнэлж шаардлагад нийцсэн гэж үзсэнээр 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдөр санхүүгийн саналыг нээсэн байна.

3.103 Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 63 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг санхүүгийн саналыг үнэлж шаардлага хангасан гэж дүгнэснээр 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хэлэлцээрийн өмнөх уулзалтыг Японы талтай зохион байгуулж албан ёсны хэлэлцээ хийх тов, тулгамдаж буй асуудлууд, одоогийн нөхцөл байдлын талаар харилцан зөвшилцжээ.

3.104 Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 209 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан талтай хэлэлцээ хийх үүрэг бүхий анхны ажлын хэсгийг байгуулан ажлын удирдамжийг баталж байсан ч ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг /2016 оны 63 дугаар, 2017 оны 16 дугаар, 2018 оны 102 дугаар, 2019 оны 43 дугаар захирамж/ 5 удаа шинэчилж, ажлын удирдамжийг өөрчилсөн байна.

3.105 Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 261 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан компани байгуулах шийдвэр гарснаар “*Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт*” ХХК-ийг 2019 оны 7 дугаар сарын 01-ны өдөр улсын бүртгэлд¹⁰² хуулийн этгээдээр бүртгүүлсэн байна.

3.106 “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын “хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх” /IOT/ төрлийн гэрээг “Үндэсний хөгжлийн газар”, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК нарын хооронд 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдөр байгуулж, гэрээнд үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш 15 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх¹⁰³ гэж заасан, уг гэрээг захиргааны гэрээ бус, ашгийн төлөөх /арилжааны/ гэрээ гэж талууд зөвшөөрч¹⁰⁴ байгуулсан байна.

3.107 Засгийн газрын 2019 оны 175 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувьд хөрөнгө оруулах, нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах 17.9 сая.ам.доллартой тэнцэх хэмжээний эхлэлтийн хөрөнгө оруулалт/ЭХО/¹⁰⁵, нисэх буудлын

¹⁰¹ Япон Улсын “Мицубиши корпорац”, “Нарита Олон улсын нисэх буудлын корпорац”, “Жатко компани”, “Жалюкс компани”-ууд хамтран консорциум

¹⁰² “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ 000168199, регистрийн дугаар 3874095

¹⁰³ Концесс эзэмшигч нар харилцан тохиролцсоны үндсэн дээр 10 жилээс хэтрэхгүй хугацаагаар сунгаж болох

¹⁰⁴ Концессын гэрээний 49.1 дэх заалт

¹⁰⁵ Засгийн газрын 2019 оны 175 дугаар тогтоолын 5 дах заалт “Улаанбаатар хотын ОУНОШБ-ын бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд шаардагдах 17,100.0 мянган ам.доллартой тэнцэх 42,784.2 сая төгрөгийн хөрөнгийг ИНЕГ-ын 2017,2018 оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос санхүүжүүлэх...”-д өөрчлөлт оруулсан.



үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хугацаанд барилга байгууламж, тоног төхөөрөмжид гарч болзошгүй эвдрэл, гэмтлийг засаж хэвийн байдалд оруулах хөрөнгийн нөөц эх үүсвэрийг бүрдүүлэхэд шаардагдах 2.4 сая.ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг¹⁰⁶ гаргахаар шийдвэрлэсэн байна.

3.108 Концессын гэрээнд концесс эзэмшигч нь концессын хугацааны туршид “концессын төлбөр”¹⁰⁷-ийг концессын жил тутам тухайн концессын жилийн орлогыг¹⁰⁸ /үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш таван концессын жилийн хугацаанд¹⁰⁹/ тухайн концессын жилд УБ хотын ОУНОШБ-аар зорчсон нийт зорчигчдын тоо¹¹⁰ болон эхлэлтийн хөрөнгө оруулалтын хувь хэмжээгээр тооцоолж эрх бүхий этгээдэд¹¹¹ 2 хэсэгт хувааж¹¹² төлөхөөр¹¹³ заасан байна. Үүнд:

Эхлэлтийн хөрөнгө оруулалт¹¹⁴ 36.6 сая.ам.долларыг 0.25 сая.ам.доллар /Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатанд¹¹⁵ Концессын зүйлийн засварын ажилд бодитоор зарцуулах 5.0 сая.ам.доллар/-оор өсгөж 41.6 сая.ам.доллар болгох, зорчигчийн тоог 1.6 саяас $\leq$ 0.2 саяар нэмэгдүүлж 2.4 саяд хүргэх, концессын жилийн орлогыг 9-18.5 хувиар тооцож концессын төлбөрийг төлөх загварыг гаргасан байна.

Хүснэгт 26. Концесс эзэмшигчээс концессын төлбөрийг төлөх хувь хэмжээний хүснэгтийн нэгтгэл сая.ам.доллар/хувь

Эхлэлтийн хөрөнгө оруулалт	Эхлэлтийн хөрөнгө оруулалтын хэмжээ /сая.ам.доллар/ (B)	Зорчигч (сая) (A)		
		/1.6 саяас эхлэн 0.2 саяар нэмэгдүүлэх замаар 2.4 сая/ (A)<1.6	1.6 $\leq$ (A)<1.8 1.8 $\leq$ (A)<2.0 2.0 $\leq$ (A)<2.2 2.2 $\leq$ (A)<2.4	2.4 $\leq$ (A)
36.6 сая.ам.долларыг 0.25 сая.ам.доллаароор өсөн нэмэгдүүлэх замаар 41.6 сая.ам.доллар болж өснө	B=36.6	9%	10%, 12%, 14%, 16%	18.5%
	36.6<B $\leq$ 36.85, 36.85<B $\leq$ 37.1, 36.85<B $\leq$ 37.1 ...гэх мэт			
	41.35<B $\leq$ 41.6 B=41.6	3%	5%, 7%, 9%, 12%	14%

Эх үүсвэр: “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын “хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний 26.2.2 дах заалтын хүснэгтээс

3.109 МУЕС-ын 2019 оны 43 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний төсөлд хуулийн зөвлөхийн баг, санхүүгийн зөвлөхийн багтай¹¹⁶ хамтран ажиллаж холбогдох дүгнэлтийг гаргуулж, концессын гэрээний төсөлд эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна. Тухайлбал:

¹⁰⁶ Засгийн газрын 2019 оны 175 дугаар тогтоолын 1-т “...ИНЕГ-ын 2017-2020 оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос санхүүжүүлэхийг ЗТХС Б.Энх-Амгалан, СС Ч.Хүрэлбаатар, ИНЕГ Л.Бямбасүрэн нарт зөвшөөрсөн...”

¹⁰⁷ “концессын төлбөр” гэж концессын хугацааны туршид Нисэх буудлын бизнес эрхлэх болон Концессын зүйлийг ашиглах онцгой эрхийг олгосонтой холбогдуулан концесс эзэмшигчээс энэхүү гэрээний 26.2 дахь хэсэг /концессын төлбөр/-т заасны дагуу эрх бүхий этгээдэд төлөх төлбөрийг...

¹⁰⁸ Зохицуулалттай төлбөр, хураамж, зохицуулалтгүй төлбөр, хураамж, концесс эзэмшигчийн олсон аливаа бусад орлого /концесс эзэмшигч нь концессын хугацаанд өөрөө шууд эсхүл гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах замаар концессын талбай болон концессын зүйлийн арилжааны боломжуудыг ашиглах эрх/.

¹⁰⁹ Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш таван концессын жилийн хугацаанд дотоодын агаарын тээвэрлэгчийн үйлдэж буй олон улсын зургаан зуун/600/ миллээс дээш холын зайн нислэгийн буулт хөөрөлтийн хураамжийг тонн тутамд 17,000/арван долоон мянга/ төгрөгөөр тооцно.

¹¹⁰ Зорчигчийн тоо нь ОУ-ын болон дотоодын нислэгийн зорчигчдын тооноос бүрдэнэ.

¹¹¹ Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж буй Үндэсний хөгжлийн газар эсхүл хууль тогтоомжийн дагуу энэхүү гэрээнд заасан эрх бүхий этгээдийн эрх, үүргийг хүлээн авсан концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг

¹¹² Концессын гэрээний 26.2.4(1)-т Эхний төлбөр: концессын жилийн эхний хагасын төлбөрийг өмнөх оны концессын төлбөрийн 50%-тай тэнцүү хэмжээгээр 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төлнө. 26.2.4(2)-т Хоёр дахь төлбөр: Концессын жилийн хоёрдугаар хагасын төлбөрийг энэ гэрээний 26.2.2 дахь хэсэгт заасны дагуу тооцоолсон тухайн концессын жилийн концессын төлбөрөөс гэрээний 26.2.4(1) дэх хэсэг /концессын төлбөр/-т заасны дагуу төлсөн эхний төлбөрийг хассантай тэнцүү хэмжээгээр төлнө.

¹¹³ Монгол улсын мөнгөн тэмдэг-төгрөгөөр төлнө.

¹¹⁴ Эхлэлтийн хөрөнгө оруулалт гэж (1) Хувьцаа эзэмшигчийн гэрээнд заасны дагуу Концесс эзэмшигчийн энгийн хувьцааны захиалгын үнийн дүн болох 36.6 сая.ам.доллар болон (2) Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатанд Концессын зүйлийн Засварын ажилд бодитоор зарцуулсан ба таван сая /5,000.000/ ам.доллаароос хэтрэхгүй зардлын үнийн дүн (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатны төгсгөлд тооцоолно)-г ойлгох ба энэхүү үнийн дүнгийн нийлбэрийг ойлгоно.

¹¹⁵ Концессын гэрээнд “...Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдөр” гэж гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойш арван (10) сарын дараах өдөр эсвэл түүнээс хойших..., “...Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шат” гэж гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс үйл ажиллагаа эхлэх өдөр хүртэлх хугацааг... ойлгоно

¹¹⁶ ЗТХС-ын 2019.06.21-ны өдрийн 01/3359 дугаар ЗГХЭГ-т хүргүүлсэн албан бичигт ...Ерөнхий сайдын 2019 оны 43 дугаар захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсгийн” хуулийн зөвлөхийн баг, санхүүгийн зөвлөхийн баг, ЗТХС-ын 2019 оны 202



- ЗТХЯ-нд хүргүүлсэн Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 8-3/7086 дугаар албан бичигт: "...Монгол Улсын Засгийн газар 15 жилээр концессын гэрээг байгуулж, 16-30 дахь жилүүдэд Японы консорциумаас хүлээн авах боломжтой 334.4 сая.ам.долларын ногдол ашгийг Монгол Улсын Засгийн газар хүртэх боломжтой, Зорчигч урсгалын өсөлтийг 5.5%, 4.7%, 4%-аар таамаглахад Монголын талын нийт 630.0 сая.ам.долларын хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа 22-23 жил болно. Хэрэв өсөлт илүү сайн байвал 15 дахь жилээс хойш Монгол Улсын Засгийн газар дангаар хариуцах нь илүү хурдан хугацаанд хөрөнгө оруулалтын зардлыг нөхөн боломжийг нэмэгдүүлнэ. Сангийн яамны зүгээс концессын гэрээний хугацааг 15 жилээр тогтоохыг дэмжиж байгаа бөгөөд харин Япон улсын Засгийн газрын 65.7 тэрбум иений хөнгөлөлттэй зээлийн төлбөрийг "Улаанбаатар хотын ОУНОШБ төсөл"-өөс орох орлогоор бүрэн төлөх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа...";
- "Ажлын хэсэг"-т хүргүүлсэн ИНЕГ-ын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/1930 дугаар албан бичигт "...Урьдчилсан санхүүгийн тооцоогоор нийт концессын хугацаанд Монгол Улсын төсөвт 278-290 сая.ам.доллар /концессын төлбөр 64.3-95.2 сая.ам.доллар, ногдол ашиг 126.9-115.3 сая.ам.доллар, татвар 86.9-79.5 сая.ам.доллар/-тай тэнцэх хэмжээний хөрөнгийг төвлөрүүлэхээр байна...." гэж дурджээ.

3.110 "Хөшигийн Хөндий Нисэх Онгоцны Буудал" ТӨХХК болон Жапан Эйрпорт Менежмент ХХК нарын хоорондын хувьцаа эзэмшигчийн гэрээг 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулж, уг гэрээнд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 100 ам.доллар¹¹⁷ ба "Хөшигийн хөндий нисэх онгоцны буудал" ТӨК¹¹⁸ нь 49 хувийг эзэмшинэ, ТЗК¹¹⁹ 51 хувийг эзэмшинэ гэж заасан байна.

3.111 Концессын гэрээнд концессын хугацааны туршид Монгол Улсад концессын төлбөр болон холбогдох татвар төлөх, концесс эзэмшигч тус бүрд ногдол ашиг хуваарилах, концессын зүйлийг¹²⁰ концесс эзэмшигчид үе шаттайгаар шилжүүлэхээр заасан ч, концессын бус зүйлд "Агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмж", "Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ангaрын байгууламж"¹²¹, Шатахууны агуулах¹²², шатаах зуухны байр, Зорчигч үйлчилгээний барилгын хүндэт зочны танхим¹²³, түр хашаа, түр барилгуудыг тус тус оруулсан нь Японы Засгийн газраас Мон-Пи8, Мон-Пи12 зээлээр бий болсон 11.0 тэрбум орчим иений хөрөнгө концессын зүйлд тусгагдаагүй, зээлийн 65.7 тэрбум иенийг эргэн төлөх зохицуулалтгүй байна.

3.112 Концессын гэрээг хэрэгжүүлэх явцад Монголын талын хүлээх үүргийн биелэлтээс шалтгаалж концессын гэрээнд заасан нисэх буудлын үйл ажиллагаа /10 сарын дараах өдөр эсвэл түүнээс хойших/ төлөвлөсөн хугацаандаа эхлэхгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна Үүнд:

- "Улаанбаатар хотын ОУНОШБ"-ыг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах "Сонгино" дэд станцын барилга угсралтын ажлыг дуусгах¹²⁴

дугаар тушаалаар байгуулагдсан концессын гэрээний төсөл болон хувьцаа эзэмшигчдийн гэрээний төсөл тус бүрд хараат бус хуулийн фирмээр дүгнэлт гаргуулах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлт, ЗТХЯ-аас гаргах хууль,эрх зүйн дүгнэлт

¹¹⁷ Хувьцаа эзэмшигчийн гэрээний 2.2-ийн (а)-д компанийг байгуулах зорилгоор компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 100 ам.доллар байна.

¹¹⁸ Хувьцаа эзэмшигчийн гэрээний 2.2-ийн (а)(i)-д ХХНОБ нь нэг бүр нь 1 ам.долларын үнэ бүхий 49 ширхэг хувьцааг нийт 49 ам.доллараар бэлнээр төлж,....компани нь 49%-г гаргана, (б)(i) ХХНОБ нь нэг бүр нь 1 ам.долларын үнэ бүхий 13,229,951 ширхэг хувьцааг нийт 13,229,951 ам.долларыг бэлнээр төлж захиалж, ХХНОБ нь компанийн хувьцаа эзэмшлийн 49%-г эзэмшсэн хэвээр байна

¹¹⁹ Хувьцаа эзэмшигчийн гэрээний 2.2-ийн а)(ii) ТЗК нь нэг бүр нь 1 ам.долларын үнэ бүхий 51 ширхэг хувьцааг нийт 51 ам.доллараар бэлнээр төлж,....компани нь 51%-г гаргана, (б)(ii) ТЗК нь нэг бүр нь 1 ам.долларын үнэ бүхий 13,769,949 ширхэг хувьцааг нийт 13,769,949 ам.долларыг бэлнээр төлж захиалж, ТЗК нь компанийн хувьцаа эзэмшлийн 51%-г эзэмшсэн хэвээр байна.

¹²⁰ Концессын зүйлд 1. Терминал, түүнд хамаарах байгууламжууд: Зорчигчийн терминал /зорчигчийн терминалын барилга, рентген аппарат, металл илрүүлэгч, хилийн хяналтын байгууламж, тоног төхөөрөмж/, Ачааны терминал /ачааны терминал барилга, хилийн хяналтын байгууламж, тоног төхөөрөмж, рентген аппарат, металл илрүүлэгч/, Автомашини зогсоол, төлбөр хураах цэг/ болон Газрын үйлчилгээний тоног төхөөрөмж; 2. Аэродром, түүнд хамаарах байгууламжууд: /Хөөрч буух зурвас, явгалах зам, перрон, гал унтраах албаны байр /гал унтраах механизм/, аэродромын засвар үйлчилгээний барилга /механизм, тоног төхөөрөмж/, технологийн зам, үйлчилгээний зам, хамгаалалтын хашаа, нэвтрэх цэгийн байр, ажиглалтын байр, 3. Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжууд: /Гүний усны худаг, ус цэвэршүүлэх байгууламж; болон ус дамжуулан түгээх сүлжээ; бохир ус цэвэрлэх байгууламж; цахилгаан эрчим хүч түгээх байгууламж; шилэн кабелийн сүлжээ; дулааны цахилгаан станц; инженерийн дэд бүтцийн шугам, сүлжээ; бусад шаардлагатай байгууламж/

¹²¹ Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ангaр (техник үйлчилгээний перрон, явгалах замын хамт).

¹²² Агаарын хөлгийн шатахууны агуулах (түгээх, дамжуулах системийн хамт)

¹²³ Зорчигч теримналын Хүндэт зочны танхим- 587 кв.м

¹²⁴ Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.1-т "...Сонгино" дэд станцын барилга угсралтын ажилтай холбоотой үүссэн шүүхийн маргааныг шуурхай шийдвэрлүүлэх...", 2.2-т "...тус дэд станцыг барьж дуусгахад шаардлагатай хөрөнгийг 2020 оны улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх...", 2.3-т "...Улаанбаатар хотын ОУНОШБ"-ыг эрчим хүчээр хангах цахилгаан дамжуулах агаарын шугамын газрын асуудлыг шийдвэрлэх..."



- “Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий катерингийн барилгын ажлыг дуусгах”
- Концессын гэрээний 16.2.10-т “Нисэх буудлын үйл ажиллагаа эхлэх өдрөөс 56 (тавин зургаа)-аас доошгүй хоногийн өмнө Чингис хаан ОУНБ-ын үйл ажиллагааг УБХОУНОШБ-руу шилжүүлэх талаар Агаарын навигацийн мэдээллийн товхимол (ОУАТХ-оос тодорхойлсон)-д нийтлэхийн тулд тодорхой бэлтгэл ажлуудыг хангах /аэродромын гэрчилгээ, бүртгэлжүүлэлт/”

Төслийн хэрэгжилтэд тавих захиалагчийн болон дотоод хяналт бүрэн хэрэгжээгүй байна

3.113 Улсын МХЕГ-аас 2014-2016 онд барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, чанар, аюулгүй байдалд хяналт шалгалтыг явуулж улсын ахлах байцаагчийн 2014 онд 06/100/319, 2015 онд 07/100/344, 2016 онд 07/100/214 дугаар дүгнэлтийг гаргаж, 06/100/96, 07/008/104, 07/100/87 дугаар бүхий албан шаардлагыг ТХН-д хүргүүлжээ.

3.114 Дээрх албан шаардлагаар нийт давхардсан тоогоор 158 зөрчил илрүүлснээс 2014 онд 42, 2015 онд 48, 2016 онд 68 зөрчил тэмдэглэгдэж, албан шаардлагын биелэлтээр 2014 оны зөрчил 20-30 хувиар буурч, үүргийн биелэлт 70 орчим хувийн гүйцэтгэлтэй¹²⁵, 2015 оны зөрчил 30-80 хувийн гүйцэтгэлтэй¹²⁶.. гэж тус тус дүгнэсэн байна.

3.115 МХЕГ-ын барилгын техник хяналтаар 53, эрчим хүчний хяналтаар 21, байгаль орчин, газрын харилцаа, геодези, зураг зүйн хяналтаар 16, газрын тос, хийн хяналтаар 15, авто тээврийн хяналтаар 14, өргөх байгууламжийн хяналтаар 10, хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтаар 10, авто замын хяналтаар 8, мэдээлэл харилцаа холбооны хяналтаар 7, хот байгуулалтын болон хэмжил зүйн хяналтаар тус бүр 2 алдаа зөрчил бүртгэсэн байна. Тухайлбал,

- Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2014 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 06/100/96 дугаар “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагад Барилгын техникийн хяналтын ...Зорчигч үйлчилгээний барилгын талбайд хөдөлтийн гүн 3,54 м бөгөөд суурийн суултын гүн тус суурийн ажлыг хүйтний улиралд хийж гүйцэтгээд холбогдох арга хэмжээ авалгүй өвөлжүүлж, хөрсний хөдөлтийн гүнг мөн хэмжээгээр доошлуулсны мөрөөр арга хэмжээ аваагүй..., ...тус барилгын Е хэсгийн галд өртсөн Х6-Х7/У4-У5 хэсэг дэх багана дам нурууг буулгаагүй, Е хэсгийн бусад төмөр бетон бүтэцүүдийн бетоныг цутгахдаа дутуу нягтруулсан, бетоны гадаргууд нүх сүв, ан цав их хэмжээтэй үүссэн..., ...Зорчигч үйлчилгээний төв барилгын үндсэн бүтэцэд илэрсэн гэмтэл, хагаралтын байдалд хөдлөнгийн, эрх бүхий, итгэмжлэгдсэн лабораториор иж бүрэн шинжилгээ судалгаа,шаардагдах инженерийн тооцоог хийлгэх..., ...дээрх шинжилгээ судалгааны дүнг мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлж, цаашид авах арга хэмжээг тодорхойлуулан тогтоолох..., ...Барилга архитектурын корпорац-ын шинжилгээний дүнгээр зураг төслийн шаардлага хангаагүй бат бэх бүхий цутгамал төмөр бетон бүтэцийг тодорхой болгож, холбогдох арга хэмжээ авах, Е зоны шаардлага хангахгүй хэсгүүдийг буулга, бэхэлж хүчитгэх... гэж шаардсан байна.
- Дээрх зөрчлөөс үүдэн Зорчигч үйлчилгээний барилгын Е болон F бүсэд 2014 оны 2 сарын 20-ны өдрийг хүртэл цутгасан бетоныг 10с-ээс дээш дулаан орчинд байлгаж бэхжүүлэх арчлалтын ажлыг гүйцэтгэж байсан 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдөрт шилжих шөнө эдгээр бүсэд гал гарч бетоны дулаалгын материал шатсан..., ... Зорчигч үйлчилгээний барилгын гал гарсан хэсэгт гүйцэтгэгчийн зардлаар Японы “Concrete Diagnostic Center” компаниар хөдлөнгийн судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулан өгсөн зааварчилгааны дагуу галд өртсөн хэсгийг буулган шинээр дахин цутгасан бөгөөд гүйцэтгэгч гарсан хохирлыг бүрэн хариуцсан¹²⁷... гэж ТХН-ийн 2014 оны үйл ажиллагааны тайланд дурдсан,
- ТУХ-ны 2014 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 1/2014 дугаар хурлын тэмдэглэлд ... зорчигч үйлчилгээний барилгын талбайд галын аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүйгээс гал гарсан хохирлыг гүйцэтгэгч талд гэрээний дагуу бүрэн хариуцуулж,... гэж дурдсан ч гүйцэтгэгч Самсунг Си энд Ти ХХК-д ямар хариуцлага тооцсон нь тодорхойгүй байна.
- Мөн улсын ахлах байцаагчийн 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 07/008/104, 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 07/100/87 дугаар “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагад ...Зорчигч үйлчилгээний төвийн зоройг давхрын 40х1500/н/ хэмжээтэй цутгамал төмөр бетон 5 дам нуруунд 0,06-0,08 мм өргөнтэй хагаралт шинээр үүссэн, хагаралтын шалтгааныг тогтоогоогүй, холбогдох арга хэмжээ аваагүй /2015 онд/,... Зорчигч үйлчилгээний барилгын Е болон А, В хэсгийн зоорины давхрын үндсэн хийц бүтэцэд 2014 оноос эхлэн хагаралт цууралт үүссэн..., ...ЗҮБ-ын үндсэн хийц бүтэцэд үүссэн гэмтэл зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй, хөрс хөлдөх болон гэсэх үед ажиглалт хийгээгүй, хагаралтуудын явц байдлын талаар тэмдэглэл хөтлөөгүй /2016 онд/... гэж дүгнэж байжээ.

3.116 ЗТС-ын 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 33 дугаар тушаалаар ОУНОШБ барих төслийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, дүгнэлт

¹²⁵ Улсын ахлах байцаагчийн 2015.06.16-ны өдрийн 07/008/104 дугаар албан шаардлагын өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт /хуудас 6/

¹²⁶ Улсын ахлах байцаагчийн 2016.05.27-ны 07/100/87 дугаар албан шаардлагын өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт /хуудас 9/

¹²⁷ Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2014 оны эхний хагас жил, жилийн эцсийн ажлын тайлан



гаргах Ажлын хэсэг¹²⁸ байгуулагдаж, төслийн нэгжийн үйл ажиллагааг шалгасан тухай тайланг 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдөр гаргасан¹²⁹ ч ЗТС-д тайланг танилцуулаагүй, гаргасан зөвлөмжийг ТХН-д хүргүүлээгүй, ажлын хэсэг илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ аваагүй, тушаалын биелэлт, хэрэгжилтийг үнэлээгүй байна¹³⁰.

3.117 ТУХ-ны 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар хуралдааны тэмдэглэлд ... Төслийн үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хагас бүтэн жилээр хяналт тавьж ажиллахыг ЗТХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасан ч хэрэгжээгүй байна.

3.118 ИНЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өрийн А/892 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрүүдэд Техникийн болон Чанарын үзлэг шалгалтыг явуулж зөвлөх компанийн тавьсан хяналт хангалтгүй, гүйцэтгэгч компаниуд зөвлөх компаниас өгсөн зөвлөмж, үүрэг даалгавруудыг хангалттай биелүүлээгүй гэж дүгнэж нийт 1164 зөрчил, дутагдал илрүүлж бүртгэснээс 240 зөрчил дутагдлыг засуулж, 924 зөрчил дутагдлыг улсын комисс ажиллахаас өмнө бүрэн засаж залруулах шаардлагатай гэсэн нэгдсэн дүгнэлтийг гаргажээ. Тухайлбал:

- **Барилгын хийц, архитектурын баг:** цахилгаан, холбооны утас, гэрлийн унтраалга, тасалгааны тохируулга, цахилгааны залгуур, ариун цэврийн өрөөний тоноглол, сантехникийн холболтууд, хаалганы бариул, түгжээ, ханын өнгөлгөө, залгаасны будаа, гэрэлтүүлэг, барилгын хийц чанарын шаардлага хангаагүй, барилга байгууламжууд доторх халаагч хэрэгсэл болон дулааны шугамын холболт нь архитектурын зураг төсөл зөрүүтэй хийгдсэнээс шалтгаалан шалан дээгүүр ил холболт хийсэн, хамгаалалтгүй, цахилгаан, дулааны шугам, кабель татсаны дараа үндсэн болон тусгаарлах хананд гарсан зайг бөглөөгүй гэх зэрэг нийт 179,
- **Аэродромын баг:** хөөрч буух хучилттай зурвас, явгалах зам, перрон талбай будган тэмдэглэгээгүй, анхааруулах тэмдэггүй, резинэн чигжээс суусан, гэрэлтүүлэг хийгээгүй, ажил бүрэн дуусаагүй зэрэг нийт 18,
- **Агаарын навигацгийн үйлчилгээний баг:** Нисэх буудлын холбооны систем, зарим цахилгаан холболт, барилга байгууламжийн заслын ажлыг чанартай хийх нийт 58,
- **Цахилгааны баг:** Нийт 19 барилга байгууламжийн 10/0.4 Кв-ын цахилгаан хуваарилах байгууламжууд, хүчдэлийн самбаруудын зураг схем ажлын байранд тавигдаагүй, өрөө тасалгаа, заал танхимын унтраалга, залгуур, галын дохиоллын мэдээлэгч гэх мэт тоноглолууд өөр өөр нэр төрлийн, жигд бус суурилуулагдсан нь технологийн шаардлага хангахгүй зэрэг нийтлэг 175,
- **Холбоо, мэдээллийн технологийн баг:** кабель болон тоног төхөөрөмжүүдийн хаягжилт хийгдээгүй, кабелийн эмх цэгц, багцлал, бэхлэгээ хангалтгүй, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт бүрэн дуусаагүй, галын дохиоллын самбар дээрх алдаа засварлагдаагүй, шалны болон хананы холбооны залгуур жигд бус түвшинд хийгдсэн зэрэг нийт 244,
- **Механикийн баг:** агааржуулалт хангалтгүй, зураг схем байршуулаагүй, тэмдэглэгээ хийгдээгүй зэрэг 175 алдаа дутагдал болон дутуу гүйцэтгэгдсэн ажлууд /санал/ бүртгэсэн байна.

3.119 Техникийн комисс нь Шатахуун хангамжийн байгууламжид туршилт тохируулгын ажил хийгдээгүй, шатахууны байгууламжийн 2 талын тэжээлийн эх үүсвэрийн 1 талын эх үүсвэрийг дахин нягталж шалгах шаардлагатай гэж дүгнэж хүлээж аваагүй бөгөөд ажлын даалгаварт өгөгдсөн хүчин чадал, техникийн үзүүлэлтээс зөрүүтэй уг байгууламж нь техникийн тодорхойлолтгүй, хүлээн авах ажлыг дахин зохион байгуулах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

¹²⁸ Ажлын хэсгийн ахлагч Н.Энхтуяа/Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга/, Нарийн бичгийн дарга Н.Угандулам/ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн/, Ажлын хэсгийн гишүүд Г.Мөнхболд /ИНЕГ-ын Нисэх буудлуудын удирдах газрын дарга/, А.Баасандагва /ИНЕГ-ын Нисэх буудлын аэродром хариуцсан мэргэжилтэн/, Ж.Ариунзаяа /ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн зохицуулалт, дотоод хяналтын албаны мэргэжилтэн/, Н.Оюунбилэг/ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн/, Л.Оюунбилэг/ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын санхүүгийн хяналт, шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн/, Ц.Батжаргал/ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын мэргэжилтэн/

¹²⁹ Ажлын хэсгийн ахлагч Н.Энхтуяа, нарийн бичгийн дарга Н.Угандулам, гишүүд Г.Мөнхболд, Н.Оюунбилэг, Л.Оюунбилэг, Ц.Батжаргал, Ж.Энэрэлсайхан, А.Баасандагва, Ж.Ариунзаяа нар гарын үсэг зурж баталгаажуулсан

¹³⁰ ЗТХЯ-ны 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 10-а/2742 дугаар "Үндэсний аудитын газар"-т ирүүлсэн албан бичигт дурдсан.



3.120 ЗТХС-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 123 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн иж бүрэн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авахтай холбогдуулан хяналт, шалгалт хийх зорилгоор Зам тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэлээр ахлуулсан /комиссын дарга/ 56 гишүүнтэй “Улсын комисс” 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн¹³¹ хооронд ажиллахаар томилогдож, мөн сайдын 2017 оны 04, 05 дугаар тушаалаар комиссын бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт орж 28 гишүүн нэмэгдэж, нийт 85 гишүүнээс бүрдсэн баг ажилласан байна.

3.121 Улсын комиссын үзлэгээр зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр баригдсан инженерийн шугам сүлжээ, авто зам зэрэг 31 барилга байгууламж, тоног төхөөрөмжийг байнгын ашиглалтад хүлээн авах 12 ажлын хэсгийн тайланд нийт 710 нэрийн зөрчил илэрсэн бөгөөд зураг төслийн дагуу хийж гүйцэтгээгүй дутуу болон чанаргүй ажил 397, зураг төсөлд тусгагдаагүй боловч зайлшгүй хийх шаардлагатай 205, ашиглалтын үед хийж хэрэгжүүлэх шаардлагатай 50 ажил гэж тайлагнасан байхад комиссын нэгдсэн дүгнэлтэд нийт зөрчлийг 689, зураг төслийн дагуу хийж гүйцэтгээгүй дутуу болон чанаргүй ажил 526, зураг төсөлд тусгагдаагүй боловч зайлшгүй хийх шаардлагатай 114, ашиглалтын үед хийж хэрэгжүүлэх шаардлагатай 49 гэж зөрүүтэй нэгтгэсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт 3/

3.122 Техникийн болон Чанарын үзлэг шалгалтаар илэрч улсын комисс ажиллахаас өмнө засуулах 924 зөрчил, улсын комиссын дүгнэлтээр 689 зөрчил, нийт 1613 зөрчил дутагдлыг засуулахаас хяналтын явцад 7 зөрчлийг засуулж, комиссын гишүүд тус бүрийн гаргасан 408 зөрчил дутагдлыг байршил, агуулгаар давхацсан саналыг 191 болгон нэгтгэж, гишүүдийн гаргасан саналд тодорхой тайлбар гарган гишүүдэд танилцуулж хаасан 131, барилга байгууламжийн ажил дуусахаас өмнө хийж дуусгах ажлын жагсаалт /Punch list/-д нийт 1205 ажлын жагсаалт гаргаж талууд¹³² баталгаажуулсан ч уг жагсаалтад 73 зөрчил нэмж, нийт 1278 зөрчил бүртгэсэн байна.

3.123 Барилга байгууламжийн ажил дуусахаас өмнө хийж дуусгах ажлын жагсаалтад бүртгэгдсэн 1278 зөрчил дутагдлаас зөвлөх компани 262, ерөнхий гүйцэтгэгч 66, туслан гүйцэтгэгч 826, ИНЕГ 146 зөрчил дутагдлыг хариуцан засварлаж хүлээлгэн өгөхөөр талууд тохиролцож гүйцэтгэснээс 2019 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн байдлаар нэмэлт хөрөнгө гарган зайлшгүй хийх шаардлагатай 20 ажлаас¹³³ 19 ажилд 102,336.0 мянга, нэмэлт 5 ажилд 45,434.0 мянга /оператор компанид шилжүүлэн гүйцэтгэх 3, тайлбараар хаах 1, ашиглалтын явцад гарсан доголдол 1/, нийт 24 ажилд 207,296.8 мянган төгрөгийг зээлийн хөрөнгөөс гаргаж гүйцэтгэсэн байна.

3.124 МУЗГ-ын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлийн 7.6-д “...ОУНОШБ барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагаа, зээлийн захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үр дүнг 2017 оны 10 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, ЗТХС Д.Ганбат, БХБС Г.Мөнхбаяр нарт даалгав...” гэсэн ч хамтарсан ажлын хэсэг байгуулагдаагүй, төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагаа, зээлийн захиран зарцуулалтад хяналт шалгалт явуулаагүй, холбогдох яамдын хамтын үүрэг хариуцлага, уялдаа холбоо хангалтгүй, улсын хэмжээний ач холбогдол бүхий томоохон төслийн хэрэгжилтэд ач холбогдол өгч ажиллаагүй байна.

3.125 ИНЕГ-ын 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/42 дугаар тушаалаар ОУНОШБ барих төслийн нэмэлт зээлийн гэрээний хүрээнд баригдаж буй барилга байгууламж, тоног төхөөрөмжид үзлэг хийж нэгдсэн дүгнэлт гаргах зорилготой 74 гишүүнтэй 5 ажлын хэсэг 2018 оны 02 дугаар сарын 01-ээс 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл ажиллаж, 12 барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид техникийн үзлэг явуулж, нийт 707 зөрчил дутагдал бүртгэснээс 66 зөрчил дутагдалд тодруулга хийх шаардлагатай, 641

¹³¹ Зам тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан.

¹³² Зөвлөх, Гүйцэтгэгч, ТХН, ИНЕГ

¹³³ ТУХ-ны 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд Н.Энхбат /ТУХ-ний нарийн бичгийн дарга/ “...манайхаас хийлгэх гэж байгаа 20 асуудлыг шийдье гэхээр ЖАЙКА-с санхүүжүүлэхээс татгалзаж байгаа, эдгээр нь төслийн анхны тохирсон ажлын тоо хэмжээнд анхнаасаа огт ороогүй ажлууд...”, шийдвэрлэсэн: “...улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдалтай танилцаад шаардлагатай гэж үзсэн 20 ажлыг зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх асуудлыг ЖАЙКА байгууллага болон гүйцэтгэгч компанитай хэлэлцэн, шийдвэрлэх нь зүйтэй...”/



зөрчил дутагдлыг ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч “М Си Эс Проперти” ХХК нарт хариуцуулан зөрчлийг арилгаж баталгаажуулсны дараа Улсын комисс ажиллуулах нэгдсэн дүгнэлтийг гаргасан байна.

3.126 БХБС-ын 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 128 дугаар тушаалаар ОУНОШБ барих төслийн ажлын нэмэлт гэрээний хүрээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах зорилгоор 24 гишүүнтэй комиссыг байгуулж, ИНЕГ-аас 16 инженер техникийн, ЗТХЯ-аас 3, МХЕГ-аас 3, БОАЖЯ-аас 1, БХТ-өөс 3, нийт 50 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллажээ.

3.127 Улсын комисс нь ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч “М-Си-Эс Проперти” ХХК-ийн гүйцэтгэсэн барилга байгууламжид 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдөр /2018/02 дугаар/ 3 акт үйлдэж, үүргийн биелэлтээр барилга байгууламжийг ашиглалтад авахаар шийдвэрлэсэн байна.

3.128 Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 166 дугаар захирамжаар ОУНОШБ-ын үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад оруулахад тулгамдаж байгаа асуудлыг судалж, шийдвэрлүүлэх үүрэг бүхий Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан 14 гишүүнтэй “Ажлын хэсэг” байгуулагдаж, ажлын хэсгийн түвшинд авч хэрэгжүүлэх 36 арга хэмжээний төлөвлөгөөг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр баталсан байна.

3.129 Ажлын хэсэг нь 2018 онд 2 удаа хуралдсанаас 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн II хуралдаанаар 8 асуудлыг шийдвэрлэх чиглэл гаргаж “...ажлын хэсгийн ээлжит хуралдааныг сар бүрийн эхний хагаст багтаан хуралдуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдлыг тухай бүр танилцуулж байх...” гэж шийдвэрлэсэн ч ажлын хэсэг дахин хуралдаагүй, биелэлтийг хэрхэн үнэлж дүгнэж ирсэн нь тодорхой бус байна.

ОУНОШБ-ыг түшиглэн хот байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна

3.130 Засгийн газрын 2012 оны 217 дугаар тогтоолоор “Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г баталж, “шинэ хотыг байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж 2012 оны IV улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх”, “Шинэ хотын инженерийн барилга, байгууламж барих бэлтгэл ажлыг хангаж, эхний ээлжид дэд бүтцийг барьж байгуулах ажлыг зохион байгуулах”-ыг ЗТБХБС, ЭБЭХС, НЗД, Төв аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосон боловч хэрэгжээгүй байна.

3.131 УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т “Аэросити” дагуул хотод 1695 га газарт 2020 оны байдлаар 45.0 мянган хүн оршин сууна гэж төлөвлөсөн байна.

3.132 Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг” баталж “нийслэлийн хилийн цэст өөрчлөлт оруулах, шинэ хот /Аэросити/-ыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлаар холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан УИХ-аар шийдвэрлүүлэх талаар шуурхай арга хэмжээ авах¹³⁴”-ыг БХБС Х.Баделхан, Нийслэлийн ЗД-ын орлогч Ж.Батбаясгалан нарт үүрэг болгожээ.

¹³⁴ Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүрдлийг баталж, батлагдсан төлөвлөгөөний дагуу шинэ хотыг байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдвэрлүүлэх.



Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrt.d.gov.mn, http://www.mrt.d.gov.mn

2020.03.04 № 02/934
танай 2020.02.17-ны № 477 -Т

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нэмэлт горим хэрэгжүүлж, өөрчлөлт оруулсан тайлангийн дүгнэлтэд дараах саналтай байна. Үүнд:

1. Дүгнэлтийн 3 дахь хэсэгт “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлсэн” гэсэн дүгнэлтэд Төсөл хэрэгжүүлэх нэгж нь өөрт олгогдоогүй ямар эрхийг хэрэгжүүлснийг тодорхой тусгах;

2. Дүгнэлтийн 4 дэх хэсэгт “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээнд тусгасан Монголын талын хүлээх үүргийн биелэлтээс шалтгаалж нисэх буудлын үйл ажиллагаа гэрээнд заасан хугацаанд эхлэхгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна” гэснийг Монгол талын хүлээх үүргээс аль байгууллагаас хамаарсан, ямар үүргийн биелэлтээс шалтгаалж байгааг тодорхой тусгах;

3. Тайлангийн төслийн 36 дугаар хуудасны 3.64 дэх хэсэгт төслийн үе шатны санхүүжилт нь талуудын хянан баталгаажуулах үйл ажиллагаа удааширснаас шалтгаалан хоцорч, төлбөр үүссэнтэй холбогдуулан доорх тайлбарыг өгч байна.

- Гүйцэтгэлийг Зам, тээврийн хөгжлийн яам хянаж баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлэх үе шатны хугацаа нь хуваарийн дагуу хуанлийн 5 хоногт багтсан байхаар байдаг. Харин зарим тохиолдолд эдгээр 5 хоногт амралтын бямба, ням гараг, бүх нийтийн тэмдэглэлт баяр ёслол, нийтээр амрах амралтын өдрүүд давхцаж таардаг.

- Зарим тохиолдолд гүйцэтгэгчээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлтэй холбоотой нэмэлт материал, тодруулга, тайлбар авах, зөвлөх болон Төсөл хэрэгжүүлэх нэгжээс баримт бичгийн бүрдлийг гүйцээлгэн авахад мөн тодорхой хугацаа шаардагддаг болно.

Иймд барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах хугацааг оновчгүй тогтоосон нь дээрх дүгнэлт гарахад нөлөөлсөн гэж үзэж байна.

4. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нэмэлт горим хэрэгжүүлж, өөрчлөлт оруулсан тайлангийн төсөлд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны 01/492 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг хавсралтаар хүргүүлэв.

Тайланд тусгах саналыг харгалзан үзэхийг хүсье.

Хавсралт: 7 хуудастай.

ДЭД САЙД



Л.ХАЛТАР

011145



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Д.ЗАНДАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.07.15 № 10-1/4661
танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн “Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудал барих төслийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах санал болон тайлбарыг хүргүүлж байна.

УАГ-ын
тайлбар
3-г үзнэ
үү

1. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд зөвлөмж болгосон хэсгийн нэгдэх заалтаас “төсөвт өртөгт хөндлөнгийн үнэлгээ, магадлал хийлгэдэг жишгийг нэвтрүүлэх, эрх зүйн зохицуулалттай болгох” гэснийг дараах үндэслэлээр хасах саналтай байна. Үүнд:

1.1. Барилгын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 4.1.30 дахь заалтад “зураг төсөл нэр томъёог ... техник, эдийн засгийн үндэслэл, ...өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг гэж;

1.2. 4 дүгээр бүлгийн 4.1.6 хэсэгт “барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт нэр томъёог ...зураг төсөлд хараат бус, бие даасан, мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргах иргэн, хуулийн этгээдийг” гэж;

1.3. Чиглэлийн яамдын дэргэдэх салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөл, техникийн зөвлөлөөр холбогдох дүгнэлт гаргах, зөвшилцөх, баталгаажуулах зэрэг харилцааг сайдын тушаалаар журамласан байх тул одоогийн хууль, эрх зүйн зохицуулалтаар төсөвт өртөгт хараат бус, бие даасан магадлал хийх боломжтой;

1.4. Мөн төслийн төсөвт өртөгт нэмэлтээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэх жишгийг нэвтрүүлэх нь төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, зардлыг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй.

2. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд зөвлөмж болгосон хэсгийн хоёр дахь заалтад дурдсан анхаарах зүйлсийг Засгийн газраас гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн гэрээ хэлэлцээр байгуулахад бүрэн хангаж ажиллаж байгаа болно.

УАГ-ын
тайлбар
4-г үзнэ
үү

3. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвлөмж болгосон хэсгийн нэгдэх заалтыг дараах шалтгааны улмаас хасах саналтай байна. Үүнд:

3.1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөлд зээлдүүлэгч улсаас тавигддаг нийтлэг шаардлага /тухайн улсын гүйцэтгэгч байх, тухайн улсаас гаралтай бараа, бүтээгдэхүүн худалдан авалт хийх хувь хэмжээнд доод хязгаар заадаг нөхцөлт зээл - tied aid credit/ нь тухайн улсын экспортоо нэмэгдүүлэх, компаниуддаа өрсөлдөөний давуу байдал бий болгох бодлоготой уялддаг бөгөөд Монгол Улсын хөгжлийн түнш гол улсууд, жишээлбэл Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ЭЗХАХБ/-ын гишүүн АНУ, ХБНГУ, Япон Улс, БНСУ, БНФУ, БНПУ, Австри Улс, мөн гишүүн бус БНХАУ ийм бодлого баримталж байна.

2745



3.2. Нөхцөлт зээл нь төслийн өртгийг 30% хүртэл нэмэгдүүлэх боломжтой гэсэн ЭЗХАХБ-ын судалгаа (OECD They tying of Aid) байдаг ч Монгол Улсын хувьд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгод нийцүүлэн, тухайн улс оронтой хоёр талт хамтын ажиллагааны стратеги, чиглэлийг харгалзан хөгжлийн албан ёсны хамтын ажиллагааны хүрээнд 100% буцалтгүй тусламж, эсвэл 35% буюу түүнээс дээш хөнгөлөлтийн түвшин бүхий нэн хөнгөлөлттэй зээлээр төслийг хэрэгжүүлснээр тухайн улсын техник, технологийн өндөр хөгжил, давуу талыг ашиглах, нэвтрүүлэх, нутагшуулах, арилжааны нөхцөлтэй зээл авахгүйгээр нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж Засгийн газрын өрийн дарамтыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

3.3. Засгийн газар нь хоёр талт хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийн зээлийн хэлэлцээр, төсөл хэрэгжүүлэх гэрээний хэлцэлийг хийхдээ зээлдүүлэгч улсаас гаралтай гүйцэтгэгч, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний төслийн нийт санхүүжилтэд эзлэх хувь хэмжээг бууруулах, монголын талын туслан гүйцэтгэгч, дотоодоос нийлүүлэх боломжтой түүхий эд материал, ажиллах хүчний хэмжээг аль болох нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажилладаг.

4. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвлөмж болгосон хэсгийн сүүлийн хоёр дахь заалтад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

4.1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн гаалийн болон импортын НӨАТ-ын чөлөөлөлт, хөнгөлөлттэй холбоотой үйл ажиллагааг цахимжуулан хурдан шуурхай болгох, хүнд суртлыг арилгах, мэдээ, мэдээллийн найдвартай байдлыг хангах, оролцогч талуудын хяналт, ил тод байдлыг сайжруулах зорилгоор "Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийн удирдлагын систем (ODAFIN)"-ийг хөгжүүлэн сайжруулах ажлыг хэрэгжүүлж байна.

4.2. Гаалийн болон НӨАТ-ын чөлөөлөлтийн асуудалд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас дотоод аудит, мөн 2 жил тутамд Үндэсний аудитын ерөнхий газраас аудитын хяналт шалгалтыг хийж, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРОНХИЙ ГАЗАР**

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Баянт-Ухаа,
Утас: 71-28-20-64, 71-28-21-02 Факс: (976) 7004 9625
И-мэйл: info@mcaa.gov.mn, Вэбсайт: www.mcaa.gov.mn

2020.03.04 № 01/492
танил 2020.02.21 -ны № 09/228 -г

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА ТАНАА**

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны буудлын төслийн хэрэгжилт, үр дүнд Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх тайлбарыг саналын хамт хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 6 хуудастай.

ДАРГА /  Л.БЯМБАСҮРЭН

17120 0799



Тайлангийн төслийн 3.123-д ирүүлсэн санал:

УАГ-ын
тайлбар
5-г үзнэ үү

“УАГ-аас гүйцэтгэлийн аудит хийх үед эдгээр 131 зөрчлийн биелэлт 90 хувьтай байсан бөгөөд энэхүү дүгнэлт нь жилийн өмнөх мэдээлэл дээр үндэслэсэн байна. УБХОУШНБ-ын үйл ажиллагааг эхэлсэн үед нисэхийн болон нислэгийн аюулгүй байдал, нислэг үйлдвэрлэлтэй холбоотой эрсдэлтэй цэгүүдийн судалгааг гаргаж, Улсын комиссын гишүүдээс нэмэлтээр хийх талаар өгсөн саналуудыг тодорхой тайлбар гарган, тухайн гишүүдэд нь танилцуулан хаасан. Бусад бүх зөрчил дутагдлыг (comment) нэг бүрчлэн хяналтын (WIR) хуудсаар холбогдох материалуудыг үндэслэн хаасан буюу арилгасан тухай ажлын нэгдсэн жагсаалт (Punch List)-ыг хавсаргаав. Аудиторуудад энэхүү материалуудыг тухай бүр тодорхой тайлбарлан 2019 оны 07 дугаар сард хүлээлгэж өгсөн.” тул энэ хэсгийг хасах саналтай байна

Тайлангийн төслийн 3.125-д ирүүлсэн санал:

УАГ-ын
тайлбар
6-г үзнэ үү

“Энэхүү барилга байгууламжыг захиалагч (ашиглагч) байгууллага болох Иргэний нисэхийн ерөнхий газрын мэдэлд 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрөөс эхлэн ашиглалтад оруулахыг Улсын Комисс (УК) зөвшөөрсөн. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 07/02/18 дугаар авч баталгаажсан. УК-ын Актуудыг баталгаажихаас өмнөх болон дараа (он сар дугаар авч баталгааждаг) 2 хувилбараар аудиторуудад хүлээлгэн өгсөн болно Улсын Комиссын акт 5 хуудас, хуралдааны тэмдэглэл 70 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 42 хуудас материал, барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалтыг хавсарган аудиторуудад тухайн үед хүлээлгэн өгсөн.” тул энэ хэсгийг хасах саналтай байна

Тайлангийн төслийн 3.4-д ирүүлсэн санал:

УАГ-ын
тайлбар
7-г үзнэ үү

“Монгол Улсын Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10 дугаар бүлэгт Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүргийг заасан хэдий ч ИНЕГ үүргээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдсан байна. Гэсэн хэдий ч, ИНЕГ-ын Нисэх буудлуудын бодлогын хэлтэс Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хамт төслийн үйл ажиллагаанд оролцож ирсэн.” гэж нэмэх саналтай байна

Тайлангийн төслийн 3.6-д ирүүлсэн санал:

УАГ-ын
тайлбар
8-г үзнэ үү

ТУХ-нд талуудын гэрээний үр дүнг танилцуулах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, санхүүжилтийг хянах, тооцоо нийлж баталгаажуулах ажлууд дээрх журмын дагуу хийгдэж ирсэн тул энэхүү дүгнэлтийг хасах саналтай байна.

Тайлангийн төслийн 3.42-д ирүүлсэн санал:

УАГ-ын
тайлбар
9-г үзнэ үү

“ИНЕГ-ын Үйлдвэрлэлийн нэгж нь 2013-2019 онуудын үйл ажиллагааны төсвийн Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын хамтарсан тушаалаар батлуулсаар ирсэн. Орлогоос зардлыг (үүнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг оруулдаггүй) хасаж, үлдэх хөрөнгийг Улсын төсөвт төвлөрүүлсээр ирсэн. Аудитын тайланд дурьдсан 2013-2017 оны татварын дараах цэвэр ашиг нь дараахь шалтгааны улмаас гарсан:

- Өнгөрөлтийн нислэгийн агаарын навигацгийн үйлчилгээний орлого нь нийт орлогын 85-90%- ийг эзэлдэг бөгөөд ам.доллараар орж ирдэг учраас ханшийн өсөлтийн улмаас орлого нэмэгдсэн;
- Дэлхийн эдийн засгийн өсөлтийн улмаас өнгөрөлтийн нислэгийн тоо, орлого төлөвлөгөөнөөс давсан;

Иймд, ИНЕГ нь цэвэр ашигтай гарах эсэхийг урьдчилан нарийн тооцоолох боломжгүй учраас төсөл хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэр баттай гарна гэж найдаж болохгүй. ИНЕГ нь цэвэр ашиг гарсан нөхцөлд тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг, нислэгийн аюулгүй ажиллагааг хангахын тулд хөрөнгө оруулалтад зарцуулах шаардлагатай. Тухайлбал, саяхан гарсан коронавирусын улмаас дэлхийн эдийн засгийн хямрал болж, манай тооцоолсон нислэгийн тоо, АНУ-ний орлого буурч эхлээд байна. Ямар ч төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр нь



тодорхой байх ёстой. ИНЕГ нь жил бүр орлогын 50-60 хувийг жил бүрийн Төсвийн тухай хуулийн дагуу Улсын төсөвт төвлөрүүлсээр ирсэн.

МОН-ПИ12 Зээлийн гэрээ 2015 оны 04-р сарын 16-ны өдөр байгуулагдсан бөгөөд зээлийн нийт дүн 36,8 тэрбум иен (610.5 тэрбум төгрөг энэ өдрийн ханшаар) бөгөөд ИНЕГ-ын цэвэр ашгаар хэрэгжүүлэх боломж байхгүй (хүрэлцэхгүй) байсан нь тодорхой харагдаж байна. МОН-ПИ12 зээлийг авахгүйгээр цогцоор нь шинэ нисэх буудлыг барих боломжгүй байх байсан” тул энэ хэсгийг хасах саналтай байна

ҮАГ-ын
тайлбар
10-г үзнэ үү

Тайлангийн төслийн 3.86-д ирүүлсэн санал:

Зээлийн санхүүжилтийн тооцооны баримт материалууд ИНЕГ-аар дамжиж байгаагүй нь хөрөнгийн бүртгэлд зөрүү гарах шалтгаан болсон байна.” Тайлбарыг үндэслэн ТХН-ийг дээрх журамд заасан үүргийг хангалттай биелүүлээгүй гэж өөрчлүүлэх саналтай байна.

ҮАГ-ын
тайлбар
11-г үзнэ үү

Тайлангийн төслийн 3.87-д ирүүлсэн санал:

Зээлийн санхүүжилтийн тооцооны баримт материалууд ИНЕГ-аар дамжиж байгаагүй нь хөрөнгийн бүртгэлд зөрүү гарах шалтгаан болсон байна.” Тайлбарыг үндэслэн ТХН-ийг дээрх журманд заасан үүргийг хангалттай биелүүлээгүй гэж өөрчлүүлэх саналтай байна.



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛААНБААТАР ХОТЫН
ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ
ШИНЭ БУУДАЛ БАРИХ
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

41100 ш/х-117, Хөшигийн хөндий, Зуунмод сум, Төв аймаг,
Утас: 7711-0213, 34-21-92, Факс: (976) 7711-0206,
<http://www.nubia.mn>

2019.07.03 № 252
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газраас "Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд оруулах санал болон холбогдох тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 272 хуудастай.

Хүндэтгэсэн,

ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Н.ОНХБАТ





ҮАГ-ын тайлбар 12-г үзнэ үү	Тайлангийн төслийн 2.59-д ирүүлсэн санал: “Ерөнхий туслан гүйцэтгэгч нь Дэд туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа өөрсдийн журмын дагуу нэг төрлийн ажилд 3-с доошгүй компанийг олон улсын төсөл дээр ажил гүйцэтгэсэн дадлага, туршлага, санхүүгийн чадавх, инженерийн техникийн ажилчдын мэдлэг, ур чадвар, тоног төхөөрөмж, тухайн ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл зэргийг нарийн судалсны үндсэн дээр бие даан зохион байгуулдаг тул сонгон шалгаруулалтыг нээлттэй өрсөлдөөнтэй явагдсан гэж үзэж байна. ТХН нь дэд туслан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад ямар нэгэн байдлаар оролцдоггүй бөгөөд сонгон шалгаруулалт төслийн гэрээ, туслан гүйцэтгэгчийг сонгох журам болон бусад баримт бичигт заасны дагуу явагддаг болно. Төслийн ерөнхий туслан гүйцэтгэгч нь нийт 203 ажил гүйцэтгэх гэрээ дэд туслан гүйцэтгэгчтэй байгуулсны дотор ТХН-ийн ажилтны хамаарал бүхий нэг компани байсан нь сонгон шалгаруулалтыг бүхэлд нь өрсөлдөөнгүй, хаалттай явагдсан байх эрсдэлтэй гэж дүгнэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Тухайлбал хэсгийн дүгнэлт нь Вортекс ХХК нь 885.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий будгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулаад 1,974.2 сая төгрөгийн санхүүжилт авсан гэж ойлгогдож байна. Вортекс ХХК нь Самсунг Си энд Ти ХХК-тай нийт 4 удаа гэрээ хийсэн бөгөөд 1,974.2 сая гэдэг нь нийт 4 гэрээний үнийн дүнгийн нийлбэр юм.” Иймд дээрх тайлбарыг үндэслэн хасах саналтай байна.
ҮАГ-ын тайлбар 13-г үзнэ үү	Тайлангийн төслийн 3.9-д ирүүлсэн санал: “ТХН нь улсын бүртгэлд бүртгэгдээгүй ИНЕГ гэсэн нэр бүхий албан бланк, Мон-Пи8 тэмдэг ашиглан үйл ажиллагаа явуулсан байна. ЗТХЯ болон ИНЕГ-аас тэмдэг нэр ашиглах зөвшөөрөл олгосон баримт ирүүлээгүй болно. Тухайлбал хэсгийн 2 дахь заалт: “ЗТЯ, Мицубиши-Чиёода хамтарсан түншлэлийн хооронд 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан “Нэмэлт гэрээ”-нд ЗТЯ-ыг төлөөлж ТХН-ийн захирал Н.Энхбат гарын үсэг зурсан”-гэх хэсэгт нэмэлт баримтыг хавсаргаав. Энэхүү нэмэлт гэрээ гэх баримт нь зөвхөн япон гүйцэтгэгчийн дотооддоо ашиглах зориулалтаар гаргуулсан эрх зүйн чадамжгүй бичиг баримт юм.” Иймд дээрх тайлбарыг үндэслэн хасах саналтай байна.
ҮАГ-ын тайлбар 14-г үзнэ үү	Тайлангийн төслийн 3.18-д ирүүлсэн санал: “Тухайлбал: “Боорчи” ХХК-ийн гэрээний зураг төсөл болон геологийн судалгаанд ПК1+260-ПК1+500 байрлалд шавартай хөрс гэж тусгагдаагүй байсан бөгөөд газар шорооны ажлын үед ханасан шавар болон өнжмөл цэвдэг илэрсэн. Иймээс технологийн дагуу суурь хөрсийг солих шаардлага үүссэн. Боорчи ХХК нь хөрс солиход ажилд 72.3 сая төгрөг нэмэлтээр шаардлагатай гэсэн төсөв ирүүлсэн. Иймээс “Самсунг Си энд Ти” ХХК нь Боорчи ХХК-ийн гүйцэтгэх үерийн хамгаалалтын далангийн зүүн сувгийн ПК1+260-ПК1+500 хооронд намагтай хэсгийн болон хоолойн сувгийн ажлыг Магадашгүй ажил буюу Variation Orders /2016 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн/-д 14,557.4 иен буюу 264.4 сая төгрөгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн нь Боорчи ХХК-ний гүйцэтгэхээр өгсөн үнээс 42.8 сая төгрөгөөр зөрүүтэй болсон байна.” гэж найруулгын тухайд өөрчлөх саналтай байна.
ҮАГ-ын тайлбар 15-г үзнэ үү	Тайлангийн төслийн 3.48-д ирүүлсэн санал: “Зөвлөх, ТХН барилгын ажлын гүйцэтгэлийн зардлын зүйл тус бүрээр нарийвчлан хянан баталгаажуулан ЗТХЯ-нд хүргүүлдэг бөгөөд ЗТХЯ-аас гүйцэтгэлийн зардлыг хянан үзэж Сангийн яаманд хүргүүлдэг, СЯ нь банкны мэдээллийг шалгасны үндсэн дээр төлбөрийн тодорхойлолтыг баталгаажуулдаг байна.” гэж найруулгын тухайд өөрчлөх саналтай байна.
ҮАГ-ын тайлбар 16-г үзнэ үү	Тайлангийн төслийн 3.88-д ирүүлсэн санал: “Ерөнхий гүйцэтгэгчийн 2014 оны 07 дугаар сарын наадмын 150.1 сая төгрөг нэхэмжлэлийн анхан шатны баримтуудыг ТХН хянан үзэж зардлыг бууруулах шаардлагатай гэж үзсэний дагуу Зөвлөх компани наадмын нэхэмжлэлд 50.4 сая төгрөг төлөх үндэслэлтэй хэмээн үзсэн болно. Уг санхүүжилтийг ТУХ-ны хурлын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар тэмдэглэлээр гарсан шийдвэрийн дагуу зээлийн хөрөнгөөс 2014 оны 07 дугаар сарын наадмын төлбөрт 50.4 сая төгрөг төлсөн болно.” Иймд уг тайлбар, нотлох баримтыг үндэслэн хасах саналтай байна.

**Саналд өгсөн тайлбар:**

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг судлан үзэж, аудитын баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

Саналд өгөх тайлбар	
ҮАГ-ын тайлбар 1	Тайлангийн 27 дугаар хуудасны 3.9 дэх хэсэгт тодорхой дурдсан тул саналыг хүлээж аваагүй болно.
ҮАГ-ын тайлбар 2	Тайлангийн 47 дугаар хуудасны 3.112 дахь хэсэгт тодорхой дурдсан тул саналыг хүлээж аваагүй болно.
ҮАГ-ын тайлбар 3	Ирүүлсэн саналыг хянан үзэж зөвлөмж хэсэгт дараах найруулгын өөрчлөлт оруулав. • Гадаадын зээлээр хэрэгжих төсөл хөтөлбөр нь Өрийн удирдлагын тухай хуульд заасан холбогдох шалгуурыг хангасан эсэхэд тавих хяналтыг сайжруулж, төслийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм журам, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох,
ҮАГ-ын тайлбар 4	Ирүүлсэн саналыг хянан үзэж зөвлөмж хэсэгт дараах найруулгын өөрчлөлт оруулав. Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын Хороонд толилуулах нь: • Хууль тогтоомжоор шалгуур болгосон төсвийн зарчим, өрийн тусгай шаардлагын зохицуулалтыг тогтвортой байлгаж, цаашид гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрийн зээлийн гэрээг иж бүрэн боловсруулсан эсэх, төсөв, мөнгөний бодлоготой уялдуулсан эсэхэд анхаарал хандуулахыг санал болгож байна.
ҮАГ-ын тайлбар 5	Саналыг хүлээн авч тайлангийн 49 дүгээр хуудасны 3.122 дахь хэсгийн өгүүлбэрийг ...Техникийн болон Чанарын үзлэг шалгалтаар илэрч улсын комисс ажиллахаас өмнө засуулах 924 зөрчил, улсын комиссын дүгнэлтээр 689 зөрчил, нийт 1613 зөрчил дутагдлыг засуулахаас хяналтын явцад 7 зөрчлийг засуулж, комиссын гишүүд тус бүрийн гаргасан 408 зөрчил дутагдлыг байршил, агуулгаар давхацсан саналыг 191 болгон нэгтгэж, гишүүдийн гаргасан саналд тодорхой тайлбар гарган гишүүдэд танилцуулж хаасан 131, барилга байгууламжийн ажил дуусахаас өмнө хийж дуусгах ажлын жагсаалт /Punch list/-д нийт 1205 ажлын жагсаалт гаргаж талууд ¹³⁵ баталгаажуулсан ч уг жагсаалтад 73 зөрчил нэмж, нийт 1278 зөрчил бүртгэсэн байна... гэж найруулгын өөрчлөлт оруулав.
ҮАГ-ын тайлбар 6	Тайлангийн 49 дүгээр хуудасны 3.125 дахь хэсэгт дурдсан зөрчлийг аудитын явцад ИНЕГ-ын Ашиглалтын өмнөх захиргаанаас холбогдох баримт материалд нөхөн бүрдүүлэлт хийсэн бөгөөд аудитаар уг зөрчлийг залруулсан гэж үзэж саналыг хүлээн авч тайлангаас хасав.
ҮАГ-ын тайлбар 7	МОН-Пи8 зээлийн гэрээнд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах талаар тусгаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй гэж үзэж тайлангийн 25 дугаар хуудасны 3.4 дахь хэсгийн өгүүлбэрт өөрчлөлт оруулаагүй болно.
ҮАГ-ын тайлбар 8	Мон-Пи8, Мон-Пи12 зээлийн гэрээнд ИНЕГ-ийг хэрэгжүүлэгч агентлаг", "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээнд "Ажил олгогч", "Барилгын ажлыг гүйцэтгэх" гэрээнд "Захиалагч"- байхаар тус тус заасан ч гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байх тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.
ҮАГ-ын тайлбар 9	Тайланд төслийн нийт өртөг 36.8 тэрбум иений хувьд бус алсын удирдлагатай хэт богино долгионы 2 ширхэг радио станц гэх мэт зарим тоног төхөөрөмж, хамгаалалтын хашаа, харуулын байр, ландшафтын ажил, аюулгүй байдлын үзлэгийн болон нэвтрэн өнгөрүүлэх байр зэрэг энгийн хийцтэй барилга, байгууламжийг ИНЕГ-ын цэвэр ашгаас санхүүжүүлэх боломжтой байсан гэж үзсэн тул уг саналыг хүлээн авах боломжгүй байна.

¹³⁵ Зөвлөх, Гүйцэтгэгч, ТХН, ИНЕГ



ҮАГ-ын тайлбар 10	ИНЕГ-аас ТӨБЗГ-т хүргүүлсэн 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01/2985 дугаарт албан тоот бичгийн хавсралт хөрөнгийн жагсаалтад дээрх 2 автомашиныг давхардалтай бүртгэлээр илгээж, ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолд давхардуулсан хэвээр баталсан байгаа нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 14.1.7-д заасантай хамааралгүй тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулаагүй болно. Дээр дурдсан 2 автомашин давхардуулсан зөрчлийг аудитын явцад илрүүлсэн бөгөөд энэ талаарх мэдээллийг ИНЕГ-аас ҮАГ-т ирүүлж байгаагүй болно.
ҮАГ-ын тайлбар 11	Зээлийн санхүүжилтээр 63.2 сая иенээр худалдан авсан алсын удирдлагатай хэт богино долгионы 2 ширхэг радио станцыг ИНЕГ-ын даргын 2018 оны А/464 дүгээр тушаалаар Хөвсгөл, Увс аймгуудад шилжүүлсэн байхад хөрөнгийн үнэлгээний жагсаалтад оруулаагүй, хөрөнгө бүртгэх тухай тогтоолд тусгаагүй байх тул зөрчлийг арилгуулах албан шаардлагыг ЗТХЯ-нд өгсөн учир саналыг хүлээн авах боломжгүй гэж үзэн тайлангийн төсөлд өөрчлөлт оруулаагүй болно.
ҮАГ-ын тайлбар 12	Ирүүлсэн материалыг хянан үзэж дараах байдлаар засвар, өөрчлөлтийг орууллаа. • ТХН-ийн ерөнхий инженерийн хамаарал бүхий Вортекс ХХК нь 2015 оны 8 дугаар сард ерөнхий туслан гүйцэтгэгч Самсунг Си энд Ти ХХК-тай 2,051.7 сая төгрөгийн /үндсэн гэрээ, 2 нэмэлт гэрээний хамт/ үнийн дүн бүхий будгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 1,974.2 сая төгрөгийн санхүүжилт авсан.
ҮАГ-ын тайлбар 13	Тайлангийн 27 дугаар хуудасны 3.9 дэх хэсэгт дурдсан зөрчил нь нотлох баримтаар дэмжигдэж байгаа бөгөөд саналыг хүлээн авах боломжгүй байх тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулаагүй болно.
ҮАГ-ын тайлбар 14	Ирүүлсэн материалыг хянан үзэж дараах байдлаар засвар өөрчлөлтийг орууллаа. “Үерийн хамгаалалтын далангийн ажил”-ыг ЗТБХБЯ, “Боорчи” ХХК-тай 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр улсын төсийн хөрөнгө 2,800.0 сая төгрөгөөр гүйцэтгэх анхны гэрээг байгуулж, гэрээг 2 удаа /2013 он, 2014 он/ сунгаж, уг ажил 5 жил үргэлжилсэн ч “Боорчи” ХХК нь үерийн хамгаалалтын далангийн автозамтай огтлолцож байгаа намагтай хэсгийн 120 метр хэсгийн далангийн 149.3 сая, хөрс солих нэмэлт 72.3 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй, “Самсунг Си энд Ти” ХХК нь “Боорчи” ХХК-ийн гүйцэтгэх үерийн хамгаалалтын далангийн зүүн сувгийн ПК1+260-ПК1+500 хооронд намагтай хэсгийн болон хоолойн сувгийн ажлыг Магадализгүй ажил буюу Variation Orders /2016 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн/-д 14,557.4 иен буюу 264.4 сая төгрөгөөр гүйцэтгэн зээлийн хөрөнгөнөөс 42.8 сая төгрөгийг нэмж гаргасан байна.
ҮАГ-ын тайлбар 15	Саналыг хүлээн авах боломжгүй байх тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулаагүй болно.
ҮАГ-ын тайлбар 16	Саналыг хүлээн авч тайлангийн 3.88 дахь Наадмын нэхэмжлэлийн хэсгийг хасав.



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төслийн хүрээнд 2013-2018 онд УБ хотоос алслагдсан байршилд Олон Улсын Иргэний нисэхийн байгууллагын стандартад нийцсэн, жилд 3 сая орчим зорчигч хүлээн авах хүчин чадалтай, нийт 1,264.6 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй, 80 гаруй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, машин механизм, тоног төхөөрөмж бүхий ОУНОШБ-ыг дэд бүтцийн хамт цогцоор нь шийдсэн бүтээн байгуулалт хийгджээ.
2. Зээлдүүлэгчээс төслийн гүйцэтгэгчид санхүүжилт олгосон үйл явц Монгол Улсын валютын урсгал, нөөцийн тэнцвэртэй байдлыг хангахад гадаад зээлийн ашиглалтаар нөлөөлөх эерэг нөхцөлийг бүрдүүлээгүй байна.
3. ТХН өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлсэн, Сангийн яам, ЗТЯ /хуучин нэрээр/, ИНЕГ нь гэрээ байгуулах болон төслийн бүтээн байгуулалтын явцад хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний үр дүнг үнэлж дүгнээгүй зэргээс барилга байгууламжийн төсөвт өртөг өсөх, тоног төхөөрөмж, авто машин өндөр үнээр нийлүүлэгдэх, зориулалт бусаар ашиглах, хугацаа хоцорсны алданги, нэмэлт зардал гарсан нь төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, хариуцлагагүй байдалтай холбоотой байна.
4. Монгол Улсын Засгийн газар, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-тай байгуулсан “Улаанбаатар хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээнд тусгасан Монголын талын хүлээх үүргийн биелэлтээс шалтгаалж нисэх буудлын үйл ажиллагаа гэрээнд заасан хугацаанд эхлэхгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна.
5. Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг үнэлсэн компанийн үнэлгээний тайланд эмнэлгийн түргэн тусламжийн болон штаб командын автомашиныг давхардуулан бүртгэсэн, хэт богино долгионы станцыг үнэлгээнд бүртгээгүй байхад ИНЕГ хүлээн авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хөндлөнгийн үнэлгээ, хөрөнгийн жагсаалтыг хянахгүйгээр “Хөрөнгө бүртгэх тухай” тогтоол гаргасан нь үе шат бүрт хяналтгүй ажилласан байна.
6. Төслийн хэрэгцээ шаардлагыг цогцоор нь төлөвлөөгүй, төслийн төсөвт өртгийг үнэлж баталгаажуулаагүйгээс хэрэгжилтийн явцад анхны төлөвлөлтөөс өөрчлөлт орсон, зээлийн нөхцөл нь нэн хөнгөлөлттэй хэдий ч Засгийн газраас томилсон ажлын хэсэг болон холбогдох яамд төслийн хэрэгжилтэд тавих хяналтаа үр нөлөөтэй хэрэгжүүлж чадаагүйгээс зээлийн ашиглалт нэмэгдэж, төслийн үр өгөөж буурахад нөлөөлжээ.
7. Гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг оновчтой төлөвлөөгүй, өрийн удирдлага, түүнийг хэрэгжүүлэхэд тавих хяналт хангалтгүй, үр нөлөөг үнэлж дүгнээгүйгээс дээрх зөрчлүүд гарсан байна.



ЗӨВЛӨМЖ:

Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын Хороонд толилуулах нь:

- Хууль тогтоомжоор шалгуур болгосон төсвийн зарчим, өрийн тусгай шаардлагын зохицуулалтыг тогтвортой байлгаж, цаашид гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрийн зээлийн гэрээг иж бүрэн боловсруулсан эсэх, төсөв, мөнгөний бодлоготой уялдуулсан эсэхэд анхаарал хандуулахыг санал болгож байна.

Аудитын илрүүлэлт, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/-д:

- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн зээлийн гэрээнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэж, цаашид зээлийн гэрээнд шалгуур тогтоож, үр ашигтай байх нөхцөлийг бүрдүүлэх;
- Төслийн гэрээний хэлцэл, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн ашиглалт, үнэлгээ, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг зохистой хэрэгжүүлээгүй яам, агентлагийн албан тушаалтанд хариуцлага тооцох;
- ОУНОШБ-ын төслийн зээлийн гэрээний биелэлтийг үнэлж дүгнүүлэх талаар холбогдох сайд нарт чиглэл өгөх;

Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/-д:

- Гадаадын зээлээр хэрэгжих төсөл хөтөлбөр нь Өрийн удирдлагын тухай хуульд заасан холбогдох шалгуурыг хангасан эсэхэд тавих хяналтыг сайжруулж, төслийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм журам, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох,
- Хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрийн бодлого, зорилт, хэрэгжилт, үр дүнд тавих хяналт, түүний үр нөлөөг сайжруулах,
- Гадаадын зээл тусламжаар цаашид хэрэгжих төсөл хөтөлбөрийн зориулалтаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, талуудын хяналтыг сайжруулах;

Зам, тээврийн хөгжлийн сайд /Б.Энх-Амгалан/-д:


- Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг бодитой үнэлж, хүлээн авч, ашиглах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;
- Төслийн гэрээний хэлцэл, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн ашиглалт, үнэлгээ, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй нэгжийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга /З.Мэндсайхан/-д:

- Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн бүртгэлийн шийдвэрийг дахин хянаж, холбогдох алдааг залруулж, хариуцлага тооцож ажиллах;


Холбогдох газар, нэгжийн удирдлагад:

- Аудитын тайлантай нарийвчлан танилцаж, газар, нэгж, албан тушаалын чиг үүргийн дагуу өөрт олгогдсон эрх, үүргийн хүрээнд аудитын тайланд тусгасан зөрчлийг арилгаж шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.



Хавсралт 1

Байр зүйн зурагт дүрслэгдсэн газар зүйн нэр болон ОУНОБ-ын байршлын зураг





Хавсралт 2

Төслийн Удирдах хороо 2009-2018 оны хооронд хуралдсан хуралдааны судалгааны нэгтгэл

Үзүүлэлт	Хуралдааны тэмдэглэл		Төслийн удирах хороо нь улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдаж төслийн хэрэгжилтийн явцыг авч хэлэлцэх”	Тухайн жилд хуралдсан тоо	Журамд заасан нөхцөлийг хангаагүй тоо	Журмын хугацаа	
	огноо	дугаар					
Төслийн удирдах хорооны хурлын тэмдэглэл	2009.06.04	№01	4 буюу түүнээс дээш	2	2	Улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдана /2007 он 120-д /	
	2009.11.04	№2					
	2010.02.24	№03					
	2010.09.23	№04	4 буюу түүнээс дээш	2	2		
	2011.03.04	№05					
	2013.03.06	№1/2013				4 буюу түүнээс дээш	5
	2013.04.03	№2/2013					
	2013.05.29	байхгүй					
	2013.07.09	№3/2013					
	2013.11.13	№4/2013					
	2014.03.26	№1/2014	4 буюу түүнээс дээш	2	2	Улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдах /2011 оны 86-д/	
	2014.07.04	№2/2014					
	2015.04.15	№01					
	2015.07.08	№02	4 буюу түүнээс дээш	3	1		Улирал, хагас жил тутам хуралдана /2015 оны 196-д/
	2015.09.30	№01					
	2016.01.22	№01					
	2017.04.18	№01	4 буюу түүнээс дээш	1	3		
	2018.03.30	№01	4 буюу түүнээс дээш	2	2		
	2018.12.10	№02					
Нийт хурлын тоо			44	19	25		



Хавсралт 3

Улсын комиссын үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлийн нэгтгэл судалгаа

№	Хяналт шалгалтын хэсгийн нэр	Нийт илэрсэн зөрчил	Зөрчлийг арилгуулсан	Зураг төслийн дагуу хийж гүйцэтгээгүй дутуу болон чанаргүй ажил	Зураг төсөлд тусгаагдаагүй боловч зайлшгүй хийх шаардлагатай	Ашиглалтын үед хийж хэрэгжүүлэх шаардлагатай
1	Барилга архитектур, ерөнхий төлөөлөгөөний хяналт	66		44	19	3
2	Барилгын техник хяналт	90		67	16	7
3	Барилгын материалын хяналт	33		23	8	2
4	Дулаан хангамжийн хяналт	138		105	23	10
5	Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн хяналт	50		34	15	1
6	Цэвэр бохир усны гадна дотор шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, ус цэвэршүүлэх байгууламжийн хяналт	22		1	21	0
7	Мэдээлэл, харилцаа холбооны хяналт	39		16	21	4
8	Шатахуун хангамжийн байгууламжийн хяналт	95		67	16	12
9	Өргөх механизмын хяналт	77	61	14	2	0
10	Авто замын хяналт	17	0	11	6	0
11	Эрүүл ахуй халдвар хамгаалалт	27		14	11	3
12	Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналт	56		1	47	8
	Нийт зөрчлийн дүн	710		397	205	50
	Улсын комиссын дүгнэлтээр	689		526	114	49
	Зөрүү дүн	21	0	-129	91	1

Хавсралт4

Төслийн хүрээнд чөлөөлөгдсөн нийт татварын мэдээ

/сая төгрөг/

№	Татварын төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	Нийт дүн
1	Импортын барааны НӨАТ	378.4	3,208.1	11,455.7	11,747.3	2,921.9	130.3	3,367.0	33,208.7
2	Гаалийн албан татвар	179.9	1,527.7	5,419.1	5,077.6	1,191.3	62.1	1,603.3	15,061.0
3	Дотоодын зах зээлээс худалдан авсан бараа ажил үйлчилгээний НӨАТ	-	-	-	23,924.5	18,412.3	4,364.2	3,751.7	50,452.7
	Дүн	558.3	4,735.8	16,874.8	40,749.4	22,525.5	4,556.6	2,963.2	98,722.4



Хавсралт 5

ТӨБЗГ-ын тогтоол, зөвшөөрлөөр 2017-2019 онд эрх шилжсэн хөрөнгийн жагсаалт

/сая төгрөг/

№	Нэр төрөл	Улсын дугаар	Шилжүүлсэн үндэслэл	Үйлдвэрлэсэн он	Шилжүүлэн өгсөн эзэмшигч	Шилжүүлэн авсан эзэмшигч	Шилжүүлсэн хөрөнгийн балансын үнэ	Шилжүүлсэн хөрөнгийн үлдэх өртөг
1	Toyota Land 200	5698 УНУ	ТӨБЗГ-ын 2017 оны 244 дүгээр тогтоол	2013	Эс Си Ту Си Эм ХХК	МУ-ын Ерөнхий прокурорын газар	159.8	105.2
2	Toyota Land 200 GX	5615 УНУ		2013	Эс Си Ту Си Эм ХХК	Цагдаагийн ерөнхий газар	109.8	72.6
3	Toyota Land 200 GX	5606 УНУ		2013	Эс Си Ту Си Эм ХХК	Цагдаагийн ерөнхий газар	111.8	73.97
4	Toyota Land 70	5605 УНУ		2013	Эс Си Ту Си Эм ХХК	Эрүүл мэндийн яам	87.0	57.3
5	Toyota Land 76	5612 УНУ		2014	Эс Си Ту Си Эм ХХК	"Говь-Алтай" АЗЗА ТӨХК	97.9	69.5
6	Toyota Hiace	5601 УНУ	ТӨБЗГ-ын 2018 оны 294 дугаар тогтоол	2013	Эс Си Ту Си Эм ХХК	ЗТХЯ	56.8	22.4
7	Toyota Land 76	5611 УНУ		2014	Эс Си Ту Си Эм ХХК	"Хөвсгөл" АЗЗА ТӨХК	97.9	97.7
8	Toyota Hiace	5610 УНУ	ТӨБЗГ-ын 2019 оны 431 дугаар тогтоол	2014	Эс Си Ту Си Эм ХХК	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	67.9	19.2
9	Toyota Hiace	5610 УНУ	ТӨБЗГ-ын 2019 оны А-2/3305 дугаарт албан бичиг	2014	Эс Си Ту Си Эм ХХК	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	67.9	-
10	Toyota Hiace	5601 УНУ		2013	ЗТХЯ	Иргэний нисэхийн ерөнхий газар	56.8	22.2
11	Toyota Hiace	5616 УНУ		2015	Эс Си Ту Си Эм ХХК	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	67.2	-



Төслийн хэрэгжилтийн явц

